



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОН 04 ДҮГЭЭР САРЫН 28-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-34
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	35-109
<hr/>	
<i>1.“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	35-36
<i>2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	36-37
<i>3.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/</i>	37-78
<i>4.Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох</i>	79-109

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 28-ны өдөр /Баасан гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 50.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 08 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Анандбазар, Б.Баттөмөр, Б.Бейсен, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Ч.Ундрал, Д.Цогтбаатар, Л.Энх-Амгалан, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батиугар, Л.Оюун-Эрдэнэ, Н.Учрал;

Эмнэлгийн чөлөөтэй: Б.Саранчимэг, Ц.Сэргэлэн;

Тасалсан: Э.Бат-Амгалан;

Хоцорсон: С.Амарсайхан-2 цаг 58 минут, С.Батболд-1 цаг 39 минут, Д.Ганбат-1 цаг 08 минут, Ц.Даваасүрэн-45 минут, Д.Сарангэрэл-50 минут, Ж.Чинбүрэн-55 минут.

Нэг. “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Г.Занданшатар: “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30

Татгалзсан: 13

Бүгд: 43

69.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./10:12/

Уг асуудлыг 10 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын дарга З.Энхболд, мөн яамны Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтсийн дарга Г.Гийхнаран, Төрийн худалдан авах ажиллагааны газрын дарга Ц.Батзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, мөн хэлтсийн Төсвийн байнгын хариуцсан референт Г.Нарантуяа нар байлцав.

Уг асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт буцаах талаар горимын санал гаргав.

Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг анхны хэлэлцүүлэгт дахин хэлэлцүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлэв./10:17/

Гурав.Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Цогтгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын ахлах

шинжээч Н.Жамьянхүү, “Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв” Төрийн бус байгууллагын хуульч, судлаач Р.Лхагвабаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн гишүүн Б.Пүрэвдорж Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийн асуудлаар Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс авсан завсарлага дууссаныг мэдэгдэв./10:18/

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Ш.Адъяаа, Х.Булгантуяа, Т.Доржханд, М.Оюунчимэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон” гэснийг “аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 21
Бүгд: 46
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль тогтоомжоос” гэснийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.

3.2.Тусгай хамгаалалтай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагааг энэ хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “нэг хоногоос” гэснийг, 4.1.4 дэх заалтын “2, түүнээс дээш” гэснийг, 4.1.6 дахь заалтын “жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан,” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 20

Бүгд: 46

56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын гадаргуу дээрх” гэснийг “үйл ажиллагаанд ашиглах” гэж өөрчилж, “археологи” гэсний өмнө “палеонтологи” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31

Татгалзсан: 15

Бүгд: 46

67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.10.“аялал жуулчлалын дэд бүтэц” гэж нисэх буудал, зам, тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэврийн байгууламж, улсын, олон улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, харилцаа, холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28

Татгалзсан: 18

Бүгд: 46

60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2.“жуулчин” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүнийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29

Татгалзсан: 17

Бүгд: 46

63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5.“аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага” гэж байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 31
Татгалзсан: 15
Бүгд: 46
67.4 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7.“аяллын агент” гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулж байгаа хуулийн этгээдийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9.“тусгай сонирхлын аялал жуулчлал” гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалыг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 17
Бүгд: 46
63.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.12.“нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал” гэж тухайн орон нутгийн иргэд, нөхөрлөл жуулчинд энэ хуулийн 11.1-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.13. “отоглох цэг” гэж аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацад нийцүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд зориулагдсан, өөрийн стандарт бүхий, жуулчинд зориулсан түр байрлах үйлчилгээний цогц орчныг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 18
Бүгд: 46
60.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь” гэснийг “үйлдвэрлэл нь” гэж, мөн зүйлийн 5.2.3 дахь заалтын “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэж, 5.3.3 дахь заалтын “урлаг, үзвэр үйлчилгээ” гэснийг “спортын арга хэмжээ, үзмэр болон урлаг” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн “энэ хуулийн 5.2, 5.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ” гэснийг “аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн энэ хуулийн 5.2, 5.3-т заасан үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 22
Бүгд: 46
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтын “худалдаа” гэсний өмнө “жуулчинд зориулсан гар урлалын болон бусад” гэж нэмж, төслийн 5.3.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 21
Бүгд: 46
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “6.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “6.2.1, 6.2.2-т зааснаас бусад байгууллага эрсдэл бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх” гэж, 6.9 дэх хэсгийн “соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлийн” гэснийг “соёлын биет өвийн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 22
Бүгд: 46
52.2 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдан борлуулах, аялал зохион байгуулах,” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 21
Бүгд: 46
54.3 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.аялал жуулчлалын мэдээллийн санд үйл ажиллагааныхаа статистик мэдээллийг маягтын дагуу тогтоосон хугацаанд ирүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 20
Бүгд: 46
56.5 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.7.бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагынхаа үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг цахим орчинд бүрдүүлсэн байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 19
Бүгд: 46
58.7 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “түүх,” гэснийг “хууль тогтоомж, түүх, соёл,” гэж, 7.2.6 дахь заалтын “хэлбэрийг хөгжүүлэх”

гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 30
Татгалзсан: 16
Бүгд: 46
65.2 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 29
Татгалзсан: 16
Бүгд: 45
64.4 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэснийг “болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 18
Бүгд: 45
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, мөн зүйлийн 9.2.2, 9.2.4, 9.2.5 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 17
Бүгд: 45
62.2 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал

11.1.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд жуулчинд зориулсан дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ хамаарна:

11.1.1.нүүдэлчдийн соёл, ахуй, зан заншлыг танилцуулан сурталчлах;
11.1.2.зочны гэрээр үйлчлэх;
11.1.3.ердийн хөсгөөр үйлчлэх;
11.1.4.энэ хуулийн 5.3-т заасан аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх.

11.2.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

11.3.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 17.16-д заасан бүсийн төлөвлөлтийг баримтална.

11.4.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг эрхлэгч нь эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 19
Бүгд: 45
57.8 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тур операторын бүртгэл

12.1.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур операторыг дараах ангиллаар бүртгэнэ:

12.1.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.1.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;
12.1.3.энэ хуулийн 12.1.1 болон 12.1.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.1.4.дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.2. Тур оператораар бүртгүүлэхдээ дараах мэдээллийг ирүүлнэ:

- 12.2.1. аялал жуулчлалын мэргэжлийн ажилтны мэдээлэл;
- 12.2.2. бүтээгдэхүүн, үйлчилгээний таарх мэдээлэл;
- 12.2.3. цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон талаарх мэдээлэл;
- 12.2.4. хариуцлагын даатгалд хамрагдсан талаарх мэдээлэл.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 25
Бүгд: 45
44.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн 26
Татгалзсан 19
Бүгд 45
57.8 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гаргасан дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 20
Бүгд: 45
55.6 хувийн саналаар дэмжигдлээ.

30. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрт” гэсний дараа “энэ хуулийн 13.1-д заасан гадаадын иргэн” гэж нэмж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “12.2.2-т заасан үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй” гэснийг “12.1.2, 12.1.3-т заасан ангиллаар бүртгүүлсэн” гэж, 13.6 дахь хэсгийн “энэ зүйлд заасны дагуу хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч буй гадаадын жуулчны мэдээллийг” гэснийг “хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч байгаа жуулчны тоон мэдээллийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

31. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл. Даатгал

15.1. Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2. Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялал зэрэг хүний амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна.

15.3. Энэ хуулийн 15.2-т заасан жуулчныг уг даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.4. Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Ш.Раднаасэд нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

32. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аялж байгаа жуулчинд шаардагдах аюулгүй байдлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг “жуулчны аюулгүй байдлыг” гэж, 16.5 дахь хэсгийн “тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчдад мэдэгдэх” гэснийг “аялал жуулчлалын байгууллага, жуулчинд мэдээлэх бөгөөд өөрийн албан ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 16.4, 16.7 дахь хэсгийн “бүхий л” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

33. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.6, 16.8 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 20
Бүгд: 43
53.5 хувийн саналаар дэмжигдлээ.

34. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 21
Бүгд: 43
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

35.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 19
Бүгд: 41
53.7 хувийн саналаар дэмжигдлээ.

36.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17 дугаар зүйл. Аялал жуулчлалын бүс

17.1.Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.

17.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

- 17.2.1.улсын аялал жуулчлалын бүс;
- 17.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.

17.3.Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газраас тогтоож, хилийн заагийг батална.

17.4.Улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтооход газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг авна.

17.5.Улсын аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн менежментийн төлөвлөгөөтэй байна.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан менежментийн төлөвлөгөө, бүсийн аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17.7.Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулна.

17.8.Энэ хуулийн 17.7-д заасан хилийн заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд болон энэ хуулийн 30.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

17.9.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

17.10.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 17.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.

17.11.Энэ хуулийн 17.9-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

17.12.Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

17.13.Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

17.14.Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтоохдоо улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагтай давхцуулж тогтоохыг хориглоно.

17.15.Улсын аялал жуулчлалын бүстэй орон нутгийн аялал жуулчлалын бүс давхацсан тохиолдолд тухайн хэсгийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүчингүй болгоно.

17.16.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Б.Энхбаяр, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

37.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийг 18 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

18 дугаар зүйл.Отоглох цэг

18.1.Улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацыг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага отоглох цэг байгуулах байршлыг тогтооно.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газар нутагт отоглох цэгийг улсын төсвийн, тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны болон олон улсын төслийн хөрөнгө оруулалтаар байгуулна.

18.3.Энэ хуулийн 18.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн менежментийг тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа хэрэгжүүлэх бөгөөд менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

18.4.Энэ хуулийн 18.1-д заасан улсын аялал жуулчлалын бүс нь улсын тусгай хамгаалалттай газартай давхцаагүй тохиолдолд тухайн аялал жуулчлалын бүс дэх отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээд, орон нутгийн иргэнээр гүйцэтгүүлж болно.

18.5.Энэ хуулийн 18.4-т заасан отоглох цэгийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх этгээдийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулна.

18.6.Энэ хуулийн 18.1-д заасан улсын тусгай хамгаалалттай газарт отоглох цэгийн үйлчилгээний хураамж авах, зарцуулахтай холбогдсон харилцааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.

18.7.Отоглох цэг нь байнгын, эсхүл түр байж болох бөгөөд стандартын шаардлага хангасан байна.

18.8.Отоглох цэгт олон нийтийн аюулгүй байдлыг хангах харилцааг Цагдаагийн албаны тухай хуулиар зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

38.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 18
Татгалзсан: 21
Бүгд: 39
46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

39.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “БАЙГУУЛЛАГА, АШГИЙН ТӨЛӨӨ БУС” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

40.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.6, 21.5,” гэж, 21.2.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа

“болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал гаргах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 16
Татгалзсан: 24
Бүгд: 40
40.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

41.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.6.аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

42.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

43.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 болон 21.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд байгаль орчин, аялал жуулчлал, төсөв, санхүү, эдийн засаг, тээвэр, эрчим хүч, гадаад харилцаа, хууль зүй, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон таван гишүүнээс бүрдэнэ.

21.4.Үндэсний хороо орон тооны бус байх бөгөөд гишүүдийг Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

44.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3, 21.4, 21.5 дахь хэсгийг 20 дугаар зүйл болгон зүйлийн нэрийг “20 дугаар зүйл.Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэн эрх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 18
Бүгд: 41
56.1 хувийн саналаар дэмжигдлээ.

45.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“22.1.13.аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

46.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “6.6, 10.3, 11.3-г” гэснийг “10.3, 15.4-г” гэж, 22.1.5 дахь заалтын “жуулчны үйлчилгээний байгууллагын” гэснийг “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн” гэж, 22.1.7 дахь заалтын “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэснийг “үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “бий болгоход дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

47.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 22.1.9 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх” гэж, 22.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 28
Татгалзсан: 13
Бүгд: 41
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

48.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

49.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж” гэснийг, 24.1.5 дахь заалтын “эрх хэмжээнийхээ хүрээнд” гэснийг, 24.1.7 дахь заалтын “наадам, бусад” гэснийг тус тус хасаж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын “тухайн жилийн” гэснийг “өмнөх оны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 13
Бүгд: 38
65.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 11 цаг 42 минутаас хуралдааныг даргалав.

Л.Мөнхбаатар: 50.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “харьяалах” гэсний өмнө “шаардлагатай тохиолдолд” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

51.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, 24.1.11 дэх заалт, мөн зүйлийн 24.2 дахь хэсэг болон “Тайлбар” хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 15
Бүгд: 37
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

52.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.15.харьяалах нутаг дэвсгэртээ улсын болон олон улсын чанартай авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, жуулчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

53.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.16.аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан аймаг, нийслэлд аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан ажиллуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 11
Бүгд: 38
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

54.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3, 25.1.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 12
Бүгд: 38
68.4 хувийн саналаар дэмжигдлээ.

55.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалт, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 11
Бүгд: 38
71.1 хувийн саналаар дэмжигдлээ.

56.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байршлыг баримтлан хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Х.Ганхуяг нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

57.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд” гэснийг “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд” гэж, 26.1.7 дахь заалтын “отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох,” гэснийг “аяллын маршрутын дагуу” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар дэмжигдлээ.

58.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийг “ТАВДУГААР БҮЛЭГ.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” гэсэн гарчиг бүхий Тавдугаар бүлгийн 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах,

боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий ашгийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “холбоо” гэх/ байна.

26.2.Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбооны дүрмээр зохицуулна.

26.3.Холбоо нь аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болно.

26.4.Холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аудитлагдсан санхүүгийн тайлангаа харилцагч санхүүгийн байгууллагад, татварын тайлангаа харьяалах татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж, олон нийтэд нээлттэй мэдээлнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Бат-Эрдэнэ, Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Г.Ганболд нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

59.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 27 дугаар зүйл нэмэх:

“27 дугаар зүйл.Холбооны их хурал

27.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны их хурал /цаашид “их хурал” гэх/ байна.

27.2.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулна.

27.3.Их хурлын төлөөлөгчдийн олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

27.4.Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмыг холбооны дүрмээр тогтооно.

27.5.Их хурлын төлөөлөгчид нь холбооны гишүүнчлэлтэй аялал жуулчлалын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

27.6.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.6.1.холбооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

27.6.2.аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

27.6.3.холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх.

27.6.4.холбооны Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, санал, зөвлөмж өгөх;

27.6.5.хууль болон холбооны дүрмээр тогтоосон бусад асуудал.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, С.Бямбацогт, Ж.Бат-Эрдэнэ, Х.Ганхуяг, Ц.Цэрэнпунцаг, Ж.Батжаргал нар үг хэлэв.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

60.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 28 дугаар зүйл нэмэх:

“28 дугаар зүйл.Холбооны Удирдах зөвлөл

28.1.Холбооны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь Их хурлын чөлөөт цагт холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

28.2.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.2.1.холбооны гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх;

28.2.2.холбооны дүрэм, журмын хэрэгжилт, жилийн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

28.2.3.холбооны их хурлыг зарлан хуралдуулах;

28.2.4.холбооны жилийн төсөв, ажлын төлөвлөгөөг батлах, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

28.2.5.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

28.3.Удирдах зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тур оператороос 5, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч компани болон аялал жуулчлалын үйлчилгээний бусад байгууллагаас тус бүр 2 төлөөллөөс бүрдэнэ.

28.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд улируулан сонгохгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

61.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 29 дүгээр зүйл нэмэх:

“29 дүгээр зүйл.Холбооны гүйцэтгэх удирдлага

29.1.Холбооны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд улируулан сонгохгүй.

29.2.Холбооны гүйцэтгэх удирдлага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.2.1.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

29.2.2.холбооны үйл ажиллагааг удирдан явуулах;

29.2.3.холбооны төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;

29.2.4.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргах, эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

29.2.5.Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

29.2.6.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

29.3.Холбооны гүйцэтгэх удирдлага нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнд ажиллана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

62.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн Тавдугаар бүлгийн гарчгийг “ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 23
Бүгд: 40
42.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 21
Татгалзсан 20
Бүгд 41
51.2 хувийн саналаар **горимын** санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 20
Бүгд: 41
51.2 хувийн саналаар дэмжигдлээ.

63.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийг Зургаадугаар бүлгийн 30 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэдээллийн сан

30.1.Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Аялал жуулчлалын мэдээллийн сан” гэх/-г аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

30.2.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

30.2.1.хууль тогтоомжийн болон салбарын хүний нөөцийн мэдээлэл;
30.2.2.дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээлэл;
30.2.3.аялал жуулчлалын байгууллагын бүртгэл, мэдээлэл;
30.2.4.улсын, орон нутгийн, хил орчмын аялал жуулчлалын бүс, маршрутын мэдээлэл;

30.2.5.олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламжийн мэдээлэл;

30.2.6.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан отоглох цэгийн мэдээлэл;

30.2.7.энэ хуулийн 16.5-д заасан жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын талаарх мэдээлэл.

30.3.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

64.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

65.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 29.2, 29.3, 29.6 дахь хэсгийг 32 дугаар зүйл болгож, зүйлийн гарчгийг “32 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

66.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“33.1.1.аялал жуулчлалын хууль тогтоомжийг зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21

Бүгд: 40

47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн	21
Татгалзсан	19
Бүгд	40

52.5 хувийн саналаар горимын санал дэмжиглээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан дээрх санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	21
Татгалзсан:	19
Бүгд:	40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

67. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35 дугаар зүйл. Шилжилтийн үеийн зохицуулалт

35.1. Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

35.2. Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

35.3. Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 35.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.

35.4. Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур оператор, аяллын агент нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлнэ” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

68. Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	18
Бүгд:	40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

69.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “хөтөч” гэснийг “хөтөч-тайлбарлагч” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

70.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, эшлэлийн дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21

Татгалзсан: 19

Бүгд: 40

52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр. Найруулгын санал:

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “үндэсний онцлог бүхий байгаль” гэснийг “байгаль, үндэсний онцлог бүхий” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “худалдах,” гэснийг “худалдан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “энгэрийн тэмдэг, үнэмлэхийг” гэснийг “үнэмлэх, энгэрийн тэмдэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын, мөн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “төрийн” гэснийг “төрөөс баримтлах” гэж, 21.1.5 дахь заалтын “харилцааг” гэснийг “харьцааг” гэж, “23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “газар нутгийнхаа” гэснийг “нутаг дэвсгэрийнхээ” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “бодлого, зорилтот хөтөлбөрийн” гэснийг “бодлогын” гэж, 24.1.14 дэх заалтын “жуулчин, аялагчийн” гэснийг “жуулчны” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эрх,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “аялагч болон” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “, аялагч” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “ажлыг хөгжүүлэх” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тухай” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “зохион байгуулах” гэсний өмнө “аялал” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “борлуулах” гэсний өмнө “худалдан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “асуудлаар” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

1.Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Анужины “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн П.Анужины гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн 21
Татгалзсан 19
Бүгд 40
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн гаргасан дээрх санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 19
Бүгд: 39
51.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “374 дүгээр зүйлийн” гэсний дараа “374.1,” гэж, мөн зүйлийн “373.4 дэх хэсгийн “аялал жуулчлал” гэсний дараа “зохион байгуулагч” гэж, “372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг,” гэсний өмнө “372 дугаар зүйлийн 372.2 дахь хэсгийн “Аялал зохион байгуулагч” гэснийг “Тур оператор, аяллын агент” гэж,” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт.” гэснийг “22 дугаар зүйлийн 22.5.12 дахь заалт.” гэж, мөн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн дугаарыг “22 дугаар зүйлийн 22.5.13 дахь заалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “22.9-д” гэснийг “22.5.13-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1. Тур оператор, эсхүл аяллын агентын үйл ажиллагааг эрхлэхдээ хуульд заасан бүртгэл хийлгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Хуралдаан даргалагчаас дээрх саналыг гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

5.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн “нэг хоногоос” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь хэсгийн дугаарыг “15 дугаар зүйлийн 15.17, 15.18, 15.19 дэх хэсэг” болгож, мөн зүйлийн 2 дахь заалтын 15.16 дахь хэсгийн, 15.17 дахь хэсгийн, 15.18 дахь хэсгийн “15.5¹ гэснийг “15.6” гэж, 15.18 дахь хэсгийн “15.16.4-т” гэснийг “15.17.4-т” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн “15.5” гэсний дараа “, 15.6” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “эрхэлдэг” гэсний дараа “хуулийн этгээд” гэж, “өөрчилсүгэй.” гэсний өмнө “, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн “15.6-д” гэснийг “15.7, 15.18-д” гэж, мөн зүйлийн 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15 дахь хэсгийн дугаарыг “15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15, 15.16” гэж тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

“1/13 дугаар зүйлийн 13.5.21, 13.5.22, 13.5.23 дахь заалт:

13.5.21.орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээ;
13.5.22.олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;
13.5.23.иргэний агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ.” гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Бямбацогт, Ш.Адъяа, Ш.Раднаасэд, Г.Ганболд, С.Одонтуяа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 33
Бүгд: 40
17.5 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

6.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид нь буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн үг хэлэв.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 29
Бүгд: 38
23.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.1.12 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 17
Бүгд: 38
55.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.13 дахь заалтын “отоглох цэгээр” гэсний өмнө “улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах” гэж нэмж, заалтын дугаарыг “29.1.12” болгож өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “29.1.13,” гэснийг “29.1.12,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “29.1.1-29.1.12 дахь заалт” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.11 дэх заалт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 15
Бүгд: 38
60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Нэг.Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал:

Л.Мөнхбаатар: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан газарт Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 18
Бүгд: 38
52.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

3/36¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэхгүй байж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 16
Бүгд: 38
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4/36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах зарыг уг ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар болон өдөр тутмын хэвлэлээр нийтэд мэдээлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	16
Бүгд:	38

57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг хасах гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	23
Татгалзсан:	15
Бүгд:	38

60.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтын дугаарыг “3, 4” гэж өөрчилсүгэй.” гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Зөвшөөрсөн:	24
Татгалзсан:	14
Бүгд:	38

63.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай хуулиудын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулиудын эцсийн найруулгатай танилцлаа./13:22/

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 15 минут үргэлжилж, 13 цаг 23 минутад завсарлав.

Үдээс хойших чуулганы нэгдсэн хуралдааныг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар удирдаж, 14 цаг 07 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Ж.Лхагвасүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг нар байлцав.

Асуулгын хариуг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Асуулгын хариулттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Ж.Батжаргал, Б.Энх-Амгалан, С.Бямбацогт, Х.Ганхуяг, О.Цогтгэрэл, А.Адьяасүрэн, Н.Наранбаатар, Т.Доржханд, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Э.Түвшинчулуун **нар** хариулж, тайлбар хийв.

Асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг үг хэлэв.

Нэгдсэн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаас “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын талаар” Эрчим хүчний сайдад тавьсан асуулгын хариуг сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Д.Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр, Дэнж, Шанд, Даваат багийн залуучуудын төлөөлөл, “Эрүүл Монгол” Үндэсний чуулганд оролцсон Баянхонгор, Ховд аймгийн сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, эмч нар Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 10 минут үргэлжилж, 73 гишүүнээс 52 гишүүн хүрэлцэн ирж, 71.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 08 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Өдрийн амгаланг айлтгая. Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 28-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай тогтоолыг хэлэлцье.

Хоёрдугаарт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Зарчмын зөрүүтэй 30 саналтай.

Гуравдугаарт, Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ. Зарчмын зөрүүтэй 96 саналтай.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно. Хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг танилцуулна.

Улсын Их Хурлын тогтоол,
“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяаг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Эдийн засгийн байнгын хорооны, Дамдинсүрэнгийн Өнөрболорыг Улсын Их Хурлын Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын гишүүн Хүрэлбаатарын Булгантуяаг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны, Дамдинсүрэнгийн Өнөрболорыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны, Жаргалтулгын Эрдэнэбатыг Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

Энэ тогтоолыг 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

“Зарим Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Хүрэлбаатар гишүүн, Жавхлан сайд нар суудалдаа сууж саналаа өгнө үү. Санал хураалт.

69.8 хувийн саналаар санал дэмжигдэж, тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолыг уншиж танилцуулсан. Эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Хөөе Агар-Эрдэнээ тогтоол батлагдсан өдрөөсөө эхэлж дагаж мөрдөж байгаа биз? Чи үүн дээр тайлбараа өгнө шүү чи. Зарим тогтоолыг чи тэгж саатуулснаа. Дараагийн асуудалд оръё.

10.12 цаг.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлж явуулна.

Ажлын хэсгийн гишүүдийг оруулна. Энэ 30 саналаа явуулчихаад горимын саналдах юм уу? Шууд горимын санал гаргах юм уу? Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Өглөөний мэнд хүргэе. Өчигдөр Тендерийн хуулийн анхны хэлэлцүүлгийг хийсэн. Хэлэлцүүлгийн үеэр 4, 5 гишүүнээс тухайлбал, Раднаасэд гишүүн, Чинзориг гишүүн, Батлут гишүүн, Чинбүрэн гишүүн гээд 4, 5 гишүүнээс энэ Тендерийн хуульд хамгийн бага үнийн санал буюу хэмнэлттэй байх зарчим эмийн асуудал дээр энэ байж боломгүй байна. Ганбаа гишүүнээ.

Энэ зарчмаар явж болохгүй байна. Эмийн асуудал бол ард иргэдийн эрүүл мэнд, амь насны цаашилаад үндэсний аюулгүй байдлын асуудал юм. Тийм учраас эм дээр бол хямд үнэ биш, чанартай нэг номерт чанарын асуудал яригдах ёстой. Тийм учраас энэ хуульдаа эм, эмийн хэрэгсэл дээр энэ зарчмыг оруулж өгөөч гээд. Энэ асуудлаар ажлын хэсэг дээр огт санал яригдаагүй учраас өнөөдөр бас гүйцээн боловсруулах чиглэл авч болохгүй байгаа юм.

Тийм учраа бас ажлын хэсэг бас энэ 4, 5 гишүүнээс гарсан энэ саналуудыг ярилцаад бас хүлээж авах нь зүйтэй гэж үзээд Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг рүү буцаагаад, энэ саналуудыг томъёолж оруулж ирээд ингээд ахиж хэлэлцье гэсэн ийм дэгийн тухай хуулийн 48.1-ийг барьж ийм горимын санал гаргаж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Бямбацогт гишүүн адилхан санал гарах юм уу? Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Би бас энэ Сандаг-Очир гишүүний гаргаж байгаа горимын саналыг дэмжиж байгаа юм. Өчигдөр Замчдын зөвлөгөөн болсон. 500 гаруй замчид оролцсон. Энэ дээр бас үндэсний компаниуд тодорхой асуудлууд ярьж байгаа юм. Энэ тендерт орохдоо хэт бага үнэ өгдөг, хэт бага үнээр тендерт орж зам, барилгын ажил авчхаад ажлаа хийхгүй, түүнээс болоод цаг хугацаа алддаг, чанаргүй зам баригддаг ийм асуудлууд байна. Тэгэхээр хэт бага үнэ өгч ялдаг. Тэгж түүнийхээ дараа үнээ өсгүүлдэг энэ байдлыг бас таслан зогсоох асуудлыг бас оруулж өгөөч гэсэн санал байгаа.

Тийм болохоор бас анхны хэлэлцүүлэг дээр энэ асуудлыг ярих ёстой юм шиг байгаа юм.

Хоёрдугаарт нь бас үндэсний компаниудаа дэмжсэн бодлого явуулна гэж бид байнга ярьж байгаа. Энэ үндэсний компаниудыг дэмжсэн бодлого явуулахдаа бид нар бас юу гэдэг юм гаднын компаниудтай тэгш өрсөлдөх бололцоо боломжийг бий болгосон зохицуулалт энэ хуульд яваад байгаа юм.

Тийм болохоор аль болох юу гэдэг юм, үндэсний компаниуд дэмжсэн бодлогыг бас хуульд тусгах ийм асуудлыг бас ярилцах шаардлагатай байгаа юм.

Тийм болохоор Сандаг-Очир гишүүний гаргаж байгаа горимын саналыг дэмжээд бас анхны хэлэлцүүлэг дээр бас эдгээр асуудлыг тусгах тал дээр анхаарч өгөөч гэсэн горимын санал гаргаж байгаа юм.

Г.Занданшатар: Одоо болно болно. Санал хураалт явуулъя. Ингээд санал хураалт явуулна. Энэ эмийн асуудал ярьж байгаа юм. Байнгын хороон дээрээ ярь тэр. Ингээд Цэндийн Сандаг-Очир гишүүний гаргасан горимын саналаар Дэгийн тухай хуулийн 43.1-т заасны дагуу анхны хэлэлцүүлэгт нь буцаах горимын саналаар санал хураалт явуулъя. Эмийн асуудал, эмийн асуудал, эмийн.

67.4 хувийн саналаар Цэндийн Сандаг-Очир гишүүний гаргасан горимын санал дэмжигдлээ. Энийг Төсвийн байнгын хороонд анхны хэлэлцүүлэгт буцаалаа. Анхны хэлэлцүүлгээ ахиж сайн хийнэ. Дараагийн асуудалд орно.

10.17 цаг.

Гурав. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Өчигдөр 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр завсарлагын хугацаа дууссан. Ажлын хэсгийн гишүүдийг оруулъя. Цогтгэрэл дарга үг хэлэх юм уу? Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Завсарлага авснаар үг хэл. Юмаа арай мэдэж байгаа байх. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Өчигдөр завсарлага авсан үндсэн шалтгаан ер нь өнгөрсөн хугацаанд энэ нөхөрлөлөөр дамжуулаад нийтдээ 150 гаруй аж ахуйн нэгж байгаа. Дээрээс нь 50 гаруй нөхөрлөл байгаа. Энэ нөхөрлөл, аж ахуйн нэгжээр дамжуулаад энэ агнангаа хамгаалъя гэдэг энэ зарчмын дагуу амьтныг хамгаалж, өөрөөр хэлбэл өвс тэжээл тавих, зудтай үед нь хариулах иймэрхүү байдлаар энэ

хамгаалж байгаа энэ тогтолцоог бас тодорхой хэмжээгээр өөрчлөх ийм магадлал энэ хууль дээр орж ирсэн байсныг нь анхны хэлэлцүүлэг дээр бас, эцсийн хэлэлцүүлэг дээр тодорхой шийдэл гаргаад энийгээ оруулсан юм байна. Энийг бас энэ завсарлага авах хугацаанд бас тодорхой ойлголтуудыг авлаа. Мөн түүнчлэн жишээ нь аргал, угалз энэ тэр бол, тэх бол жишээ нь буудаад, агнаад ингээд цаашаа явдаг.

Гэтэл тул байна. Агнадаггүй, тэр барьдаг. Тэгээд барьчхаад 1 минут 30 секундийн дотор буцаагаад тавьдаг. Тэгээд дээрээс нь энэ агнуур дээр ямар байр суурьтай байх юм. Мөн түүнчлэн нуур, цөөрөм дээр загас үржүүлэх, тэр загас үржүүлсэн загасаа тодорхой хэмжээгээр арчлан хамгаалах, түүнийгээ бас ашиглангаа хамгаалах энэ зарчим дээр ямар байр суурьтай байх юм гэдэг асуудлуудаар нэлээн ярилцлаа.

Тэгэхээр одоо хамгийн гол нь Занданшатар дарга энэ эцсийн хэлэлцүүлэг дээр ялангуяа энэ загас агнуур, энэний хийж байгаа энэ ажлын хүрээнд бас тодорхой энэ аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар загас агнуурыг агнангаа хамгаалах, үржүүлэнгээ хамгаалах энэ тогтолцоог бас энэ хуульд оруулах талаар бас чиглэл өгөх талаар анхаарна уу. Тэгээд завсарлагын хугацаа дууссаныг мэдэгдье. Мөн Цогтгэрэл дарга нэмж үг хэлнэ.

Г.Занданшатар: Энэ нэмэлт гэж байхгүй л дээ. Тэгээд ер нь цаашидаа бас ингээд Пүрэвдорж гишүүн би Ардчилсан намын бүлгийн даргыг төлөөлөх эрх, үүрэгтэй хүн гээд байгааг. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан байгаа. Одоо Байнгын хорооны зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 96 санал байгаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Сангийн сайд Болдын Жавхлан. Зоригтбаатар Энхболд энэ чинь

төрийн ба орон нутгийн өмч сая хойшилдог байна.

Ажлын хэсэг Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сүхбаатарын Цогтгэрэл Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Нармандахын Жамъянхүү. Жамъянхүү алга байна. Хууль зүй, дотоод хэргийн яам. Ренчинпүрэвийн Лхагвабаяр Монголын эрх зүйн судалгаа хөгжлийн төв Төрийн бус байгууллагын хуульч, судлаач.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна. Зарчмын зөрүүтэй 96 санал байгаа. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаарх зарчмын зөрүүтэй санал.

Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “аялал жуулчлалын үйлдвэрлэлээр эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, дэмжихтэй холбогдсон болон” гэснийг “аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх,” гэж өөрчлөх санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Ширнэнбандийн Адьяа, Хүрэлбаатарын Булгантуяа, Тогмидын Доржханд, Мөнхөөгийн Оюунчимэг. Цаашид ажлын хэсэг гэнэ. Санал хураалт.

Гомпилдоогийнн Мөнхцэцэг, Бямбасүрэнгийн Энх-Амгалан 2 суудалдаа сууя, саналаа өгье.

25 гишүүн дэмжиж, 54.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль тогтоомжоос” гэснийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль

тогтоомжийн бусад актаас” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

67.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ренчинпүрэвийн Жамъянхүү бос, чи яагаад хоцроод байгаа юм? Нармандахын Жамъянхүү юм байна. Ренчинпүрэвийн Лхагвабаяр энэ хууль сайн бичиж сураарай. Энэ ёстой бөөн будилаан хутгасан юмнууд хийж.

3.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.Энэ хуулиар Монгол Улсын нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулна.

3.2.Тусгай хамгаалалтай газар нутаг дахь аялал жуулчлалын үйл ажиллагааг энэ хууль болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: 3.1 дэх заалтыг нь дэмжиж байгаа юм. 3.2 дахь заалтыг дэмжихгүй байгаа юм. Энэ анх орж ирэхдээ бүүр балай орж ирсэн юм. Харин зассан байгаа юм. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тухайлан зааснаас бусад аялал жуулчлалыг энэ хуулиар зохицуулна гээд. Тэгээд Монгол ийм аялал жуулчлалын 2 хуультай болчихоод байгаа байхгүй юу. Нийт ер нь зүгээр би буруу тоо хэлж байж магадгүй. Нийт аялал жуулчлалын чинь бараг 50 хувь нь тусгай хамгаалалттай газар дээр байгаа шүү дээ аялал жуулчлалын баазууд чинь.

Гэтэл энэ нь өөр хуулиар явчхаж байгаа байхгүй юу. Тэгээд энэ иргэдэд

асар их хүндрэл учруулдаг байхгүй юу. Бид нөгөө аялал жуулчлалаа хөгжүүлбэ гэж ярьчихаад тусгай хамгаалалттай газрынхаа асуудлаа өөр хуулиар зохицуулна гэж авч үлдээд, тэгээд тэр гэрээ байгуулах, зөвшөөрөл өгөх юм нь бол энэ хуулиар биш Тусгай хамгаалалттай хуулиараа гээд ингээд балай болоод явчих гээд байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр уул нь энэ Тусгай хамгаалалттай хуулийг нь энэнтэй нь хамт явах ёстой байхгүй юу Ганхуягаа. Хамт явж тэр үнэхээр аялал жуулчлалаа хөгжүүлбэ гэж байгаа бол тэр Тусгай хамгаалалтынхаа хуульд байгаа тэр аялал жуулчлалын заалтуудаа цэгцлэх ёстой байхгүй юу. Тэгээд та нар хулгайгаар шахуу нэг хууль оруулж ирчихээд Бат-Эрдэнэ, хөөе Бат-Эрдэнэ та нар хулгайгаар шахуу хууль оруулж ирж байдаг шүү. Өмнө нь энэ Тусгай хамгаалалттай хууль хулгайгаар явсан хууль байхгүй юу.

Одоо ахиад л энэ хуулийг ерөөсөө оруулж ирдэггүй . Энэ хуулийг. Бид бүх газрыг дуудлага худалдаагаар өгнө л гэж яриад байгаа. Тусгай хамгаалалттай газар дээр шууд олгоод байгаа. Одоо энэ аялал жуулчлал дээр яах вэ гэхээр бид аялал жуулчлалыг одоо ингээд нээлттэй болгоод, тусгай хамгаалалттай бусад газрууд зүгээр явна. Тусгай хамгаалалт дээр очих дээр зэрэг нь зөвшөөрөл авна гээд суучихна. Ингээд явдаггүй байхгүй юу. Морь хөтөлдөг хүмүүс хүртэл явдаггүй байхгүй юу.

Ингээд бид нар нээх гоё аялал жуулчлалын хууль батлаад гаргана, маргааш нь Тусгай хамгаалалттай хуулиар нь энэ нь өөрчлөгдөөгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр би юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр энэ 3.2 дээр энэ тусгай хамгаалалттай гэдэг энэ хуулийг эсвэл дараагийн хэлэлцүүлэг дээр оруулж ирж ярих ёстой байхгүй юу. Нийт аялал жуулчлал эрхэлж байгаа жуулчны баазын чинь 50 гаруй хувь нь тусгай

хамгаалалттай цэг дээр байгаа шүү, бүс дээр байгаа шүү. Бараг 100 хувь байгаа. Тэгээд очих дээр нь зэрэг өнөө муу хэд хэдэн зөвшөөрлийг нь өгөхгүй. Гэр баазад нь зөвшөөрлийг нь өгөхгүй, морь хөтөлдөгт нь зөвшөөрлийг нь өгөхгүй. Ер нь тусгай хамгаалалттай бүс дээр нэг аюул үүсээд байгаа байхгүй юу. Бид нар тусгай хамгаалалттай бүсээ өртгөнө, 50 хувьд хүргэнэ гээд л яриад байгаа юм. 30-50 хувьд.

Гэтэл хэрэг дээрээ тухайн нутагт амьдарч байгаа иргэдийн хувьд бол хохирол амсаж байдаг байхгүй юу байнга. Өвөлжөө, хаваржаагаа зарим нь барих эрх байхгүй. Бүүр тэр байтугай түлээний модоо ашиглах эрх байхгүй шүү дээ. Өөр бүсэд очно шүү дээ. Тийм. Тийм учраас энэ ашиглан хамгаалах гэдэг зөрчлийг яваад, хамгаалах гэдэг нэрийн дор өөр нэг хэдэн хүний хамгаалалтад өгөөд, тэр нь магадгүй бүүр зориудаар буруу ашигладаг байхгүй юу. Нутгийн иргэдээсээ илүү буруу ашигладаг байхгүй юу.

Тийм учраас бол бид нар Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуулийн тэр аялал жуулчлалын асуудлыг энэтэй хамтатгаж уул нь явах ёстой байхгүй юу. Тэгж яваагүйгээс болоод наадах чинь яг гараад хэрэгжихээр асуудал үүснэ шүү. Тэгээд аялал жуулчлалын 2 хуультай болоод байна шүү дээ энэ чинь. Үүгээр бол бараг жижигхэн юм зохицуулагдана. Хэдэн тур оператор гэсэн юм чинь зохицуулагдана. Яг нөгөө аялал жуулчлал явуулах гээд байгаа газар нь тусгай хамгаалалттай гээд л өөр болчихно шүү. Тийм учраас энэ асуудлыг би ажлын хэсэг дахиж авч үзэх ёстой шүү гэдгийг би хэлье гэж бодож байна.

Г.Занданшатар: Энэ заалтыг гүйцээж боловсруулах чиглэл өгнө. Ер нь тэр Зөвшөөрлийн тухай хуулийг дагаж мөрдөх 98 хууль оруулж ирэхдээ Тусгай хамгаалалтын зөвшөөрөл олгох хуулийг өргөдлөөр оруулж ирнэ гээд ингээд тухайн үед хэлээд байхад Газрын хуулийг

энэ Энхбаяр гишүүн бас хэлж л байсан тэгээд гаргачихсан шүү дээ. Одоо энэ Зайсангийн газрыг бол аялал жуулчлалын зориулалтаар гэж өгөөд л одоо өнөөдөр ямар болчихсон байна хар. Тэгээд энэ тусгай хамгаалалтын газар нутгуудын яг үнэндээ цаана нь газрын зөвшөөрлийн асуудал болоод явчхаад байгаа юм. Энийг гүйцээж боловсруулах чиглэл өгье. Дараагийн асуудал руу оръё 4. 96 саналтай.

4.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “нэг хоногоос” гэснийг, 4.1.4 дэх заалтын “2, түүнээс дээш” гэснийг, 4.1.6 дахь заалтын “жижиглэн, эсхүл хоёр, түүнээс дээш бүтээгдэхүүн, үйлчилгээг багцлан,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ одоо ингэхээр чинь морь унуулдаг хүн байдаг шүү дээ. Тэр энэ тэрийг бодвол 2 бүтээгдэхүүн үйлчилгээг багцална энэ тэр гэхгүй бол дан дангаараа болчих юм бол энэ чинь ингээд аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болчихоор болох юм уу? Тэгээд бүтээгдэхүүн үйлчилгээгээ 4.1.1-ээ янзалчихвал. Санал хураалт.

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “бүтээгдэхүүн, үйлчилгээг эрхлэхэд шаардагдах газрын гадаргуу дээрх” гэснийг “үйл ажиллагаанд ашиглах” гэж өөрчилж, “археологи” гэсний өмнө “палеонтологи” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

67.4 хувийн саналаар санал дэмжлээ.

6.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.10 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.10. “аялал жуулчлалын дэд бүтэц” гэж нисэх буудал, зам, тээвэр, эрчим хүч, ус хангамж, ариун цэврийн байгууламж, улсын, олон улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламж, тэмдэг тэмдэглэгээ, харилцаа, холбоо, мэдээлэл технологийн цахим дэд бүтцийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.2. “жуулчин” гэж энэ хуулийн 4.1.1-д заасан аялал жуулчлалын үйл ажиллагаанд хамрагдаж байгаа хүнийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Морь унуулж байгаа малчин бол жуулчин болох юм байна. Жолоонд нь явж байгаа жолооч жуулчин болох юм байна. Энийгээ үйлчилгээнд хамрагдаж байгаа хүнийг, үйлчлүүлж байгаа хүнийг ингэж найруулга энэ тэрийг нь засахгүй бол тануусын бичиг энэ тэр МОНЦАМЭ-гийн модон хэлнээс долоон доор хэл болоод явчих юм.

8.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.5. “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага” гэж байр сууц, тээвэр, хоол үйлдвэрлэл, үзмэр, үзвэр үйлчилгээ, жуулчны мэдээллийн төв зэрэг жуулчинд зориулсан үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Жуулчинд зориулж тэр аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийг л жуулчны байгууллага гээд товчхон л заачихмаар байна. Жуулчнаа

тодорхойлчихсон. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ гэдгээ тодорхойлчихсон. Тэгээд жуулчинд аялал жуулчлалын бүтээгдэхүүн, багц үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээдийг л аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага гэж байгаа юм байна. Тэгээд л одоо энд би хэлсэн шүү дээ. Урлаг, уран сайхан юу ч байдаг юм, бусад юм бүгд хамаарагдах бүгдийг нь тоочих гээд байгаа байхгүй юу. Тоочихоор л ингээд хууль дээр хийдэл, зөрчил гардаг.

Тэгээд эцсийн хэлэлцүүлэгтээ анхаарна биз. Найруулгаар засахгүй бол нэг шинэ үйлчилгээ гараад ирлээ тэр энэ дотор орохгүй нь гээд л. Одоо жишээлбэл энтертайнмент, аялал жуулчлалын энтертайнмент болон бусад янз янзын юм орж бодно шүү дээ. Тэр битгий хэл казино, морин бооцоот таавар гээд л яриад байгаа биз дээ. Тэд нар чинь одоо орохгүй болох нь байна шүү дээ энэ чинь.

9.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.7. “аяллын агент” гэж тур оператор болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучлан борлуулж байгаа хуулийн этгээдийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Та хэд тэр Солонгосын аялал жуулчлалын туризмын тухай хуулийг үзээрэй. Ингээд энтертайнмент туризм, байгаль, түүхийн туризм энэ тэр гэж ялгаад, тэгээд бүтээгдэхүүн үйлчилгээгээ аягүй оновчтой тодорхойлчихсон байгаа.

10.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.9. “тусгай сонирхлын аялал жуулчлал” гэж тусгай мэргэжлийн ур чадвар, техник хэрэгсэл шаардсан аялал жуулчлалыг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

63 хувийн саналаар санал дэмжигдлээ. Одоо Өвөр Монголд энэ говийн элсэн дээрх авто ралли уралдаан гэж маш том туризмын 20 сая жуулчин ирдэг тийм арга хэмжээ болдог юм байна лээ. Тэгээд энэ хил дамнасан аялал жуулчлал билүү тэр энэ тэрийг чинь хөгжүүлэе л гээд байдаг юм.

11.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Дотоодын жуулчин, гадаадын жуулчин хоёулаа ормоор байна. Дотоод аялал жуулчлал хөгжиж байж гадаад аялал жуулчлал хөгждөг юм байна лээ уул нь.

12.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.12. “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал” гэж тухайн орон нутгийн иргэд, нөхөрлөл жуулчинд энэ хуулийн 11.1-д заасан бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэхийг;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“4.1.13. “отоглох цэг” гэж аялал жуулчлалын эрэлт, байгаль орчны даацад нийцүүлэн хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд зориулагдсан, өөрийн стандарт бүхий, жуулчинд зориулсан түр байрлах үйлчилгээний цогц орчныг;”.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, тэдгээрийг хэрэглэгчдэд хүргэх үйлдвэрлэл, үйл ажиллагаа нь” гэснийг “үйлдвэрлэл нь” гэж, мөн зүйлийн 5.2.3 дахь заалтын “бүтээгдэхүүн” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээ” гэж, 5.3.3 дахь заалтын “урлаг, үзвэр үйлчилгээ” гэснийг “спортын арга хэмжээ, үзмэр болон урлаг” гэж, мөн зүйлийн 5.4 дэх хэсгийн “энэ хуулийн 5.2, 5.3-т заасан аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн үйлчилгээ” гэснийг—“аялал жуулчлалын байгууллагын гадаадын жуулчинд үзүүлсэн энэ хуулийн 5.2, 5.3-т заасан үйлчилгээ” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэр hiking уулын, мөсний, агаарын, цасны энэ тэр чинь бүгд аялал жуулчлалын бүтээгдэхүүнд орж болно шүү дээ.

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15. Төслийн 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх заалтын “худалдаа” гэсний өмнө “жуулчинд зориулсан гар урлалын болон бусад” гэж нэмж, төслийн 5.3.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тийм. 56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

16.Төслийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Монгол Улсын иргэн эрхэлж болно гэснийг л хасаж байгаа юм байна.

54.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

17.Төслийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн “6.2-т заасан ангилалд тусгагдаагүй байгууллага тусгай сонирхлын болон бусад төрлийн эрсдэл бүхий аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх” гэснийг “6.2.1, 6.2.2-т зааснаас бусад байгууллага эрсдэл бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх” гэж, 6.9 дэх хэсгийн “соёлын биет өв буюу түүх, соёлын үл хөдлөх болон хөдлөх дурсгалт зүйлийн” гэснийг “соёлын биет өвийн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэгээд болно гэж санцгуй юм хийж байгаа байхгүй юу.

52.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Аяллын агент нь иргэн байж болно л гэсэн санаа юм байна л даа. Хуулийн этгээд биш.

18.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.1.1.аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төлөвлөн бүрдүүлж, шууд, эсхүл аяллын агентаар дамжуулан худалдан борлуулах, аялал зохион байгуулах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

54.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

19.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.2.аялал жуулчлалын мэдээллийн санд үйл ажиллагааныхаа статистик мэдээллийг маягтын дагуу тогтоосон хугацаанд ирүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

20.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“7.2.7.бүтээгдэхүүн, үйлчилгээ болон байгууллагынхаа үйл ажиллагааны талаар мэдээлэл авах боломжийг цахим орчинд бүрдүүлсэн байх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

58.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

21.Төслийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтын “түүх,” гэснийг “хууль тогтоомж, түүх, соёл,” гэж, 7.2.6 дахь заалтын “хэлбэрийг хөгжүүлэх” гэснийг “бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

22.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

64.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

23.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтын “бүтээгдэхүүнийг” гэснийг “болон аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

24.Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, мөн зүйлийн 8.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Цаашаагаа явъя. Энэ тэгэхдээ энэ аяллын агентын үүргийг нь хасаад хаячихлаа л даа. Энэ тур оператортай адилхан үүргийг хүлээж байсныг хасчихлаа.

25.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, мөн зүйлийн 9.2.2, 9.2.4, 9.2.5 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

62.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Аубакир гишүүн анхааралтай оролцоорой. Аубакир гишүүн яриад байхгүй шүү. Анхааралтай оролцоорой. Энэ Баян-Өлгий аймагт аялал жуулчлал хөгжүүлэх асуудлыг тэр байгалийн тусгай хамгаалалттай газарт чинь аялал жуулчлал эрхлэх асуудлыг яриад байхад та. Дараа нь тэгээд би юу хийчхэв гээд байдаг шүү та.

26.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “Хөтөч” гэсний өмнө “Аялал жуулчлалын мэргэжилтэй, эсхүл” гэж, мөн зүйлийн 10.2.2 дахь заалтын “үндэсний” гэсний өмнө “хууль тогтоомж,” гэж, 10.3 дахь хэсгийн “журмыг” гэсний өмнө, 10.4 дэх хэсгийн “чиг үүргийг” гэсний өмнө “болон мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтоох” гэж тус тус нэмж, мөн 10.4 дэх заалтын “журмын дагуу” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт явахгүй шүү. Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ. Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ.

Н.Энхболд: Энэ дээр нэг ийм юмыг бас анхаармаар байна гэж бодоод байгаа юм. Чимээгүй байж байгаарай дарга аа. Энэ хөтөч, тайлбарлагч хийх хүн заавал бүртгүүлж, үнэмлэх авсан байна. Тэгж байж жуулчны хөтчийн үйлчилгээ үзүүлнэ гээд байгаа байхгүй юу. Гэтэл жуулчны баазууд дээр жишээ нь өөрийнх нь чиглэлийн юмыг маш сайн мэддэг түүхч, судлаач, биологич хүмүүс байна.

Жишээ нь Хустай дээр гэхэд. Ямар ч хөтөч, ямар ч жсуулчны ажилтнаас илүү бүх юм мэддэг докторын зэргийг хамгаалчихсан ийм хүмүүс хөтөч хийгээд тайлбарлаад явдаг байхгүй юу.

Тэгэхээр тэр хүмүүс дахиж заавал сургалтад хамруулж үнэмлэх авсан байх шаардлага байна уу, үгүй юү? Байхгүй гэж би бодож байгаа. Тэгэхээр энийг бас нэг бодмоор, дараагийн хэлэлцүүлэг дээр Ганхуяг гишүүнээ. Энэ хөтөч, тайлбарлагч заавал бүртгүүлээд тэгээд үнэмлэх авна гэж байгаа байхгүй юу. Тэгтэл жсуулчны бааз өөрийнх нь би Хустайгаар жишээ аваад ярья. Манай биологичид байна. Тэр тахийг чинь унаганаас нь үхтэл нь ингээд хараад явж байдаг. Хаана яадаг бүгдийг нь мэднэ. Тэр хүмүүс бас тэр мэддэг юмаа хүнд ярьж өгөхийн тулд заавал үнэмлэх авах хэрэг гарах гээд байна л даа.

Тийм учраас энэ дээр эс үгүй бол тэд нарыг нэмж өгөх хэрэгтэй. Эс үгүй бол арай тодруулаад яг тухайн жсуулчны сонирхож байгаа сэдвээр мэргэшигчсэн, мэргэжлийн хүмүүс энэ тэр бол яагаад хөтөч хийж болохгүй гэж жишээ нь. Ингээд энэ дээр дараагийн хэлэлцүүлэг дээр бодож үзэх хэрэгтэй юм байна лээ шүү.

Г.Занданшатар: Энийг Ганхуяг гишүүнээ гүйцээн боловсруулах чиглэл өгчихье тэгэх үү. Тэгэхгүй бол энэ морь, тэмээ унуулж байгаа хүн нь тэр 10.4 дээр мэргэжлийн ур чадвар тогтоох гээд мэргэжлийн ур чадварын зэрэглэл тогтооно гэж байна л даа. Хэн тогтоох юм тэр зэрэглэлийг нь. Тэгээд нөгөө морь, тэмээ унуулж байгаа чинь нэг малчин л хүн байж таарна. Тэрэнд үнэмлэх олгоод. Энийг гүйцээж боловсруулах хэрэгтэй.

Тийм. Тэгээд хөтөч чинь усан спорт, уулын аялал, морь, тэмээ унуулах аялал жуулчлалын үйлчилгээнд чинь аялал жуулчлалын мэргэжилтэй болгоод, тэгээд мэргэжлийн ур чадвар, зэрэглэл

тогтоогоод ингээд явна гэвэл энэ бас хэцүү болох байх. Тэгээд энийг яг амьдрал дээр сайн судалж үзээд гүйцээн боловсруулах хэрэгтэй гэж бодож байна.

27.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

28.Төслийн 11 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11 дүгээр зүйл.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал

11.1.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалд жуулчинд зориулсан дараах бүтээгдэхүүн, үйлчилгээ хамаарна:

11.1.1.нүүдэлчдийн соёл, ахуй, зан заншлыг танилцуулан сурталчлах;

11.1.2.зочны гэрээр үйлчлэх;

11.1.3.ердийн хөсгөөр үйлчлэх;

11.1.4.энэ хуулийн 5.3-т заасан аялал жуулчлалын дагалдах бүтээгдэхүүн, үйлчилгээ үзүүлэх.

11.2.Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

11.3.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэхэд энэ хуулийн 17.16-д заасан бүсийн төлөвлөлтийг баримтална.

11.4.Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг эрхлэгч нь эрх бүхий байгууллагаас баталсан техникийн зохицуулалт, стандартыг үйл

ажиллагаандаа мөрдөнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

29.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“12 дугаар зүйл.Тур операторын бүртгэл

12.1.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур операторыг дараах ангиллаар бүртгэнэ:

12.1.1.Монгол Улсаас бусад улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;

12.1.2.бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлалын үйлчилгээ;

12.1.3.энэ хуулийн 12.1.1 болон 12.1.2-т заасан аялал жуулчлалын үйлчилгээг хамтад нь эрхлэх олон улсын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.1.4.дотоодын аялал жуулчлалын үйлчилгээ.

12.2.Тур оператораар бүртгүүлэхдээ дараах мэдээллийг ирүүлнэ:

12.2.1.аялал жуулчлалын мэргэжлийн ажилтны мэдээлэл;

12.2.2.бүтээгдэхүүн, үйлчилгээний таарх мэдээлэл;

12.2.3.цахим төлбөрийн баримтын систем, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд холбогдсон талаарх мэдээлэл;

12.2.4.хариуцлагын даатгалд хамрагдсан талаарх мэдээлэл.” Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хуучин түр операторын тусгай зөвшөөрөл гэж

байсан. Тэгэхээр энэ Зөвшөөрлийн тухай хуулиар энэ тусгай зөвшөөрөл бол байхгүй болсон байгаа. Тэгэхээр ямар ч байсан нэг юм аваад үлдэх бас санаатай л байгаа юм байна л даа. Тэгээд түүнийгээ Аялал жуулчлалын холбоон дээрээ үлдээх юм байна. Тийм, уул нь бол ингээд хууль бол их сайн гардаг л даа. Яах вэ ингээд сайн үзсээр байгаад гардаг.

Гэтэл яг хэрэгжих шатдаа энийг чинь ашиглаад бас нөгөө нэг тусгай зөвшөөрлийн хэмжээнд аваачаад юм хумыг нь зовлонтой болгоод ингээд орхичих юм биш байгаа. Тийм учраас энэ дээр бас яг энэ тусгай зөвшөөрлийн хэмжээнд байхгүйгээр бүртгээд л явуулах тэр зохицуулалтыг нь сайн хийж өгөхгүй бол бас болохгүй. Тэгэхгүй бол энэ чинь бүртгэнэ гэгчээд л тэгээд бүртгэхгүй, танайхыг бүртгэхгүй гэдэг ийм байдлаар хандаад явчих юм бол бас зовлонтой шүү дээ. Тийм учраас энэ дээр бас яг тусгай зөвшөөрөл биш учраас. Тусгай зөвшөөрөл чинь жишээ нь 21 хоногийн дотор зөвшөөрлөө буцааж өгөхгүй бол тэр байгууллага шууд үйл ажиллагаагаа явуулаад явчих боломжтой байхгүй юу.

Гэтэл энэ бүртгэнэ гэх дээр бүртгэж байгаа юмаа шийдэхгүй удаад байх юм бол нөгөө аж ахуйн нэгж байгууллага чинь үйл ажиллагаа явуулж чадахгүй ийм болчих гээд байгаа байхгүй юу. Тийм учраас энэ дээр бас яг тэр тусгай зөвшөөрөл дээр тавьдаг шаардлагуудыг бас тодорхой хугацаатай болгох, заавал бүртгэх тэр заалтуудыг оруулах нь зүйтэй л гэж үзэж байна.

Г.Занданшатар: Энэ Пүрэвдорж гишүүн энэ чинь байна шүү дээ нийтийн эрх зүй этгээдээр бүртгүүлэх тухай байхгүй юу Улсын бүртгэлийн газарт. Тэр чинь нөгөө журмаараа тусдаа Зөвшөөрлийн хууль энэ тэрээр хугацаатай шүү дээ. Үгүй ээ 6.5-ыг нь унш. Наадах чинь 6.5-д заасны дагуу бүртгүүлэх гэж байгаа юм. 6.5-д нь

нийтийн эрх зүй этгээдээр бүртгүүлэх гэж байгаа юм.

6.5-д нь тур оператор аяллын агент нь энэ хуулийн 27.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна гэж байгаа юм. Тэгээд 6.5-аараа 5-ын дагуу бүртгүүлэхдээ дараах ангиллаар бүртгүүлнэ гэж ангиллыг нь л зааж өгч байгаа юм. Ангиллыг нь зааж өгч байгаа юм байна лээ. Тэгэхдээ энэ хуулиа их муу боловсруулсан чинь байна шүү дээ. Энэ Жамъянхүү энэ тэр анхаар. Энэ дээр хуулийн этгээд бүртгүүлнэ гэхээд түрүүн Монгол Улсын иргэн болно гээд тэгчихсэн байсан шүү дээ. Энэ 2 чинь зөрчилдөж байгаа учраас хассан нь зөв л юм байна л даа.

Санал хураалт явуулъя. Адьшаа гишүүн, Пүрэвдорж гишүүн л санал гаргахгүй бол энэ эсрэг санал өгсөн хүмүүс Б.Энхбаяр. Тийм үү? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Би сая, миний өгсөн санал эсрэг гарчихсан байна. Тийм учраас дахин санал хураалт явуулах ийм саналтай байна. Гишүүдэд хэлэхэд энэ заалтыг дэмжихгүй бол Тусгай зөвшөөрлийн заалт үлдчихэж байгаа байхгүй юу. Тийм, тийм учраас энэ заалтыг дэмжих хэрэгтэй шүү гэдгээ хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Тэгээд 6.5 дээрээ ч гэсэн найруулгын засвар хиймээр юм байна лээ шүү. Тэр хуулийн этгээдээр бүртгүүлэх юм уу, хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна гээд биччихсэн байхгүй юу. Хуулийн этгээдэд бүртгүүлсэн байна гэдэг чинь. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүний гаргасан горимын саналаар санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Хуулийн этгээдэд бүртгүүлэх юм уу? 57.8.

Одоо 30 дээр явж байна. 3-ны 1 дээр нь явж байна. Санал хураалтыг хүчингүйд тооцсон учраас саяын 29 дэх санал хураалтыг дахиж явуулъя.

55.6 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэгээд энийг эцсийн хэлэлцүүлэг дээр найруулгаар хэн бүртгэх юм гэдгээ бас тодорхой жоохон болгомоор юм байна. Тэгэхгүй ингээд бүртгэнэ гэхээд хэн, яаж бүртгэх гэдэг нь тодорхойгүй юм шиг харагдаад байна. Тэр 6.5-д заасны дагуу гэж байгаа болохоос биш, заасан этгээд гээгүй.

30.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “нутаг дэвсгэрт” гэсний дараа “энэ хуулийн 13.1-д заасан гадаадын иргэн” гэж нэмж, мөн зүйлийн 13.3 дахь хэсгийн “12.2.2-т заасан үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй” гэснийг “12.1.2, 12.1.3-т заасан ангиллаар бүртгүүлсэн” гэж, 13.6 дахь хэсгийн “энэ зүйлд заасны дагуу хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч буй гадаадын жуулчны мэдээллийг” гэснийг “хил орчмын аялал жуулчлалын үйлчилгээ авч байгаа жуулчны тоон мэдээллийг” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дэмжээгүй бол балрах байсан байна шүү.

31.Төслийн 15 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15 дугаар зүйл.Даатгал

15.1.Тур оператор, аяллын агент нь үйл ажиллагаандаа алдаа гаргасны улмаас үйлчлүүлэгчид учруулсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор хариуцлагын даатгалд заавал даатгуулна.

15.2.Өндөр уулын авиралт, спорт агнуур, олзворын ан, усны гүнд шумбах, авто спорт, нисдэг тэрэгний аялал зэрэг

хүний амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэл бүхий аялалд оролцох жуулчин, жуулчны хөтөч-тайлбарлагч, мэргэшсэн сургагч багш, зааварлагч нь гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна.

15.3.Энэ хуулийн 15.2-т заасан жуулчныг уг даатгалд хамруулах үйл ажиллагааг аялал жуулчлалын байгууллага хариуцан зохион байгуулна.

15.4.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан даатгалын эрсдэл, нөхцөл, үнэлгээ, хураамжийн хэмжээг тогтоох, хяналт тавих журмыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санхүүгийн зохицуулах хороотой хамтран батална. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Нямаагийн Энхболд гишүүн, Шатарбалын Раднаасэд гишүүн нар үг хэлнэ. Нямаагийн Энхболд гишүүн. Энэ алх цохиогүй байхад яагаад санал хураалт явуулаад байна?

Н.Энхболд: Энэ үгээр нь заавал оруулах хэрэг байна уу, үгүй юү? Хүний амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэл бүхий гэдэг дээр. Зүгээр эрсдэл бүхий гээд л яачихвал зүгээр юм болов уу? Эд нарыг заавал тэгж энэ загас олзвор бол амь насанд аюултай шүү гэж зарлаж байгаа юм шиг юм болчих гээд байх юм. Үүнийг бас хэлэлцүүлэг дээрээ дахиад нэг харвал. Найруулга талаас нь эрсдэлтэйд тооцогддог ч гэдэг юм уу тийм үгээр хийхгүй бол энэ жоохон эд нарыгаа бүүр албан ёсоор эрсдэлтэй шүү гэж хуулиар заагдаж байгаа юм шиг жоохон тийм санагдаж байна даа.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ аялагч бүрээ даатгах юм уу? Энэ аяллын байгууллага нь өөрөө хариуцлагын даатгал төлөх ёстой юм уу? Энэ дээр яахгүй бол нисдэг тэрэг, одоо энэ урд ууланд гулгадаг “Скай

Ресорт”-д гулгаж байгаа хүмүүс чинь хүртэл даатгуулсан байх ёстой гэдэг юм яригдах гээд байх шиг байна.

Хоёрдугаарт түрүүн тэр 13 дугаар зүйл дээр нэг юм хил орчмын аялал жуулчлал дээр анхаарахгүй бол болохгүй. Энэ хууль дээр 24 цагийн виз олгоно гээд ингээд гарсан юм. Гадаадын иргэн харьяатын эрх зүйн байдлын тухай хуулиар, виз олгох журмаар нь 24 цагийн виз гэж. Энэ бол бүхэл тухайн аймгийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь ингээд бичээд хаячихсан байна. Энэ чинь хилийн баганын наад талд гарч зургаа авхуулаад л цаашаа орох. Ялангуяа энэ урд Хятадын талаас бол жуулчин богино хугацаанд оруулж ирж зураг хөргийг нь авхуулаад л гаргах хоног хүрэхгүй хугацаан дотор л аялал жуулчлал явуулах гээд байгаа шүү дээ. Тэгээд энийг нь ингээд бүхэл бүтэн аймгийнх нь нутаг дэвсгэрийг хамруулахаар хийчихсэн байна.

Хоёрдугаарт энэ дээр тусгай зөвшөөрөл заавал авна гээд байх юм. Тэгээд орж ирж байгаа нь, оруулж ирж байгаа нь хоёулаа ингээд тусгай зөвшөөрөл авдаг, Хил хамгаалах газар, энэ Байгаль орчны яамны Аялал жуулчлалын газар нь өөрсдөө хамтраад журам гаргаад хийчхэж болохгүй байсан уу? Бүгдийг нь тусгай зөвшөөрөлтэй болгоод хаячихаар энэ чинь тэгээд зөвшөөрөл байхгүй танай хүмүүсийг оруулахгүй гэдэг юм болно. Энэ чинь Монголд л хэдэн төгрөгийг нь авч үлдэх л зорилго байгаа шүү дээ. Үгүй, тусгай зөвшөөрөлтэй тур оператор эрхэлнэ гээд байж байна шүү дээ. Наадах чинь 13.3 дээр чинь. Тийм, тэгэхээр заавал энэ чинь тусгай зөвшөөрөл шаардаад байгаа байхгүй юу.

Г.Занданшатар: Ганхуяг гишүүн зөвлөгөөнөө дууссан уу? Санал хураах уу? Энэ Нямаагийн Энхболд гишүүний хэлсэн санал дээр ингэж хуульд тоочихоор л дандаа эрсдэл, хийдэл, зөрчил гардаг байхгүй юу. Тэгээд ингэж тийм тийм амь

насанд халтай, тийм тийм спорт гэхгүй. Өндөр эрсдэлтэй аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ бол гэнэтийн ослын болон амь насны тэр даатгалын төрлөөрөө даатгуулаад байгаа шүү дээ. Тэр даатгалтай байна гэсэн агуулгаар урьдчилан найруулах. Тэр тусгай зөвшөөрөлтэй. 12.2-т заасан тусгай зөвшөөрөлтэй гэж байна шүү. 12.2.2 чинь бусад улсаас Монгол Улс руу хийх аялал жуулчлал бүгд хамаарч байгаа байхгүй юу.

Тэгээд тэр маршрутын дагуу тусгай зөвшөөрөлтэй байх болчихоод байна тиймээ? Хэний, тэгээд тэр чинь хил дамнасан эдийн засгийн чөлөөт бүсийн хууль, гэрээнд ч билүү тийм 24 цагийн юм энэ тэр гээд орчихсон. Тэгээд тэр энэ тэрийг, Раднаасэд гишүүний тэр юмыг анхаараад энийгээ гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Энэ хууль нь тэгээд Цагдаагийн газар хангана, тэр хангана ерөнхий бөгөөд орон нутгийн удирдлагын байгууллагууд дэмжиж ажиллана. Яаж дэмжиж ажиллах юм, яаж аюулгүй байдлыг хангах юм энэ тэр ийм тунхаглалын шинж чанартай заалтууд, санкцгүй ийм заалтууд чинь ямар ч үйлчлэхгүй шүү дээ. Эднүүсийгээ л сайн.

33.Төслийн 16 дугаар зүйлийн 16.6, 16.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

31-ийг гүйцээж боловсруулахад чиглэл өгчихсөн.

32.Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “аялж байгаа жуулчинд шаардагдах аюулгүй байдлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага,” гэснийг “жуулчны аюулгүй байдлыг” гэж, 16.5 дахь хэсгийн “тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчдад мэдэгдэх” гэснийг “аялал жуулчлалын байгууллага,

жуулчинд мэдээлэх бөгөөд өөрийн албан ёсны цахим хуудсанд тухай бүр байршуулах” гэж өөрчилж, мөн зүйлийн 16.4, 16.7 дахь хэсгийн “бүхий л” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ. Аюулгүй байдлыг яам хариуцна гэж байгаа юм.

Н.Энхболд: Тэрийг хасаж байгаа юм дарга. Яамыг нь хасчхаж байгаа юм байна лээ.

Г.Занданшатар: Хасчхаж байгаа юм байна лээ.

Н.Энхболд: Тэгээд энэ дээр зүгээр ийм юм байвал жишээ нь аялал чинь янз бүрийн хэсгүүдээс бүрддэг шүү дээ. Замдаа явах хэсэг байна, жуулчны баазад үзүүлж байгаа хэсэг нь байна. Бааз дээр байгаа хэсгийг нь бол тэд нар нь хариуцна, замдаа явж байгааг нь операторууд нь хариуцна гэдэг ч юм уу. Тэгэхээр энэ дээр тэр урд талыг нь хасах нь зүйтэй. Төрийн захиргааны төв байгууллага ийшээ орж ирж хэрэггүй. Цагдаагийн байгууллага, тэгээд аяллын тодорхой хэсгийг гэдэг юм уу, бүлгийг хариуцаж байгаа жуулчлалын байгууллага гээд жоохон заагаад өгчихгүй бол жишээ нь нэг жуулчны бааз руу явж байтал тэр хүргэж яваа операторууд нь замдаа асуудалд орвол, тэгээд очих гэж байгаа бааз нь ч бас юу яачих гээд байгаа юм уу тийм ээ ийм ойлгомжгүй байдал үүсчих бий.

Тэгэхээр санаа бол яг л аялал чинь тодорхой ийм бүлгүүдтэй байгаа. Замдаа явж байхдаа хэний, бааз дээрээ байгаа хэн нь гэдгийг нь ойлгуулахын тулд тэр хэсгийг нь зааж өгөөд холбогдох гэж хэлчихвэл илүү ойлгомжтой болох юм болов уу. Энэ болохоор зүгээр л ерөнхий юм болчихоод байна нэгдүгээрт.

Хоёрдугаарт ингэсэн байна шүү. 16.4 16.7 дээр бүхий л гэж үг байхгүй.

Бүхий л гэж байхгүй. 16.5 16.8 дээр байгаа шүү. Буруу биччихсэн юм болов уу айн? 4 дээр миний энэ дээр алга л байна даа.

Г.Занданшатар: 16.7-д байгаа.

Н.Энхболд: 16.5 дээр анхан шатын тусламж үзүүлэх бүхий л нөхцөл боломжийг хангасан гэсэн. Бүгдийг нь хангах боломж байхгүй. Тэгэхээр энийг хасах нь зүйтэй гэхдээ би зүгээр тоо нь өөр байна шүү л гэж хэлье. Тэрийгээ анзаараарай гэж хэлээд байгаа юм.

Г.Занданшатар: Энэ хууль бичихдээ яам тэр Баян-Өлгийн Өлгий сумд явж байгаа жуулчны аюулгүй байдлыг Байгаль орчны яам яаж хангана гэж бодож бичсэн юм.

Н.Энхболд: Хасаж байгаа, хассан юм дарга.

Г.Занданшатар: Хасъя гэдэг. Төсөл дээрээ тэгж бичиж орж ирсэн байхгүй юу. Цагдаагийн байгууллага нь, аюулгүй байдал гэдэг чинь маш өргөн ойлголт. Цаг агаар, өвчин зовлон, осол аваар. Тэгээд энийг яам, цагдаагийн байгууллага яаж ингэж хангах юм. Ийм тунхаглалын шинж чанартай ийм санкцгүй заалтууд чинь. Тэр жуулчны байгууллага нь өөрөө л хариуцна биз. Энийг тэгээд ингэж л өөрчилж байгаа л юм байна л даа. Тэгээд бүхий л нөхцөл боломжийг хангана гэж 16.4.7-д байгаа юм. 4.7 хоёрт бол. Тийм бүхий л гэдгийг хасаж байгаа. Тэр нь бол зөв байгаа юм. Анхан шатны тусламж үзүүлэх бүхий л нөхцөл боломжийг бий болгосон байна. Энэ хуульд нь ингэж хүчитгэсэн өгүүлбэрүүд маш, бүхий гэдэг үг ордоггүй шүү дээ ер нь. Ахиад боловсруулна гэхээр энэ.

Санал хураалт явуулъя. Үг хэлж дууслаа. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээр энэ өгүүлбэрүүдээ. Аюулгүй байдлыг аялал жуулчлалын тэр тур оператор байгууллага, үйлчилгээ үзүүлж байгаа

байгууллага гэж байгаа шүү дээ. Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага энэ тэр хангаж байх шаардлагатай юм байгаа юм.

Санал хураалт. 51.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

33.Төслийн 16 дугаар зүйлийн 16.6, 16.8 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ хасах нь зөв юм байна. Өөрөө өөр дээрээ заасан ийм заалт байгаад байгаа юм. Тэгээд энэ 16.6 гэсэн мөртөө энэ хуулийн 16.6-д заасан мэдээллийг гэж байгаа байхгүй юу. Энэ техникийн алдаа юм гэж бодоход аялал жуулчлалын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон нийтийн цахим сүлжээгээр түгээх өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулна гэж байгаа юм.

16.8 нь тур оператор аяллын агент нь аяллын явцад автомат ажиллагаатай бичлэгийн техник хэрэгслээр тоноглогдсон стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслээр жуулчдад үйлчилгээ үзүүлнэ гэж байгаа юм. Энэ ингээд тагнаж чагнах гэж байгаа юм шиг. Ингээд энэ заалт хасагдсан.

34.Төслийн 17 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. 17 дугаар зүйлийг тэр чигээр нь хасаж байгаа юм уу? Санал хураалт. Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Энэ тараагдсан материалуудыг, эс үгүй бол би хамгийн анхныхаа явчихсан юм уу, нөгөө дугаарууд нь зөрөөд байна. Энэ хасагдаж байгаа юм байна. Зөв, яагаад гэвэл машин дотор ингээд шувт бичлэг хийж байдаг ийм юм хийчихвэл энэ чинь ялангуяа гаднынхан юу гэж бодох вэ? Хувийн эрх чөлөө гэж юм байхгүй, privacy гэж юм байхгүй. Энэ нөхөр юу идэж байна, юу хийж байна,

хэнтэй юу ярьж байна бүгдийг нь бичдэг ийм юмнууд байж болохгүй шүү дээ. Зөвшөөрөхгүй байх. Ийм бичлэгийн машин байгаа гэвэл аягүй бол суух ч үгүй байх. Манайх хуулиараа ийм тоногтой шүү. Чиний ярьж байгаа, идэж байгаа, ууж байгаа, юу хийж байгаа бүгдийг нь машин дотор бичиж явна гээд тэгвэл жуулчин би явган явъя даа л гэх байх. Эс үгүй бол танайхаар үйлчлүүлэхгүй л гэх байх. Тэгээд энэ заалт бол хасагдаж байгаа юм байна тийм ээ? Хасагдаж байгаа гэж ойлголоо шүү. Тийм.

Г.Занданшатар: Угаасаа өмнө стандартын шаардлагад хангасан бүтээгдэхүүн үйлчилгээгээр үйлчилнэ гэж байгаа л даа. Одоо 17 дугаар зүйл бол нөгөө аялал жуулчлалын санг л хасах гэж байгаа шүү дээ? Санал хураалт. Гишүүд анхааралтай санал хураая.

51.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ сангаа нөгөө дагалдах 2, 3 хууль байгаа шүү дээ тээ? Тэн дээрээ бодож үз за юу. Бусад улс бол тэндээс чинь сан бүрдүүлдэг юм байна лээ.

35.Төслийн 18 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, санал хураалт, санал хураалт.

53.7 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Дуудлага худалдаа нь зөв боловч тэр идлэг шонхор шувуу агнана гэж байхгүй л дээ. Барьж л болдог юм байгаа биз. Дараагийн санал.

36.Төслийн 19 дүгээр зүйлийг 17 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17 дугаар зүйл.Аялал жуулчлалын бүс

17.1.Монгол Улс тодорхой газар нутгийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилгоор орон зайн зохистой төлөвлөлтийг бий болгосон аялал жуулчлалын бүстэй байна.

17.2.Аялал жуулчлалын бүсийг дараах байдлаар ангилна:

17.2.1.улсын аялал жуулчлалын бүс;

17.2.2.орон нутгийн аялал жуулчлалын бүс.

17.3.Улсын аялал жуулчлалын бүсийг тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих, байгаль, түүх, соёлын өв, аялал жуулчлалын нөөцийг хамгаалах зорилгод нийцүүлэн, улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд үндэслэн Засгийн газраас тогтоож, хилийн заагийг батална.

17.4.Улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтооход газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны саналыг авна.

17.5.Улсын аялал жуулчлалын бүсэд аялал жуулчлалын үйл ажиллагаа, газар ашиглалтад холбогдох техникийн зохицуулалт, стандартыг мөрдөх бөгөөд түүнд нийцсэн менежментийн төлөвлөгөөтэй байна.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан менежментийн төлөвлөгөө, бүсийн аялал жуулчлалын маршрутыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17.7.Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг аймаг,

нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийцүүлэн боловсруулна.

17.8.Энэ хуулийн 17.7-д заасан хилийн заагийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд болон энэ хуулийн 30.1-д заасан мэдээллийн санд хүргүүлнэ.

17.9.Орон нутгийн аялал жуулчлалын бүс нь менежментийн төлөвлөгөөтэй байна. Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн газар зохион байгуулалтын асуудлыг аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.

17.10.Улсын аялал жуулчлалын бүсэд хамаарах аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд аялал жуулчлалын газрын ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж, хэрэгжүүлэхдээ энэ хуулийн 17.5-д заасан техникийн зохицуулалт, стандартыг мөрдөнө.

17.11.Энэ хуулийн 17.9-д заасан орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийн төлөвлөгөөг аймаг, нийслэлийн аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батална.

17.12.Улсын аялал жуулчлалын бүсийн менежментийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн аялал жуулчлалын бүсийн менежментийг аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан зохион байгуулна.

17.13.Аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь, эсхүл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

17.14.Орон нутгийн аялал жуулчлалын бүсийн хилийн заагийг тогтоохдоо улсын аялал жуулчлалын бүсийн хилийн заагтай давхиулж тогтоохыг хориглоно.

17.15.Улсын аялал жуулчлалын бүстэй орон нутгийн аялал жуулчлалын бүс давхацсан тохиолдолд тухайн хэсгийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хүчингүй болгоно.

17.16.Улсын болон орон нутгийн аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа эрхлэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгч хоорондын орон зайн төлөвлөлтөд холбогдох техникийн зохицуулалт, стандартыг заавал дагаж мөрдөнө. Санал гаргасан ажлын хэсэг.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр ийм улсын аялал жуулчлалын бүс, орон нутгийн аялал жуулчлалын бүс гээд ингээд 2 хувааж байна л даа. Тэгэхээр юу байдаг юм Тэрэлж, Алтай Таван Богд байдаг юм уу, Хөвсгөл ч байдаг юм уу, Хонгорын элс ч байдаг юм уу эд нар чинь бүгдээрээ дархан цаазат газруудын бүсэд байж байгаа шүү дээ. Тэгээд тэр дархан цаазат газрынхаа бүс нутагт давхиулаад тэгээд ийм аялал жуулчлалын, улсын аялал жуулчлалын бүс өгөх юм байна л даа. Ийшээ нэг алхах дээр нь хөөе чи дархан цаазат газар руу, бүс рүү орчихлоо гээд л . Ийшээ нэг алхах дээр л юу байдаг юм улсын аялал жуулчлалын бүс рүү орчихлоо гээд л ийм давхардуулсан юм тэн дээр бий болоод л ингээд л явах нь л дээ.

Тэгэхээр дээрээс нь орон нутгийн аялал жуулчлалын бүс гээд ингээд байж байна. Жишээ нь Архангайн Өгийн нуур дээр тухайн сум нь шийдвэр гаргаад, энэ бүс нутаг руу ороход тэдэн төгрөгийн хураамжтай гээд шийдвэр гаргаад

явчихвал яах юм? Тэгээд ийм их зовлонтой юмнууд дээр ингээд тийм бүс тогтоогоод л, тэгээд тэр бүсээсээ болоод л тэгээд бүүр жуулчин хөгжүүлэх биш бүүр ингээд тийм гацаасан юм болчих вий. Тэн дээрээ бас анхаараарай гэж бас энэ Аялал жуулчлалын яамныханд хэлье.

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлнэ.

Б.Энхбаяр: Энэ аялал жуулчлалын бүс гэдэг ойлголт нь Тусгай хамгаалалтынхаа хуультай их уялдах шаардлага байгаа юм. Түүрүүн Тогтохсүрэн дарга бас хэлж байсан юм Тусгай хамгаалалтын хууль үлдчихээр одоо бидний энэ санал хураах чинь 17 дугаар зүйл ер нь бүхэлдээ тусгай хамгаалалттай газрын харилцааг зохицуулаад байгаа зүйл байгаа байхгүй юу. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, хилийн бүс тогтоох гэдэг чинь хилийн бүс биш шүү дээ энэ чинь. Газрын зааг тогтоох гэж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ Засгийн газраас тогтоох гэж байгаа газрын зааг тогтоох гэж байгаа тохиолдолд энэ чинь ялангуяа хөдөө орон нутагт аймаг дамжсан аялал жуулчлалын, аймгуудын хилийн бүс дамжсан газрын зааг тогтоогдож таарна. Сумууд дээр сумуудын хилийн бүс заагдсан газрууд тогтоогдож таарна. Энэ тохиолдолд энэ бүс дээр бусад харилцаанууд яригдана. Жишээлбэл. Мал аж ахуй бэлчээрийн харилцаа нь яах юм, мал ерөөсөө байж болохгүй юм уу гэдэг асуудал үүснэ. Энэ хилийн зурвас бүс дээр байвал яах вэ гэдэг харилцаа яригдана.

Тийм учраас энэ яах вэ жишээлбэл, 17.3 байгаа юм аялал жуулчлалын бүсийн менежментийг бүхэлд нь эсвэл тодорхой хэсгийг гэрээний үндсэн дээр хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэж байгаа юм. Тэгэхээр энэ хэрэг дээрээ газрыг тухайн тэр аялал жуулчлалын газрыг хувийн хуулийн этгээдэд ямар гэрээгээр

өгөх гэж байгаа вэ гэдэг харилцаа байхгүй юу. Ямар гэрээгээр? Эзэмшүүлэх эрхийн харилцаа юу, ашиглуулах эрхийн харилцаа юу? Одоо үйлчилж байгаа Газрын хуулийн. Эсвэл Иргэний хуулийн түрээсийн гэрээний асуудал ярьж байна уу. Түрээсийн гэрээний асуудал ярьж байгаа бол энд хугацаа нь яригдана. Тусгай хамгаалалттай газрын тухай хуулиа баривал энэ 5 жилийн гэсэн хугацаатай байгаа 5 жил. 5 жилээс дээш байхгүй шүү дээ. Хэрвээ газрын хуулийн концепт яривал энэ 60 жилийн хугацаа яригдана.

Тэгэхээр энэ гэрээний үндсэн дээр эзэмшүүлж болно гэдэг бол Иргэний хуулийн түрээсийн гэрээ яриад байна уу гэвэл энэ хугацаа нь өөрөө яригдана. Иргэний хуулийн бусад сервитут, узуфрукт бусад эрхүүд энэ дээр үйлчилж явна гэвэл тусгай хамгаалалттай хуулийн хугацаанууд яригдахгүй гэдэг юм уу ийм асуудлууд үүснэ.

Тийм учраас Тусгай хамгаалалттай газрынхаа хуультай ер нь Газрын ерөнхий хуультай хамт ярьж байж энэ илүү тодорхой, илүү ойлгомжтой, цаашаа эрхийн харилцаанд орох ийм нөхцөл байдал байгаад байгаа юм. Жишээлбэл бидний сая Хөгжлийн банкин дээр ярьдаг шиг тэр “Скай ресорт” дээр хувийн байшин барьчихаж байгаа гэдэг чинь хэдийгээр тэгээд гэрчилгээ нь болохоор хувийн өмч, зориулалт нь болохоор аялал жуулчлалын зориулалттай, тэгсэн мөртөө дээр нь байгаа үл хөдлөх нь болохоор хувийн хөрөнгө үл хөдлөхийн гэрчилгээтэй явж байгаа шүү дээ тэр чинь. Ийм зөрчлүүд үүснэ шүү дээ. Тэгээд тэнд хөрөнгө оруулчихсан, мөнгөө оруулаад том том хэдэн тэрбумаар нь мөнгө оруулчихсан хүмүүсийн эрхийн асуудал яригдаад байгаа байхгүй юу. Хувийн өмч баталгаагүй. Тэгээд 5-хан жилийн хугацаан дээр чи 5 тэрбумаар байшин бариад яв гэвэл ямар ч дурак хөрөнгө оруулахгүй шүү дээ.

Тийм учраас нөгөө газартай нь холбосон эрхийн харилцаанд оруулах дээр яг энэ аялал жуулчлалын бүс гэдэг нь асуудал нь ер нь л юу яагаад байгаа юм. Тийм учраас энэ Тусгай хамгаалалттай хуультайгаа л цуг, тэгээд Газрын хуультайгаа цуг яв.../минут дуусав./

Г.Занданшатар: Бүсийн менежмент нь хуулийн этгээдээр бүртгүүлж болно гэж байгаа. Энийг Ганхуяг даргаа, Цэрэнпунцаг даргаа энэ 17, 18 хоёр бол найруулгаар энэ ихэнх нь 3 зүйл л нэмэгдсэн болохоос биш энэ чинь тэр чигээрээ хуулийн энэ төсөлд нь байгаа заалт шүү дээ. Тийм, тэгэхээр найруулгаар дугаарлалтыг өөрчилнө шүү дээ угаасаа. 17 дугаар зүйл чинь хасагдчихаж байгаа учраас. 17, 18 дугаар зүйл хасагдчихаад дугаар шилжиж байгаагаар энэ дараагийн отголох цэг хоёрыг, энэ хоёрыг ингэж отголох цэг дээр ерөөсөө өөрчлөлт ороогүй мөртөө ингээд ахиад санал хураагаад тэгээд ганц 2 юмнууд өөр байна лээ. Тэгээд энэ хоёрыг тэр дугаарлалтыг нь өөрчлөөд, дугаарлалтыг нь тэгж янзлаад энэ доторх заалт нь 3 заалт нэмэгдэж байгаа юм л даа. Тэр Тусгай хамгаалалтын газар нутгийн хуультайгаа л уялдуулах шаардлагатай л гээд байна шүү дээ.

Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлнэ.

Ж.Батжаргал: Тодорхой байгалийн унаган төрх гэдэг юм уу, түүх соёлын, дурсгалт газар энэ бүх юмаараа аялал жуулчлалын хөгжлийг нэлээн тийм татах бололцоотой газруудаа аялал жуулчлалын бүс гэж ярьж байгаа юм шиг байгаа юм.

Гэтэл үүний менежментийг хуулийн этгээдээр гүйцэтгүүлдэг юм гэж байхгүй шүү дээ энэ чинь. Болохгүй байхгүй юу. Тийм учраас тэр бүсээ тогтоож болно. Тэндээ аялал

жуулчлалын хөгжлөө тэргүүн ээлжид хөгжүүлэх бодлогоо барьж болно. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь өөрөө яг тэр хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гэдэг юм уу, тэр тухайн нэгж дээрээ хийгдэх үйл явцаараа л зохицуулагдах ёстой. Тэгэхгүй бүс нутгаар нь аль нэгэн хувийн хэвшил асуудлыг нь авч явдаг, менежментийг нь авч явдаг болчих юм бол энэ чинь болохоо байчихна шүү дээ. Тэгэхээр энийгээ жоохон зааглаж ялгахгүй бол наадах чинь боломгүй болчихлоо.

Тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын гол хөгжил яваад байгаа. Гэтэл Тусгай хамгаалалттай газар нутаг дотор чинь өөрөө аялал жуулчлалын мэдээллийн сан буюу аялал жуулчлал хөгжих тодорхой тийм суурьшлын хэсгүүд нь ялгагдах ёстой тэрнийх нь ерөнхий гэдэг юм уу, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө гарч байж сая үйл ажиллагаа нь явах ёстой. Тэгээгүй нь үр дагавар энэ урд ам тэр чигтээ тэгж харагдаад байгаа байхгүй юу. Байгаль орчны яам бол аялал жуулчлалын гэдэг нэрийн доор баахан газар өгсөн. Гэтэл Барилга, хот байгуулалтын яам уг эскиз зураг, төлөвлөгөөг нь орон сууцын хорооллоор ороод ирэхэд нь баталж өгөөд явуулчихаад байгаатай холбоотой л ийм асуудал болж хувирч байгаа байхгүй юу. Тэгэхээр үүнийг их зааглаж, ялгаж зөв болгохгүй энэ ёстой буруу юм руугаа явна шүү.

Г.Занданшатар: Энэ 17, 18 дугаар зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгье. Энэ юмтайгаа уялдуулах хэрэгтэй юм байна. Тусгай хамгаалалтын газар нутгийн хууль болон тэгээд менежментийг гэхээр тэр газарт олгох зөвшөөрөл энэ тэр бүх юм хамаарч байгаа юм уу, менежментээ тодорхойлолт байхгүй учраас менежментийг Засаг дарга хэрэгжүүлнэ гэж байгаа юм. Бас хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно гэж байгаа юм.

Тэгэхээр гол нь энэ бүсэд чинь менежмент нь газрын асуудал л яригдана шүү дээ. Газар олгох зөвшөөрөл энэ тэр нь. Тэгэхээр менежмент гэдэг юундаа хамаарч байгаа юм уу, хамаарахгүй байгаа юм уу? Тусгай хамгаалалтын газар нутаг, бүсийг, ер нь аялал жуулчлал дандаа тусгай хамгаалалтын газар нутаг дээр л байгаа. Энийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Тэгээд дугаарлалт энэ тэртэйгээ.

18 дугаар зүйл, 37 дугаар санал хураалтыг ч гэсэн отголох цэгийг гүйцээн боловсруулахад чиглэл өгч байна.

38.Төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

2-хон зүйлтэй л бүлэг гарах нь байна шүү дээ энэ. Энэ санал дэмжигдсэнгүй. Энэ эцсийн хэлэлцүүлэг дээр энэ 2 зүйл л байгаа шүү дээ. Аялал жуулчлалын бүс, отоглох цэг гэсэн ийм 2 зүйлтэй бүлэг байх юм уу, бусдаа хамруулах юм уу? Энийгээ гүйцээн боловсруулж дээ.

39.Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн “БАЙГУУЛЛАГА, АШГИЙН ТӨЛӨӨ БҮС” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Энэ төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх л гэж болж байгаа юм. Ашигийн төлөө бус байгууллага гэж тэр бодвол нөгөө холбоогоо л хэлж байгаа байлгүй дээ. Тэрний статусыг хасаж байгаа юм.

40.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.5 дахь заалтын “хуулийн” гэсний дараа “6.6, 21.5,” гэж, 21.2.1 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “болон хэрэгжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад зөвлөгөө өгөх, санал гаргах” гэж тус тус

нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй. 40-өөс 26 гишүүн байна. Энэ чинь Үндэсний хорооны бүрэн эрх шүү дээ 21.2.1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого боловсруулах тал зөвлөгөө. Энэ ингээд дэмжигдсэнгүй.

41.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.6.аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлах.” гэдгийг үү? Санал гаргасан ажлын хэсэг. 21.1.6.

41 дээр үү? Угаасаа 21.1.6 гэж байна л даа. Тэгэхээр тэр 21.1.6 Монгол Улсын аялал жуулчлалыг сурталчлах, хүний нөөцийг бэлтгэх аялал жуулчлалын төрөлжсөн мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах гэдгийг бас хасчхаж болж байгаа юм уу? Хасаад ерөнхий төлөвлөгөөгөө батлах гэж. Энийг гүйцэтгэн боловсруулах чиглэл өглөө. Ажлын хэсгийн саналаар.

42.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ зүйтэй санал байна. Санал хураалт.

Аялал жуулчлалын салбарт шинэчлэлт, өөрчлөлтийг нэвтрүүлэх гэж байна шүү.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

43.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.3 болон 21.4 дэх хэсгийг тус тус доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.3.Үндэсний хороог Ерөнхий сайд тэргүүлэх бөгөөд байгаль орчин, аялал жуулчлал, төсөв, санхүү, эдийн засаг, тээвэр, эрчим хүч, гадаад харилцаа,

хууль зүй, соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон тус бүр нэг, энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдээс санал болгосон таван гишүүнээс бүрдэнэ.

21.4. Үндэсний хороо орон тооны бус байх бөгөөд гишүүдийг Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тэгэхээр энэ түрүүчийнх чинь зөв байна шүү. Ерөнхий сайд өөрөө тэргүүлэх мөртөө тэр Үндэсний хороо чинь Ерөнхий сайдад зөвлөгөө өгнө, санал гаргана гэдэг чинь зөрчилдөх байсан юм байна. Энэ заалт.

44. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3, 21.4, 21.5 дахь хэсгийг 20 дугаар зүйл болгон зүйлийн нэрийг “20 дугаар зүйл. Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэн эрх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

45. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“22.1.13. аялал жуулчлалын талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавих.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

65.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

46. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалтын “6.6, 10.3, 11.3-т” гэснийг “10.3, 15.4-т” гэж, 22.1.5 дахь

заалтын “жуулчны үйлчилгээний байгууллагын” гэснийг “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн” гэж, 22.1.7 дахь заалтын “үйлдвэрлэл, үйлчилгээ” гэснийг “үйлдвэрлэлийг хөгжүүлэх” гэж, 22 дугаар зүйлийн 22.1.11 дэх заалтын “бий болгоход дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт

63.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

47. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1.7 дахь заалтын, 22.1.9 дэх заалтын “боловсруулах” гэсний дараа “, хэрэгжүүлэх” гэж, 22.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “салбарын хүний нөөцийг бэлтгэх, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

28 гишүүн дэмжиж, 68.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Манай Бямбацогт гишүүн чинь уулчин хүн. Тэр отоглох цэг энэ тэр гэдгийг Таван Богдод их олон авирсан хүн байгаа юм. Саналыг нь бас аваарай. Түрүүн үг хэлэх гээд байсан.

48. Төслийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

27 гишүүний дэмжиж, 65.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ингээд яг талдаа орлоо 48. Өнөөдөр генералуудын өдөр генералуудын өдрийн мэнд хүргэе. Тэгээд Улсын Их Хурлын дэд дарга манай Лхагвын Мөнхбаатар гишүүн хурал удирдана. Хурандаа, цагдаагийн хурандаа. 12-оос би явлаа. Мөнхбаатар гишүүн. Энийг унигъя.

Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.4 дэх заалтын “батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулж” гэснийг, 24.1.5 дахь заалтын “эрх хэмжээнийхээ хүрээнд” гэснийг, 24.1.7 дахь заалтын “наадам, бусад” гэснийг тус тус хасаж, 24 дүгээр зүйлийн 24.1.7 дахь заалтын “тухайн жилийн” гэснийг “өмнөх оны” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Л.Мөнхбаатар: Уг санал 65.8 хувиар дэмжигдсэн байна.

50.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалтын “харьяалах” гэсний өмнө “шаардлагатай тохиолдолд” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Уг санал 68.4 хувиар дэмжигдлээ.

51.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.8, 24.1.11 дэх заалт, мөн зүйлийн 24.2 дахь хэсэг болон “Тайлбар” хэсгийг тус тус хасах. Санал хураалт.

Уг санал 59.5 хувиар дэмжигдлээ.

52.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.15.харьяалах нутаг дэвсгэртээ улсын болон олон улсын чанартай авто замын дагуу аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, жуулчинд үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд хамтран ажиллах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

53.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай заалт нэмэх:

“24.1.16.аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан аймаг, нийслэлд аялал жуулчлалын асуудал хариуцсан нэгж, эсхүл ажилтан ажиллуулах.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

71.1 хувиар санал дэмжигдлээ.

54.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.3, 25.1.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

68.4 хувиар санал дэмжигдлээ.

55.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.8 дахь заалт, мөн зүйлийн 26.2 дахь хэсгийг хасах. Санал хураасан ажлын хэсэг. Санал хураалт.

71.1 хувиар санал дэмжигдлээ.

56.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“26.1.3.харьяалах нутаг дэвсгэртээ байгуулах жуулчны үйлчилгээний байгууллагад газар эзэмших зөвшөөрлийг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон нөөц, даац, тоо, байрилыг баримтлан хууль тогтоомжийн дагуу олгож гэрээ байгуулах;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түдгэлзүүллээ.

Баттөмөрийн Энхбаяр гишүүн үг хэлье.

Б.Энхбаяр: Энэ газрын зөвшөөрөлтэй холбоотой харилцаа байгаа. Түрүүн аялал жуулчлалын бүстэй холбоотой газрын харилцааны асуудал дээр хурал даргалагч гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Энэ дээр бол газар эзэмших зөвшөөрөл болоод яваад байна тийм ээ? Одоо бол? Одоо бол ашиглах зөвшөөрөл өгөөд байгаа шүү дээ.

Тусгай хамгаалалттай газар дээр. Энэ бол газар эзэмших зөвшөөрөл нэгдүгээрт өгч байгаа юм байна. Хэрвээ эзэмших зөвшөөрөл өгч байгаа тохиолдолд энэ чинь эзэмших эрхийн хугацаа чинь 60 жил байгаа шүү дээ. Тэгээд энэ хугацаа нэгдүгээрт өөр болно гэсэн үг.

Хоёрдугаарт хууль тогтоомжийн дагуу олгогчоод, гэрээ байгуулах гэхээр энэ гэрээ нь газар эзэмших гэрээгээ л хэлж байгаа биз дээ тийм ээ? Тэрнээс биш газар эзэмших зөвшөөрлөө өгчхөөд, ахиад өөр гэрээ байгуулах юм болчихоогүй байгаа гэдэг нэг асуудал.

Энэ дахиад л Тусгай хамгаалалттай газрын хууль руу ороод байгаа юм. Одоо энэ дээр бол Байгаль орчны яамны тогтоосон нөөц, даац, тоо, байршилыг баримтлаад гэрээ байгуулна гээд байгаа юм. Тэгэхээр энэ Байгаль орчны яам энэ чинь аймаг, сум, нийслэлийн Засаг даргын эрх байна уу? Сумын Засаг даргын эрх байна уу? Энэ дээр бас оролцоод л яваад л байна л даа. Түрүүн бол орон нутгийн аялал жуулчлалынх нь тэр менежментийн төлөвлөгөөг хурал нь батална гэж байсан тийм ээ? Аймгийнх нь хурал нь батална гэж байсан шүү дээ.

Тэгэхээр аймгийн хурлын батлах аялал жуулчлалын менежментийн төлөвлөгөө гэдэг чинь ер нь нөөц, даац, тоо, байршилаа л хэлээд байна уу? Байгаль орчны яам нь нөөц, даац, тоо, байршилаа шийдээд байх юм байна. Тэгэхээр аймгийн хурал юуг нь шийдэх юм? Менежментийн төлөвлөгөөгөө батална гээд байна лээ шүү дээ түрүүн. Тэгэхээр нөөц, даац, тоо, байршил ордоггүй менежментийн төлөвлөгөө гэж юу байгаад байна бас? Юу үлдээд байгаа юм тэнд? Одоо хурал батлах.

Тэгэхээр энэ хурлын эрх хэмжээ, Байгаль орчны яамны эрх хэмжээ, Засаг даргын эрх хэмжээ гэсэн нэг ийм юмнууд яг газрын зөвшөөрөл дээрээ ингээд байна.

Тийм учраас энийг түрүүн гүйцээн боловсруулах чиглэл өгсөн. Энэ зөвшөөрөлтэй холбоотой байгаа учраас адилхан гүйцээн боловсруулбал яадаг юм бол гэсэн ийм саналтай байна.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүний сая хэлсэн үгтэй холбогдуулаад ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг үг хэлэх үү? Энэ дээр эзэмших, ашиглах зөвшөөрлийн тухай асуудал яригдаж байна. Дээр нь энэ даац гээд нэр томъёо орж ирээд байна шүү дээ. Даац гэдэг маань энэ өөрөө хуулийн нэр томъёо, энэ хуульдаа байгаа юу? Нэр томъёо дотор нь заасан юм байгаа болов уу? Ганхуяг, Ганхуяг гишүүн үг хэлье.

Х.Ганхуяг: Юу яачихъя дарга нэгэнт сая, өмнө нь бид нар аялал жуулчлалын бүс болон отоглох цэг дээр гүйцээн боловсруулах чиглэл авсан болохоор энэ заалтаа бас гүйцээн боловсруулах чиглэлээ авчихъя. Энэ даац, энэ тоо, байршил эд нарыг үндсэндээ Тусгай хамгаалалттай газрын хуулийн нэр томъёотой нь уялдуулж уг нь оруулж ирсэн байгаа юм. Бат-Эрдэнэ сайд нэмж хариулах уу? Гүйцээн боловсруулах чиглэл авчихъя даа дарга.

Л.Мөнхбаатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүний гаргасан санал, үгтэй холбогдуулаад төслийн 26 дугаар зүйлийн 26.1.3 дахь заалтыг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өглөө. Цаашаа явъя.

57.Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.4 дэх заалтын “аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэгч иргэний үйл ажиллагааг хөгжүүлэхэд” гэснийг “нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйл ажиллагаанд” гэж, 26.1.7 дахь заалтын “отоглох цэгийн байршил, аяллын маршрутыг тогтоох,” гэснийг “аяллын маршрутын дагуу” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.5 хувиар санал дэмжигдлээ.

58.Төслийн 27 дугаар зүйлийг “ТАВДУГААР БҮЛЭГ.АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” гэсэн гарчиг бүхий Тавдугаар бүлгийн 26 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

26 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

26.1.Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал эрхлэгчийн нэгдэл бүхий, аялал жуулчлалын үйл ажиллагаанд оролцогчдыг сургалт, зөвлөгөө, мэдээлэл, мэргэжлийн арга зүйгээр хангах, аялал жуулчлалын байгууллагын ажилтны баримтлах мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, боловсронгуй болгох үндсэн чиг үүрэг бүхий ашигийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд /цаашид “холбоо” гэх/ байна, байна. Найруулгын хувьд уншигдахаар их төвөгтэй л байна.

26.2.Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг холбооны дүрмээр зохицуулна.

26.3.Холбоо нь аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр төрийн, ашигийн төлөө бус хуулийн этгээд болон олон улсын байгууллагатай хамтран ажиллаж болно.

26.4.Холбоо нь тухайн жилийн үйл ажиллагааны тайлангаа дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аудитлагдсан санхүүгийн тайлангаа

харилцагч санхүүгийн байгууллагад, татварын тайлангаа харьяалах татварын албанд хуульд заасан хугацаанд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Энэ аялал жуулчлалын холбоодод нэлээн чиг үүрэг нэмэгдүүлж, бас тодорхой хэмжээний эрх хэмжээ олгосон байна. Энэ болж байна бас. Энэ холбоо дээр ер нь бид нар энэ мэргэжлийн холбоодыг бас бэхжүүлэх, мэргэжлийн холбоодоороо дамжуулж үйл ажиллагаа явуулах нь зөв болов уу гэж бодож байна. Гэхдээ хэт эрх бас олгож болмооргүй байгаа юм. 26.2 бол хэт эрх олгочихсон байгаа юм. Холбооны зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулагдаагүй харилцааг холбооны дүрмээр зохицуулна гээд хуульд тусгаагүй юм бүгдийг зохицуулах хэлбэртэй юм шиг ойлгогдоод байгаа юм.

Тийм учраас дараагийн хэлэлцүүлэг дээрээ, найруулга дээр энэ 26.2 дахь өгүүлбэрийг бас нэг бодож үзэх хэрэгтэй өгүүлбэр байгаа юм гэж хэлэх гэж байгаа юм.

Хоёр дахь асуудал нь энэ холбооны чиг үүрэг дотор энэ байгаль хамгаалах чиг үүрэг огт байхгүй байгаа юм. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах тухай асуудал байгаа юм. Эд нар чинь бас байнга л ашиглагч нар болчихоод байгаа байхгүй юу. Голдуу тусгай хамгаалалттай уул, устай тийм аятайхан газрууд байдаг. Гэтэл энийгээ хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах, талхлалтад оруулахгүй байх энэ үүрэг бол энэ холбооны үүрэг бас байх ёстой байхгүй юу.

Тийм учраас энэ холбооны чиг үүрэг дээр нь дараагийн хэлэлцүүлэг дээр

ийм асуудлыг авч үзээрэй гэж ингээж хэлэх байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ 27.1 дээрээ үүрэг бүхий ашигийн төлөө бус нийтийн эрх зүйн хуулийн этгээд байна гэхээд байна шүү дээ. Тэгчхээд одоо энэ 27.4 дээрээ болохоор тайлангаа зайлиггүй бүүр 4 сарын 1-ний дотор тайлангаа төрийн захиргааны төв байгууллагад өг, аудитлагдсан санхүүгийн тайлангаа харьцагч санхүүгийн байгууллагад өг, татварын тайлангаа татварын байгууллагадаа өг эд нар гээд ингээд бүүр үүрэгжүүлээд энэ чинь төрийн байгууллага шиг л болгоод хаячхаад байна шүү дээ. Энийг ер нь яах ёстой юм бэ? Бид нар энэ төрийн бус байгууллагуудаа ерөнхийдөө төрийн байгууллага сонсох ёстой. Тэндээс гарч ирж байгаа саналуудыг үйл ажиллагаандаа авах ёстой.

Гэхдээ яг ингээд бүүр тайлангаа наашаагаа өг гээд эд нар хажуудаа байлгаж байгаа юм шиг ингээж байлгаад байдаг чинь болж байгаа юм уу? Тэгэхээр энийг арай бас нэг жоохон ондоо байдлаар нь жоохон юу яаж, энэ чинь олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллага тэгээд энэ чинь хажуудаа авчраад ингээд уячхаж болж байгаа юм уу л гэж гэх гээд байна л даа. Эндээ найруулга юман дээр нь засмаар ч юм шиг л харагдаад байх юм.

Л.Мөнхбаатар: Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Үгүй үгүй энэ хууль дотор тэр мэргэжлийн холбооны тодорхойлолтыг оруулж ирэх гээд оролдоод байгаа нь буруу болчихож байгаа байхгүй юу. Төрийн энэ аялал жуулчлалтай холбоотой чиг үүргийг энэ байгууллагаар гүйцэтгүүлэх тухай асуудал, шилжүүлсэн тэр чиг үүргээ

хэрхэн хангасан тухай тайлал авах болохоос биш холбооны тайлан аваад явдаг эд нар юм байж таарахгүй шүү дээ.

Тийм учраас төр аялал жуулчлалын чиглэлээрх ямар чиг үүргээ холбоогоор гүйцэтгүүлэх юм? Тэр шилжүүлсэн чиг үүргийнхээ дагуу хийсэн тайлангаа авах тухай л асуудал байхгүй юу даа. Ийм байдлаар зохицуулахгүй бол болохгүй байна.

Л.Мөнхбаатар: Ажлын хэсгийн ахлагч Хассуурийн Ганхуяг үг хэлье.

Х.Ганхуяг: Энэ мэргэжлийн холбоо хуульд оруулж, байгуулж байгаа ер нь шалтгаан нь юу гэхээр нэг үндсэндээ энэ чинь 300-гаад төрийн бус байгууллага байгаа. Мэргэжлийн холбоод эд нар гээд. Яг аялал жуулчлалын чиглэлийн. Зарим компани нь 4, 5 тамгатай, гэрчилгээтэй байгаа юм.

Тэгээд бид нар энэ нөгөө төр хувийн хэвшилтэйгээ хамтран ажиллах энэ юуг нь л нээж өгч байгаа юм. Эхнийхээ хурлаа хийчих, тэрнийх нь дараа ингээд бүх юм чинь шилэн байна шүү, хариуцлагатай байна шүү гэдэг асуудлууд тавигдана гэсэн үг. Энэ дотор яагаад ингээд ангилуудыг нь оруулж ирж байгаа вэ гэхээр энэ бүртгэлийн асуудлууд явагдах юм яг энэ холбоо дээрээ. Тэгэхгүй бол аль холбоонд бүртгэлээ явуулах вэ гэдэг нь тодорхой болчихоод байгаа юм.

Тэгэхээр 1 нийтийн эрх зүйн хуулийн этгээд байгуулья. Тэн дээрээ энэ аж ахуйн нэгжүүдийг бүртгээд яв. Энэ түр операторууд нь болохоор тэр хил орчмын аялал жуулчлалын бас хилийн хамгаалах, хил хамгаалахтайгаа гэрээ хийгээд явуулах асуудлууд сөхөгдөнө.

Дээрээс нь түр оператор, түр агентууд татварын хөнгөлөлтүүд орж ирж байгаа энэ хуулийг дагаад. Тэгэхээр энэ чинь эргээд, буцаагаад тайлагнадаг байх. Тоо хэмжээ, статистикаа өгдөг

байх. Ийм хариуцлагажуулах асуудал ялт ч үгүй сөхөгдөж гарч ирнэ.

Дээрээс нь энэ нийт эрх зүйн хуулийн этгээдээсээ тодорхой яг сонгогдсон хүмүүс нь бас Үндэсний хороо дээр очиж ажиллах юм байгаа юм. Тэгэхээр чинь бид нар яг дунд нь нэг удаа анхны зохион байгуулалтыг нь хийж өгөөд ингээд энэ төрийн бус байгууллага нь төртэйгөө хамтраад бодлогоо тодорхойлоод ингээд явдаг л байх асуудлыг ярьж байгаа юм.

Энэ холбооны зохион байгуулалт энэ үйл ажиллагаатай холбогдсон энэ үйл ажиллагаатай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй дотоод харилцааг тэр холбооны дүрмээр зохицуулна гээд энэ дотоод гэдэг үг гээгдсэн байна. Тэрийг бид нар бас найруулгаараа засаад оруулчихъя дарга. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганболд гишүүн үг хэлэх юм уу? Гочоогийн Ганболд гишүүн үг хэлье.Тэгээд хэдүүлээ шуурхай явна. Одоо 36 санал бас дутуу байна шүү.

Г.Ганболд: Гишүүдийн хэлээд байгаа зөв л дөө. Ер нь бол энэ холбоодын хууль гээд нэг юм байгаа шүү дээ. Энэ хуулиа оруулж ирж байж ярихгүй бол одоо бид нар чинь ингээд энэ салбарын хуулиудад холбооны зохицуулалтуудыг ингээд бүүр эрх, үүргийг нь ч юм уу ингэж оруулж ирээд байгаа нь өөрөө буруу шүү дээ. Тэгээд энэ дотор чинь одоо бүүр заавал бусад, түрүүний нийтийн эрх зүйн хуулийн этгээд байгаад байгаа чинь энэ чинь төрийн бус байгууллагаа хэлж байгаа юм байна. Тэгээд энд чинь нөгөө бүртгэлийн асуудал чинь бас яг тэгвэл энэ төрийн бус байгууллага дээр явж байгаа юм байна. Тэгээд энд нөхдүүдийг заавал гишүүнчлэхийг нь үүрэгжүүлж байна л даа хуулиар.

Тэгэхээр өмнө нь бид нар чинь бол энэ холбоонууд юу хийдгийг мэднэ шүү дээ. Монголын аялал жуулчлалын холбоо

гэж байгаа юм. Аймгууд дээр бас аялал жуулчлалын холбоод байгаа юм. Тэгээд эд нар чинь нөгөө бусад тэнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн баазуудаа оруулж, нөгөө татвар хураамж авах тухай асуудал байхгүй юу. Тэгэхээр зэрэг эд нар чинь бол ерөөсөө үндсэндээ хийдэг ажилтан нь бол гадаад, дотоодын аялал жуулчлалын арга хэмжээнүүдэд оролцож, тэрэнд нь нөгөө гишүүн байгууллагуудаа оролцуулах гэж л 5 төгрөг авах л ийм зорилготой байдаг шүү дээ.

Тэгээд энийгээ энэ холбооныхоо хуулиар зохицуулаад, зүгээр энэ заалт дээр ингээд энэ холбооны тухай асуудалд оруулах гэж байгаа бол төр зарим чиг үүргээ төрийн бус байгууллагаар хэрэгжүүлж болно гэж үгээ оруулаад л тэгээд л болоо шүү дээ. Тэгээд л төрийн бус байгууллагууд нь тэр холбоодынхоо хуулиар дараа нь зохицуулаад л тэгээд л ямар чиг үүргээ өгөх юм? Тэрийгээ өгөөд л явах хэрэгтэй шүү дээ. Яг сая Батжаргал гишүүний хэлж байгаа зөв шүү дээ.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Тогтохсүрэн, Бат-Эрдэнэ, Батжаргал, Ганболд нарын хэлсэн санал болон найруулгын болон зарчмын зөрүүтэй саналуудыг тусгаж, дахин авч үзэх нь зүйтэй байна. Ийм учраас эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ энэ төслийн 26 дугаар зүйлийг бүхэлд нь гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Цаашаа явъя.

59.Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 27 дугаар зүйл нэмэх:

“27 дугаар зүйл.Холбооны их хурал

27.1.Холбооны эрх барих дээд байгууллага нь Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны их хурал /цаашид “их хурал” гэх/ байна.

27.2.Их хурал нь ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байх бөгөөд ээлжит хурлыг жилд нэг удаа хуралдуулна.

27.3.Их хурлын төлөөлөгчдийн олонх оролцоноор хурал хүчин төгөлдөр болно.

27.4.Их хуралд оролцох төлөөлөгчдийг сонгох журмыг холбооны дүрмээр тогтооно.

27.5.Их хурлын төлөөлөгчид нь холбооны гишүүнчлэлтэй аялал жуулчлалын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

27.6.Их хурал дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.6.1.холбооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

27.6.2.аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

27.6.3.холбооны Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх.

27.6.4.холбооны Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, санал, зөвлөмж өгөх;

27.6.5.хууль болон холбооны дүрмээр тогтоосон бусад асуудал.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Гишүүд суугаад саналаа өгөөрэй. Хэн үг авах юм уу? Нямаагийн Энхболд гишүүн үг хэлье. Санал хураалтыг цуцаллаа. Дараачид нь Бямбацогт гишүүн, дараа нь Бат-Эрдэнэ гишүүн.

Нямаагийн Энхболд гишүүн үг хэлнэ. Нямаагийн Энхболд гишүүний микрофон өгөөрэй.

Н.Энхболд: Энэ аялал жуулчлал хөгжсөн тэр салбар нь улс орныхоо эдийн засгийн амьдралд томоохон хувь нэмэр оруулж байдаг бүх улсуудад ийм холбоо байгаа. Эд нар нэгтгэж байж гадагшаа, дотогшоо холбоо тогтоодог, нэгдсэн стандарт тогтоодог, сахилгатай, харууцлагатай, зохион байгуулалттай хийдэг ийм юм байна лээ.

Тэгэхээр нэгэнт Байнгын хороонд чиглэл өгсөн үүнийгээ бас харгалзаж үзээрэй гэж бодож байна. Түүнээс манай эдийн засгийн хамгийн том салбарын нэг болж болох энэ зүйлийг зөвхөн улсаас удирдаад явах ийм боломж туйлын хомс. Дахиад хэлэхэд энэ аялал жуулчлал хөгжсөн тэр нь томоохон үүрэг гүйцэтгэдэг улс орнууд бол ийм өөрсдийнх нь зохион байгуулалт байдаг. Энэ нь өөрөө олон ачааллыг өөр дээрээ авч, төртэй заавал холбогдоод элдэв янзын болоод байхгүйгээр ажлыг нь зохицуулахад маш том үүрэгтэй байдаг юм байна лээ шүү. Тэгэхээр энэ бараг холбоо хэрэггүй ч юм шиг, эс үгүй бол зарим юмыг нь зөвхөн дүрмээр нь зохицуулаад явах юм бол бас жоохон учир дутагдалтай. Энийг тэр Байнгын хороон дээр ярихдаа та нар бодно биз.

Зүгээр хэлэхэд одоо ингээд энэ хууль ингээд батлагдчихвал өнөөдөр байгаа тэр мэргэжлийн холбоогоо дахиж хуралдуулаад л, зохион байгуулалтад оруулаад байх юм гарахгүй байлгүй дээ гэж бодож байна. Тэр холбоо нь өөрөө гарсан хуульд зохицоод юмнуудаа хийгээд явна биз. Тэгэхгүй хууль гарсан одоо ингээд дахиад тэр холбоог нь шинээр байгуулна энэ тэр гэвэл бас л нэг. Надад тэр холбоотой хамаатай юу ч байхгүй. Сайн, мууг нь мэдэхгүй. Хуулиар зохицуулахгүй байгаа учраас энэ асуудлууд нь бид нарын бодсон хэмжээнд төрөөс дэвшүүлж байгаа бодлогын хэмжээнд үйл ажиллагаа, орлого, ажлын байр бий болгох, хамрах цар хүрээ, энэ бүх юмнууд нь болохгүй байна уу даа л гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр энийг бас бодолцох ёстой шүү. Байнгын хороон дээрээ та нар сайн тал талаас нь яриарай. Нэг ч их хэрэггүй эд юм шиг тэгж ярих хэрэг бас байхгүй.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд гишүүний хэлж байгаа санал бол үндэслэлтэй байна. Салбар болгоны төрийн бус байгууллагуудыг ингээд хууль болгонд оруулж ингээд хуульчлаад явах юм бол энэ бол дуусахгүй зүйл болно. Ер нь Мэргэжлийн холбоодын тухай хууль гээд энэ хууль санаачилж байгаа тэгээд тэрэнтэй холбогдуулаад эргэж авах нь зүйтэй. Тийм ер нь бол энэ дүрмээрээ зохицуулагддаг харилцаа шүү дээ. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

С.Бямбацогт: Энхболд гишүүн холбоо бараг хуулиараа зохицуулаад явсан ч болох байх гээд хэлчих шиг боллоо. Би эсрэг байр суурьтай байгаа юм. Энэ мэргэжлийн холбоод, төрөл мэргэжлийн холбоод ингэж хуультай болоод хуульд оруулаад явах нь буруу. Холбоо, сангийн тухай хууль гэж байж байгаа. Төрийн бус байгууллагуудын тухай хууль бас зохицуулалт байж байгаа. Энэ зохицуулалтын хүрээнд л нэгдсэн тэр хуулиудаа зохицуулах ёстой болохоос ингээд мэргэжлийн тийм үү салбарын хууль болгонд холбоо байна, холбоо их хурлаа ингэж хийнэ, холбоо нь удирдах зөвлөлтэй байна, удирдах зөвлөл нь ийм эрхтэй, үүрэгтэй байна, холбооны гүйцэтгэх удирдлага, гүйцэтгэх захирал ийм эрхтэй, ийм үүрэгтэй гээд ингээд хууль болгонд ороод эхлэх юм бол үндсэндээ Монголын бүх хуулиуд манай салбарт гэх юм бол Авто замчдын холбоо гээд Авто тээврийн хуульд өөрчлөлт орох нь. Авто тээврийн тухай хуульд Тээвэрчдийн холбооны асуудал яригдах нь. Төмөр замын хуульд төмөр замчдын хуульд асуудал яригдах нь. Иргэний нисэхийн хуульд Иргэний нисэхийн холбооны асуудал яригдах нь. Ийм байдлаар. Тэгээд спортын холбоод, Үндэсний бөхий холбоо, Морины холбоо,

Сурын холбоо, Сагсны холбоо, Волейболын холбоо гээд бүгд хуультай болох нь.

Ийм юм хийж хэрэггүй. Тэгээд Төрийн бус байгууллагын хууль байж байгаа шүү дээ. Холбоо, сангийн тухай хууль гээд гарах гэж байгаа шүү дээ Их Хурлаар. Тэрүүгээрээ төрийн бус байгууллага нь төрийн бус байгууллагынхаа хүрээнд, хуулийнхаа хүрээнд үйл ажиллагаа яаж зохицуулах юм? Тэр эвлэлдэн нэгдээд сайн дураараа. Тэр хүрээндээ ямархуу эрхтэй байх юм, ямар үүрэгтэй байх юм? Тэрүүгээрээ зохицуулагдаад л явбал уул нь зөв юм биш үү.

Үндсэндээ энэ чинь төрийн байгууллага болох гэж байна л даа. Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нэртэй төрийн бус байгууллага. Тэгээд би хуульд тусгагдсан. Хуулиараа ийм байгууллага учраас би ийм эрхтэй, ийм үүрэгтэй гээд бас хүнд суртал, бас юу гэдэг юм нөгөө бусад байгууллагуудаа, тур операторуудаараа нөгөө хэдэн жуулчны компаниудаа дарамталдаг. Би хуульд тусгагдсан эрхтэй байгууллага шүү. Та нар надтай битгий олон юм яриад байгаарай гээд л бас л хүнд суртал, бас л нэг шантайж, бас л нэг тийм дарамт, шахалт гарч ирэх гэж байна шүү дээ. Энд ямар ч энэ холбоо аялал жуулчлалын мэргэжлийн холбоог ингэж Их хуралтай, Их хурал нь ийм эрхтэй гэж бас тусгах шаардлага байхгүй.

Ер нь би бас төрийн зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллагад шилжүүлж байгаа. Зөв, уул нь бодлого зөв. Гэтэл цаанаа яг бодит амьдрал дээр амьдралыг хөрсөн дээр буугаад хэрэгжихдээ нөгөө мэргэжлийн холбоод чинь эрхээ илүү эдэлдэг, үүргээ биелүүлэхгүй байна шүү дээ. Үүргээ биелүүлэхгүй.

Гэтэл өнөөдөр хуульд зохицуулагдаагүй төрийн бус байгууллага

сайн дураараа эвлэлдэн нэгдээд, ажиллаж байгаа мөртөө эрхээ илүү эдлээд хүнд суртлын байгууллага болж эхэлж байхад түрүүчийнх нь одоо бүүр хуульд суулгаж өгч байгаад хуулиар тийм үү би хуульд заагдсан хуулийн байгууллага шүү, хуультай. Чи бол сайн дураараа хууль ч байхгүй, юу ч байхгүй нөхөр шүү гээд давуу эрх үндсэндээ бий болох гэж байна л даа.

Тэгээд ийм байдлаар энэ мэргэжлийн холбоо энэ 27 дугаар зүйл цаашилаад энэ мэргэжлийн холбоотой асуудлууд байх шаардлагагүй байх. 28, 29 гээд ингээд явж байна шүү дээ энэ чинь. Тийм, энэ 3 ерөөсөө хэлэлцэх шаардлагагүй. Тийм. Тэгээд л хуульд хийж байгаад л нөгөө аж ахуйн нэгж байгууллагаа, нөгөө хэдэн жуулчдыгаа дарамталдаг тийм дарамт давуу эрх л бий болгох гэж байна шүү дээ. Тийм, тэгэхээр энэ шаардлагагүй энийг хасах хэрэгтэй. Энийг анхны хэлэлцээрт буцаах, санал хураах шаардлагагүй гэж үзэж байна.

Л.Мөнхбаатар: Ингэе Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Би санал нэг байгаа юм. Бямбацогт гишүүний хэлсэнчлэн энэ чинь төрийн байгууллага болж хувирах гээд байна шүү дээ. Хуульд заагдсан үйл ажиллагаа явуулдаг, төрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах ийм байгууллага болох гээд байна шүү дээ. Энэ өөрсдийнхөө дүрмийн дагуу, хуулийнхаа дагуу эвлэлдэн нэгдээд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдээд ингээд явах ийм зарчим чинь алга болох гээд байна. Энэ 28.3.2 дээр хар даа аялал жуулчлалын салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлах нэмэлт, өөрчлөлт оруулах гэж байна.

Аялал жуулчлалын салбарт ажиллаж байгаа салбарын ажилтны мэргэжлийн ёс зүйн дүрмийг хуулиар нь баталж өгөөд, энийгээ хэрэгжүүлээгүй

бол яах вэ? Хууль зөрчсөн болох нь байна шүү дээ. Нөгөө эвлэлдэн нэгдэх сайн дураараа эвлэлдэн нэгдэх эд нар гэсэн юмнууд чинь яах юм. Ингээд хэрвээ холбоонд багтсан л бол чи ийм дүрэмтэй байна. Энэ хуулийг мөрдөнө гээд. Ингээд наад чинь ерөөсөө тэр эвлэлдэн нэгдэх, энэ холбоогоороо эрх ашигаа хамгаалуулах, өөрсдийн санал бодлоо холбоогоороо дамжуулж төр рүү дамжуулдаг энэ зарчим, систем чинь бүүр хуульчлагдаад, батлагдаад, хэрвээ хийхгүй бол хууль зөрчсөн хэрэгтэй болоод энэ магадгүй Зөрчлийн хуулиараа аягүй бол арга хэмжээ авагддаг болоод ингээд л явчих гээд байна шүү дээ.

Тэгэхээр ерөөсөө төрийн бус байгууллагыг авчирч ингэж нааж байгаа, хуульд оруулж байгаа энэ явдал чинь өөрөө болохгүй байна гээд олон гишүүн хэлж байна. Энийгээ ерөөсөө бараг л ч тэр зүйл, заалтаар нь тэгээд Удирдах зөвлөл нь тийм байна, Их хурал нь тийм байна, гүйцэтгэх засаглал нь тийм байна, гүйцэтгэх удирдлага нь тийм эрхтэй байна энэ хуульд чинь орчхоод байна. Тэгээд түрүүний гишүүний хэлчихсэнчлэн бүх л холбоонууд өөрсдөө өөрсдийнхөө салбарын хуульд оруулж ирэх гээд байна шүү дээ.

Тэгээд би бол энэ бүүр бүхэлд нь хасчихмаар л байна. Түрүүн тэр Батжаргал гишүүний хэлсэнчлэн төрийн зарим үйл ажиллагааг холбоо хэрэгжүүлж болно гэсэн нэг ийм сайхан заалт л оруулчихад тэгээд л болчихно шүү дээ. Хамтарч ажиллаж болно, гэрээ хийж болно ч гэдэг юм уу ингээд л явчихмаар байгаа байхгүй юу даа. Төрийн зарим үйл ажиллагааг төрийн бус байгууллагаар хийлгүүлнэ гэсэн нэг ийм зарчмыг л оруулчихмаар байна.

Л.Мөнхбаатар: Гишүүдээ ийм байгаа юм. Энэ заалт бол нь өргөн барьсан төсөл дээр байхгүй, Байнгын хорооноос нэмж байгаа заалт байгаа юм. Тийм учраас энэ саналыг дэмжихгүй бол

энэ санал унана гэсэн үг. Энэ холбоотой холбоотой зохицуулалт байна шүү дээ. 59, 60, 61 дэх санал бол та бүгдийн байх шаардлагагүй гэж сая хэлээд байгаа энэ заалтууд байгаа юм. Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлэх үү? Үг хэлээд дараачийнх нь санал хураалтаараа энийгээ ишийдээд явах боломж нь энэ чуулганы хуралдаанд байна гэсэн үг.

Х.Ганхуяг: Энэ холбооны асуудал яагаад орж ирсэн бэ гэхээр бид нар нөгөө энэ аялал жуулчлалын үйл ажиллагаат эрхлэхтэй холбоотой нэлээн олон тооны энэ тусгай зөвшөөрөл дагаж орж ирсэн. Энэ хуулиар. Тэр тусгай зөвшөөрлүүд нь бүгдийг нь байхгүй болгочихсон байхгүй юу. Тэгээд тэр бүртгэлийн асуудал заавал ч үгүй сөхөгдөөд ирж байгаа. Тэр түр оператор нь тэгээд хэн бүртгэх вэ? Түр агентыг нь хэн бүртгэх вэ? Одоо энд чинь 300-гаад төрийн бус байгууллага байна шүү дээ. Аялал жуулчлалын чиглэлтэй. Тэгээд тэр аялал жуулчлалын чиглэлийн тэр 300 төрийн бус байгууллагын аль нь тэр түр операторыг бүртгэх юм? Зөвшөөрөлгүй болгочихсон.

Дээрээс нь бид нар татварын хөнгөлөлт өгөх гэж байгаа. Тэгээд хил орчмын аялал жуулчлалын бүсэд түр операторууд үйл ажиллагаа явуулна гээд хилийн цэргийн Хил хамгаалах ерөнхий газартай гэрээ хийнэ гээд ороод ирчихсэн байгаа. НӨАТ-ын буцаалтын асуудал орж ирж байгаа. Энэ яг аялал жуулчлалыг дэмжих энэ хугацаанд энэ түр операторуудын энэ ашигийн татварыг нь бас орлогын албан татвараас бас хөнгөлөлт орж ирж байгаа. Тэгээд энэ чинь хэн бүртгэл хийх вэ? 300 төрийн бус байгууллага байна. Зарим төрийн бус байгууллага нь 1 ч гишүүнгүй, ганцхан гишүүнтэй төрийн бус байгууллагууд байна. Насаараа ингээд төрийн бус байгууллагын захирал хийсэн төрийн бус байгууллагууд байна.

Тэгэхээр чинь бид нар энд дунд нь нэг зохион байгуулалт хийж өгөөд,

дандаа бүх юмыг төр хийгээд байна гэж ерөөсөө болохгүй шүү дээ. Энэ яам чинь агентлаг байхгүй, аялал жуулчлалын агентлаг байхгүй. Ганцхан газартай тэр 4, 5-хан хүнтэй. Тэгээд энэ аялал жуулчлалын бодлогыг хэн хэрэгжүүлэх вэ? Төрийн байгууллага нэмж болохгүй гээд цөмөөрөө хаалт хийчихсэн. Тэгээд хувийн хэвшил нь төрийн бус байгууллага байгуулаад хамтраад явъя гэхэд нь бид нар ингээд өө энэ хуулиар ингээж болохгүй гээд яачихдаг. Тэгэхээр энэ 300 төрийн бус байгууллагын аль нь одоо энэ хуулиар эрх авах төрийн бус бус байгууллага байх вэ? Ингээд бид нар гаргалгаагаа олоод л ороод ирэнгүүт нь төрийн бус байгууллага байж болохгүй, та нар тэр өөрсдөө хоорондоо зохиц гээд. Тэд нар чинь зохицохгүй шүү дээ.

Тэгээд энийг бид нар ингээд нэг удаа анхны энэ юугаар нь ишийдээд явахгүй бол яг ний нуугүй хэлэхэд яг аялал жуулчлалын, мэргэжлийн аялал жуулчлалын компаниудыг төлөөлөх байгууллага нь хэн бэ гэдэг нь тодорхойгүй болчихоод байгаа байхгүй юу. Яг яам, Засгийн газар аялал жуулчлалын чиглэлээр хувийн хэшилтэй уулзъя гэхээр хэдэн төрийн бус байгууллагууд л ирдэг. Тэд нар нь бараг тэр үйл ажиллагаа явуулдаг ч юм уу, явуулдаггүй ч юм уу мэдэхгүй. Яг компаниудыг төлөөлөөд орж ирж байгаа төрийн бус байгууллага нь байхгүй байгаад байгаа байхгүй юу. Тэх, тэгээд энэ чинь ингээд бид нар ямар нэгэн байдлаар эхнийхээ тэр гарааныхаа юуг нь бүрдүүлж өгөхгүй бол бид нар энэ хууль цаашаа хэрэгжих, хэрэгжихгүй нь өөрөө асуудалтай болчих гээд байна шүү дээ.

Энэ үйл ажиллагааг нь шилэн байлгах, тэр менежментийг нь хэн нэгэн тэнчээ очиж захирлаараа насаар нь ажилладаг байх эд нарыг нь бид нар халчихсан юм. Ерөөсөө ганцхан удаа, Удирдах зөвлөлийн гишүүнд ганцхан удаа улиран сонгогдохгүйгээр ганцхан удаа Удирдах зөвлөлийн гишүүн байна. 1 удаа 3

жилээр. Иймэрхүү байдлаар шилэн байх, менежмент нь байнга хоорондоо тэр сэлгээний зарчмыг нь оруулж өгөөд ингээд явъя л гээд байсан ийм асуудлыг орж өгсөн байгаа.

Л.Мөнхбаатар: Та түрүүн үг аваад үг хэлчихсэн. Гишүүдийн яриад байгаа, Байнгын хороо хэлж болно. Ер нь ийм агуулга л байна шүү дээ Ганхуяг гишүүнээ аялал жуулчлалын ийм нэгдсэн холбоо байж болох талаар заалт байж болохоос биш ингээд холбооныхоо бүх дүрэмд байх ёстой бүх зүйлүүдийг, холбооны удирдах зөвлөл, хурал нь яаж хуралдах юм, гүйцэтгэх удирдлагын ажил гээд энэ бүх зүйлүүдийг нь ингээд хуульчилж байгаа нь зохимжгүй байна гэж Бямбацогт, Нямаагийн Энхболд, Бат-Эрдэнэ гишүүд яриад байна шүү дээ. Ийм учраас энийгээ та нарт нэг ийм юу байна. Хэрвээ энийгээ санал болгоод хэрвээ унах юм бол энэ заалт чинь тэр чигээрээ унана. Энэ 3 заалт байгаад байгаа юм.

Хэрвээ гүйцээн боловсруулах чиглэл аваад, энийгээ хасаад, товчхон томъёолоод тэр аялал жуулчлалын компаниудаа бүртгэдэг энэ тогтолцоо руугаа явах юм уу гэдэг л ийм асуулт байгаа юм. Алинаар нь явах юм? Гүйцээ. Хариуцсан Байнгын хороо, Цэрэнпунцаг гишүүн үг хэлье. Эдийн засгийн байнгын хорооны дарга товчхон яриарай.

Ц.Цэрэнпунцаг: Энийг Мөнхбаатар дарга гүйцээн боловсруулах чиглэл өгвөл хэрэгтэй байна. Энийг бид нар унагаад, аваад хаячих юм бол байна шүү дээ. Бид нар энд өнөөдөр энэ Аялал жуулчлалын хуулиа яриад байгаа, бас яаралтай оруулж ирээд яаралтай горимоор оруулж ирээд яваад байгааг бүгд мэдэж байгаа. Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг энэ эдийн засгийн тэргүүлэх салбар болгоно, энэ жил аялал жуулчлалын жил гээд зарлачихсан. Энэ дээр их ач холбогдол өгч байгаа. Тэгээд сая Энхболд гишүүн бүүр тодорхой хэллээ

шүү дээ. Энэ бол шинэ салбар. Энэ бол онцлогтой. Жишээлбэл бас л бид нарын айгаад байгаа шиг ингээд бусад олон чиглэл салбаруудаараа ингээд хуулиуд нь гараад, тэр гарсан хуулиуд нь ингээд тусдаа энэ холбоог нь ингээд тусад нь хуультай болгоод яваад байх юм уу гэж. Энэ бас болгоомжлол бас зүйтэй байх.

Тэгэхдээ энэ аялал жуулчлалын салбар өөрөө онцлогтой. Ялангуяа бид нар энэ аялал жуулчлал, үзэл санаа, энэ хуулийн гол үзэл санаа бол нутгийн иргэдэд түшиглэсэн ийм аялал жуулчлалыг бид нар хөгжүүлнэ гэж ярьж байгаа юм. Тэгэхээр энэ зүгээр нэг мэргэжлийн зөвхөн 20, 30 холбоо ч биш цаашидаа энэ бизнест оролцож байгаа тэр малчид, нутгийн иргэд, тэгээд л тээврийн жуулчин хүртэл тээвэрлэж явж байгаа компаниуд гээд энэ бол оролцож байгаа энэ оролцогчид бол их өргөн хүрээтэй, тоогоор ч гэсэн тэр. Салбар, чиглэл, мэргэжил, амьдарч байгаа газар нутгийн байрлалаар үзэх юм бол маш өргөн дэлгэр ийм салбар болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ салбарын ажлыг бид нар өнөөдөр авч явуулах, энийг бид нар ялангуяа өөрөө бие даасан агентлаг байхгүй, бүтэц байхгүй тийм үү? Ингээд энэ Байгаль орчин хамгаалах яамны энэ хажууд хавсарга явж байгаа энэ эдийн засгийн тэргүүлэх салбар болгох гээд байгаа энэ чиглэлээ бид нар энэ хувийн хэвшлийнхэнд нь энэ мэргэжлийн байгууллагууд нь энд оролцож, энэ бизнест оролцож эндээс үр шимийг нь, эдийн засгийн үр өгөөжийг нь хүртэж байгаа энэ хүмүүсийнх нь оролцоог хангахын тулд гарцаа байхгүй хувийн хэвшлийн энэ давуу талыг энд оруулж ирэх заавал шаардлагатай байгаа юм.

Тийм учраас сая энэ Ганхуяг ажлын хэсгийн ахлагч Ганхуяг гишүүн сайн тайлбарлалаа. Яагаад бид нар энэ холбоо нь чухал юм бэ гэхээр зэрэг энэ холбооны дүрмийг нь бас ганц нэг

тодорхой зүйлд тусгахгүй бол одоогийн, өнөөгийн мэргэжлийн холбоо дээр гардаг 1, 2 дархан суучихдаг, насаараа тэр холбоог ахлаад аваад явдаг нэг хэсэг бүлэг нөхдүүдийн гарт орчих вий гэсэндээ бид нар энэ хууль дээр нь тусгаж, хуульчилж өгье гэсэн санаа явж байгаа юм шүү.

Тийм учраас гишүүд минь та бүхэн сайн ойлгоорой энэ салбар бол онцлогтой. Та бүхэн бүгд мэдэж байгаа. Ингээд л бид нар нутагтаа, тойргоороо явахад малчид энэ аялал жуулчлалын салбарыг бүгд л бидэнд хамаатай юу, бид нар энд оролцох ямар боломж байна гэж харж байгаа.

Тэгэхээр энэ бүгдийг бид нар төрийн энэ ямаар ингээд төрийн мэдэлд ингээд бид нар бүгдийг нь энд хүрч ажиллана, энэ ажлыг бид нар энэ зорилтод хүрнэ гэх юм бол өнөөдөр бид нарт төрөөс энийг бид нар энэ салбарыг ингээд бид нарын зорьж бодож байгаа шиг энэ хууль гарснаар үр дүнд хүрнэ гэж харж байгаа үр дүнд энэ хүрчихнэ гэхэд хэцүү л байгаа.

Тийм учраас энийг бол бид нар чиглэл аваад, боловсруулаад тэр янз бүрийн жижиг буруу, зөрүүг нь янзлаад оруулж ирье л гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: Одоо ингээд тодорхой болчихсон доо. Батжаргал гишүүн. Жигжидийн Батжаргал гишүүн үг хэлье.

Ж.Батжаргал: Энэ мэргэжлийн холбоод эд нарын ач холбогдол, агуулга эд нарыг бид бууруулах гэж оролдоогүй. Энэ хууль өөрөө мэргэжлийн холбоодын харилцаа зохицуулж байгаа хууль юм уу, эс үгүй бол аялал жуулчлалынхаа хөгжлийг хангах гээд байгаа хууль юм уу? Энийгээ ялгаж үзмээр байна. Тэгээд тэр аялал жуулчлалын нэгдсэн холбоо гэж байгууллага байх юм байна, тэрэнд ийм ийм чиг үүрэг өгөх юм байна гэдэг юмаа л энэ хуульдаа оруулж өгье. Тэрнээс биш тэр мэргэжлийн холбооны дотоод зохион

байгуулалт, эрх хэмжээний асуудлыг энэ рүү оруулж ирэмгүй байна.

Тийм учраас гүйцээн боловсруулах чиглэл авахдаа энэ талынхаа юмыг бодмоор байна. Хэрвээ тэр мэргэжлийн холбооны асуудлыг нарийвчлах хэрэгтэй гээд байгаа бол холбогдох хуульд нь өөрчлөлт оруулахаар дагасан хуулийг нь оруулж ир. Тэгэхгүйгээр тухайн салбарын хууль ярихаар л тэр чиглэлийн мэргэжлийн холбоодын юм яриад байдаг байж болохгүй шүү дээ энэ чинь.

Л.Мөнхбаатар: Тодорхой байна. Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболд, Бямбацогт, Бат-Эрдэнэ, мөн Батжаргал гишүүдийн хэлсэн саналуудыг тусгаад, хүрээ хязгаарыг нь энэ хэмжээнд гэж ойлгоод ингээд 28 дугаар зүйлийг бүхэлд нь, 27 дугаар зүйлийг гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Өгөхдөө 3 зүйл байгаа. 27, 28, 29-ийг тус тусад нь уншиж байж гүйцээн боловсруулах чиглэл өгөх юм байна. Тийм учраас 27 дугаар зүйл дээр бас гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна.

28 холбооны. Энэ чинь 60 дугаар зүйл тийм ээ? Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 28 дугаар зүйл нэмэх:

“28 дугаар зүйл.Холбооны Удирдах зөвлөл

28.1.Холбооны Удирдах зөвлөл /цаашид “Удирдах зөвлөл” гэх/ нь Их хурлын чөлөөт цагт холбооны үйл ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын байгууллага байна.

28.2.Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.2.1.холбооны гүйцэтгэх удирдлагыг томилох, чөлөөлөх;

28.2.2.холбооны дүрэм, журмын хэрэгжилт, жилийн ажлын

төлөвлөгөө, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих;

28.2.3.холбооны их хурлыг зарлан хуралдуулах;

28.2.4.холбооны жилийн төсөв, ажлын төлөвлөгөөг батлах, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;

28.2.5.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

28.3.Удирдах зөвлөл 15 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тур оператороос 5, аялын агент, зочид буудал, жуулчны бааз, агаарын тээврийн үйлчилгээ үзүүлэгч компани болон аялал жуулчлалын үйлчилгээний бусад байгууллагаас тус бүр 2 төлөөллөөс бүрдэнэ.

28.4.Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд улируулан сонгохгүй.”.

Энэ дээр мөн гишүүдийн хэлсэн саналтай холбогдуулаад гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Эцсийн хэлэлцүүлэг дээр Эдийн засгийн байнгын хороо анхаараарай.

61.Төсөлд доор дурдсан агуулгатай Тавдугаар бүлгийн 29 дүгээр зүйл нэмэх:

“29 дүгээр зүйл.Холбооны гүйцэтгэх удирдлага

29.1.Холбооны гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийн хугацаа гурван жил байх бөгөөд улируулан сонгохгүй.

29.2.Холбооны гүйцэтгэх удирдлага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.2.1.холбоог гадаад, дотоод харилцаанд төлөөлөх;

29.2.2.холбооны үйл ажиллагааг удирдан явуулах;

29.2.3.холбооны төсөв, төлөвлөгөөг боловсруулах, батлуулах;

29.2.4.санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг хуульд заасан журмын дагуу гаргах, эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэх, холбогдох байгууллагад хүргүүлэх;

29.2.5.Удирдах зөвлөлөөс олгосон бүрэн эрхийн хүрээнд холбоог төлөөлөн гэрээ, хэлцэл хийх;

29.2.6.хууль болон холбооны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

29.3.Холбооны гүйцэтгэх удирдлага нь Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хорооны бүрэлдэхүүнд ажиллана.”. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ дээр мөн адил Эдийн засгийн байнгын хороонд эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэл өгч байна.

Санал хураалт явагдаж байгаа тул гишүүд танхимдаа орёё. Танхимдаа ор, санал хураалтдаа бэлдээрэй. 62 дугаар зүйл дээр санал хураана. Гишүүд байриллаа эзэлье.

Энхбаяр гишүүн суудалдаа суугаарай. Жаргалмаа гишүүн суудалдаа сууж санал хураалтдаа оролцёё. Хууль зүйн байнгын хорооны дарга Энхбаярыг дууд. Санал хураалтын бэлтгэл ажлыг Тамгын газрынхан хангаарай. Томьёоллыг уншиж танилцуулъя.

62.Төслийн Тавдугаар бүлгийн гарчгийг “ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт гишүүдээ.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн санал гаргая, горимын санал гаргая. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгөөрэй горимын

санал гаргана. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Би горимын санал гаргаж байна. Саяын саналыг дахин хураалгаж өгөөч.

Л.Мөнхбаатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний гаргасан горимын саналаар санал хураая. Уг саналыг хүчингүйд тооцох санал хураалт явуулъя. Санал хураалт.

51.2 хувиар санал дэмжигдлээ. Үндсэн санал хураалтыг явуулъя. Томъёоллыг уншиж танилцуулсан. Гишүүдээ анхааралтай санал хураалт.

Санал 51.2 хувиар дэмжигдлээ.

63.Төслийн 28 дугаар зүйлийг Зургаадугаар бүлгийн 30 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“30 дугаар зүйл.Аялал жуулчлалын мэдээллийн сан

30.1.Аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ, статистик мэдээллийн нэгдсэн сан /цаашид “Аялал жуулчлалын мэдээллийн сан” гэх/-г аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим хэлбэрээр бүрдүүлнэ.

30.2.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь дараах мэдээллээс бүрдэнэ:

30.2.1.хууль тогтоомжийн болон салбарын хүний нөөцийн мэдээлэл;

30.2.2.дотоодын болон олон улсын жуулчны тоон мэдээлэл;

30.2.3.аялал жуулчлалын байгууллагын бүртгэл, мэдээлэл;

30.2.4.улсын, орон нутгийн, хил орчмын аялал жуулчлалын бүс, маршрутын мэдээлэл;

30.2.5.олон улсын, улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух үйлчилгээний байгууламжийн мэдээлэл;

30.2.6.энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан отоглох цэгийн мэдээлэл;

30.2.7.энэ хуулийн 16.5-д заасан жуулчдад учирч болзошгүй аюул, халдварт өвчин, тахал болон зорчиход аюултай газар, байршлын талаарх мэдээлэл.

30.3.Аялал жуулчлалын мэдээллийн сан нь нийтэд нээлттэй байна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал 55 хувиар санал дэмжигдлээ.

64.Төслийн 29 дүгээр зүйлийн 29.4, 29.5 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

65.Төслийн 29.2, 29.3, 29.6 дахь хэсгийг 32 дугаар зүйл болгож, зүйлийн гарчгийг “32 дугаар зүйл.Аялал жуулчлалын үйл ажиллагаанд тавих төрийн хяналт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

66.Төслийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“33.1.1.аялал жуулчлалын хууль тогтоомжийг зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллагад гаргаж, шийдвэрлүүлэх;”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Улсын Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа горимын санал гаргая.

С.Одонтуяа: Үнэхээр ажилласангүй сая. Дэд дарга энэ сая би уг нь дэмжиж санал өгсөн юм. Тэгсэн чинь энэ нь ингээд ажилласангүй. Тэгэхээр энэ санал хураалтыг хүчингүй болгох санал хураалгаж өгнө үү.

Л.Мөнхбаатар: Одонтуяа даргын гаргасан горимын саналаар уг санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалтыг явуулъя. Санал хураалт. Гишүүдээ байрлалаа эзлээрэй.

52.5 хувиар хүчингүйд тооцох санал дэмжигдлээ. Үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалтын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

67.Төслийн 32 дугаар зүйлийг 35 дугаар зүйл болгон доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“35 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт

35.1.Энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулах хурлыг аялал жуулчлалын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хууль батлагдсан өдрөөс хойш 90 хоногийн дотор зохион байгуулна.

35.2.Энэ хууль батлагдсан өдрөөс өмнө байгуулагдан аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага хамтран энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг үүсгэн байгуулна.

Тийм, энэ өмнөх гүйцээн боловсруулах чиглэл өгсөн зүйлтэй

холбогдох зорилттой байна. Би уншиж танилцуулчхаад чиглэл өгчихье.

35.3.Аялал жуулчлалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 35.1-д заасан хуралд оролцох байгууллагыг нээлттэй бүртгэх ба тур оператор, аяллын агент, аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын зохистой харьцааг хангаж хурлыг зохион байгуулна.

35.4.Энэ хуулийн 6.5-д заасны дагуу тур оператор, аяллын агент нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор энэ хуулийн 26.1-д заасан нийтийн эрх зүйн хуулийн этгээдэд бүртгүүлнэ.

Энэ дээр гүйцээн боловсруулах чиглэл өгчихье. Яагаад гэхээр өмнө төсөлд байсан 27, 28, 29 дүгээр зүйл дээр гүйцээн боловсруулах чиглэл өгсөн байгаа. Энэнтэй хоорондоо уялдаатай төслийн заалт учраас гүйцээн боловсруулах чиглэлийг Эдийн засгийн байнгын хороонд өгч байна.

68.Төслийн 33 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

69.Төслийн “хөтөч” гэснийг “хөтөч-тайлбарлагч” гэж тохиолдол бүрд агуулгад нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

70.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн нэр томъёог жигдлэх, зүйл, хэсэг, заалт, шилэлийн дугаарыг нийцүүлэн өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

*Найруулгын саналууд байна.
Уншиж танилцуулъя.*

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “үндэсний онцлог бүхий байгаль” гэснийг “байгаль, үндэсний онцлог бүхий” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтын “худалдах,” гэснийг “худалдан” гэж, 10 дугаар зүйлийн 10.2.1 дэх заалтын “энгэрийн тэмдэг, үнэмлэхийг” гэснийг “үнэмлэх, энгэрийн тэмдэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.5 хэсгийн “хариуцсан” гэснийг “эрхэлсэн” гэж, 21 дүгээр зүйлийн 21.1.1 дэх заалтын, мөн 23 дугаар зүйлийн 23.1.1 дэх заалтын “төрийн” гэснийг “төрөөс баримтлах” гэж, 21.1.5 дахь заалтын “харилцааг” гэснийг “харьцааг” гэж, “23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заалтын “газар нутгийнхаа” гэснийг “нутаг дэвсгэрийнхээ” гэж, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “бодлого, зорилтот хөтөлбөрийн” гэснийг “бодлогын” гэж, 24.1.14 дэх заалтын “жуулчин, аялагчийн” гэснийг “жуулчны” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “эрх,” гэснийг, 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсгийн “аялагч болон” гэснийг, 16 дугаар зүйлийн 16.3 дахь хэсгийн “, аялагч” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.4 дэх заалтын “ажлыг хөгжүүлэх” гэснийг, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “тухай” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь заалтын “зохион байгуулах” гэсний өмнө “аялал” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын “борлуулах” гэсний өмнө “худалдан” гэж, 21 дүгээр зүйлийн 21.2.4 дэх заалтын “аялал жуулчлалын” гэсний дараа “асуудлаар” гэж тус тус нэмэх.

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

Аялал жуулчлалын тухай хуулийн үндсэн санал хураалтууд дуусааж байна. Одоо дагасан хуулиудын санал хураалт явагдана.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Нэг. Эдийн засгийн байнгын хороо дэмжсэн санал.

Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэрийн “НЭМЭЛТ,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Ануужин гишүүн горимын санал гаргая.

П.Ануужин: Энэ сүүлийн 2 өдөр миний тоног төхөөрөмж бас болохгүй байгаад байгаа юм. Техникийн ажилтнууд мэдэж байгаа. Тэгэхээр бас олон санал өгсөн хэр нь эсрэг гараад байна. Тэгээд тэр бүрийг бас хэлэх боломж олдохгүй байгаад байна. Тэгээд энэ удаад ч гэсэн бас эсрэг гарчихлаа. Саяын явуулсан санал хураалтыг хүчингүй болгож өгнө үү.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын Тамгын газар, техникийн хэлтсийнхэн Ануужин гишүүний тоног төхөөрөмжийг бас үзэж шалгаж өгөөрэй.

Ануужин гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Хүчингүйд тооцох санал хураалт. Санал хураалт.

52.5 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “374 дүгээр зүйлийн” гэсний дараа “374.1,” гэж, мөн зүйлийн “373.4 дэх хэсгийн

“аялал жуулчлал” гэсний дараа “зохион байгуулагч” гэж, “372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг,” гэсний өмнө “372 дугаар зүйлийн. За. Тийм байна. Сая хүчингүйд тооцсон санал хураалт явагдсан. Тийм болохоор өмнөх томъёоллыг уншиж танилцуулсан санал хураалтыг явуулъя. Үндсэн санал хураалтыг явуулъя. Санал хураалт гишүүдээ.

51.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн “374 дүгээр зүйлийн” гэсний дараа “374.1,” гэж, мөн зүйлийн “373.4 дэх хэсгийн “аялал жуулчлал” гэсний дараа “зохион байгуулагч” гэж, “372 дугаар зүйлийн 372.3 дахь хэсэг,” гэсний өмнө “372 дугаар зүйлийн 372.2 дахь хэсгийн “Аялал зохион байгуулагч” гэснийг “Тур оператор, аяллын агент” гэж,” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

53.8 хувиар санал дэмжигдлээ.

Засгийн газрын тусгай сангийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Нэг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын “21 дүгээр зүйлийн 21.1.15 дахь заалт.” гэснийг “22 дугаар зүйлийн 22.5.12 дахь заалт.” гэж, мөн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалт буюу 22 дугаар зүйлийн 22.9 дэх хэсгийн дугаарыг “22 дугаар зүйлийн 22.5.13 дахь заалт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн “22.9-д” гэснийг “22.5.13-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх. Одоо энэ танилцуулах гэж байгаа заалт дээрээ хэлж байгаа юм уу? Уншаад дууссаныхаа дараа хэлэх үү?

Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Нэг. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөх.

“1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 10.14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“10.14.Аялал жуулчлалын тухай хууль зөрчих

1.Тур оператор, эсхүл аяллын агентын үйл ажиллагааг эрхлэхдээ хуульд заасан бүртгэл хийлгээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван

мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллага нь үйлчилгээний стандарт, техникийн зохицуулалт, зэрэглэлд тавигдах шаардлагыг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.". Санал гаргасан ажлын хэсэг гэсэн байна.

Энэ дээр яах юм үг авах юм уу? Энэ дээр Ганхуяг. Шууд авчих юм уу? Энэ Зөрчлийн хуульд оруулж байгаа энэ нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцээн боловсруулах чиглэлийг өгч байна. Эдийн засгийн байнгын хороонд өгч байна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн "нэг хоногоос" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 15 дугаар зүйлийн 15.5¹ дэх хэсгийн дугаарыг "15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсэг" болгож, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 15 дугаар зүйлийн 15.16, 15.17, 15.18 дахь хэсгийн дугаарыг "15 дугаар зүйлийн 15.17, 15.18, 15.19 дэх хэсэг" болгож, мөн зүйлийн 2 дахь заалтын 15.16 дахь хэсгийн, 15.17 дахь хэсгийн, 15.18 дахь хэсгийн "15.5¹ гэснийг "15.6" гэж, 15.18 дахь хэсгийн "15.16.4-т" гэснийг "15.17.4-т" гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

"2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.9 дэх хэсгийн "15.5" гэсний дараа ", 15.6" гэж нэмсүгэй.". Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

56.4 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн "эрхэлдэг" гэсний дараа "хуулийн этгээд" гэж, "өөрчилсүгэй." гэсний өмнө ", 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн "15.6-д" гэснийг "15.7, 15.18-д" гэж, мөн зүйлийн 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15 дахь хэсгийн дугаарыг "15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.12, 15.13, 15.14, 15.15, 15.16" гэж тус тус" гэж нэмэх. Санал гаргасан ажил ажлын хэсэг. Санал хураалт.

59 хувиар санал дэмжигдлээ.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал байна. Гишүүд бас саналаа өгөхдөө өөрсдөө анхааралтай хандаарай. Дэмжээгүй санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

"1/13 дугаар зүйлийн 13.5.21, 13.5.22, 13.5.23 дахь заалт:

13.5.21.орон нутгийн агаарын тээврийн үйлчилгээ;
13.5.22.олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;
13.5.23.иргэний агаарын хөлгийн түрээсийн үйлчилгээ."

Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлье.

С.Бямбацогт: Энэ өнгөрсөн 22 оны 11 сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурал 23 оны төсөв баталсан юм. Тэгээд төсөв батлахтай холбогдуулан Улсын Их Хурлын төсвийн 23 оны төсвийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Улсын Их Хурлын тогтоол гаргасан. Энэ тогтоолын 11 дэх заалт дээр нь орон нутагт байнга оршин сууж байгаа иргэдийн орон нутгийн нислэгийн тийзийн үнийг хямдруулах талаар Засгийн газарт үүрэг болгосон. Улсын Их Хурлын тогтоолоор. Засгийн газар бас надад энэ орон Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг бас өгчихсөн байгаа юм.

Үүнтэй холбоотойгоор ингээд орон нутгийн нислэг хямдруулах гээд орон нутгийн нислэгийн тоо нэмэгдүүлэхэд бас манай нислэгийн авиа компаниудын бас тавьж байгаа шаардлага нь орон нутгийн нислэгийг нэмэгдсэн өртгийн албан татваргүй болгож өгөөч гэсэн хүсэлт тавиад байгаа юм. Өнөөдөр үндсэндээ нийтийн тээвэрт гадаад нислэг НӨАТ-гүй байгаа. Дээрээс нь төмөр замын тээвэр НӨАТ-гүй байгаа. Мөн хот хоорондын тээвэр НӨАТ-гүй, мөн Улаанбаатар хотын нийтийн тээвэр НӨАТ-гүй байгаа юм. Ганцхан орон нутгийн дотоод нислэг л НӨАТ-тай байгаад байгаа юм.

Тийм болохоор бусадтайгаа адилхан болгоод л НӨАТ-аас нь чөлөөлчихье гэдэг асуудлыг хөндсөн юм. Нэг.

Хоёрдугаарт нь олон улс орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ, олон улс, орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ дээр нэмэгдсэн өртгийн албан татвар авдаг юм. Гадаад нислэг дээр үндсэндээ нэмэгдсэн өртгийн албан татвар авдаггүй юу яаж байгаа юм. Гадаад нислэг дээр нисэх буудлын үйлчилгээний үндсэн дээр 70 орчим доллар, одоогоор 250 орчим мянган төгрөгийн хураамж төлж байгаа юм. Энэ хураамжийг бас багасгах шаардлага

байгаа юм. Тийм болохоор нисэх буудлын үйлчилгээгээс бас НӨАТ-аас нь чөлөөлөх шаардлагатай болчихоод байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол иргэний агаарын тээврийн хөлгийн түрээсийн үйлчилгээ. Өнөөдөр Монгол Улсын эдийн засгийн чадавх сул байна. Иргэний агаарын дотор авиа компаниудын бас санхүүгийн бололцоо боломж тааруухан. Тийм болохоор онгоцыг түрээсэлж байгаа. МИАТ компани л хэдэн өөрийн өмчийн онгоцтой болохоос бусад нь бүгд гаднаас онгоц түрээсэлж байгаа. Түрээс дээр нь дахиад НӨАТ аваад байхаар дахиад л нөгөө түрээсийн төлбөр, дахиад л нөгөө тийзийн үнэ нэмэгдээд байгаа юм л даа.

Тийм болохоор НӨАТ-аас нь чөлөөлж өгье гэсэн ийм 3 асуудлыг ажлын хэсэг оруулж ирсэн юм байна лээ. Энийг бас ингээд уул нь дэмжээд өгчих юм бол ганцхан дотоод нислэг НӨАТ-гүй, бусад гадаад нислэг НӨАТ, юу дотоод нислэг НӨАТ-тай, гадаад нислэг НӨАТ-гүй, зорчигч тээвэр НӨАТ-гүй, төмөр замын тээвэр НӨАТ-гүй байж байгаа энэ асуудлуудаа адилхан л болгочихъё гэж байгаа юм.

Тэгээд гишүүдийг нь бас ойлгоод Их Хурлаас өгсөн үүрэг даалгавар бас биелүүлэх боломжийг хангаж өгөөч гэж Их Хурлын гишүүдээсээ хүсье. Тэгээд адилхан болгоё гэж байгаа юм.

Л.Мөнхбаатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн үг хэлье.

Ш.Адьяа: Зүгээр энд Бямбацогт бид 2 хэрэлдээд байгаа асуудал биш. Энэ өнөөдөр энэ Эдийн засгийн байнгын хороон дээр энэ санал дэмжигдээгүй. Хууль тогтоомжийн тухай хууль гэж байгаа. Төсөв хөрөнгөтэй, татвартай холбоотой асуудлыг Засгийн газрын энэ асуудал хариуцсан сайд оруулж ирнэ гэсэн. Засгийн газрын 2 сайд 2 талаас 2 өөр юм яриад, бодлогоо зөрчилдсөн ийм

асуудал байгаа. Энэ асуудлыг яагаад ингэж Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй, ажлын хэсэг миний бие дэмжээгүй гэхлээр энэ Нэмэгдсэн өргөдлийн албан татварын тухай хуулийг зүгээр нэг компани зориулаад ингээд өөрчлөөд байх асуудал цаашидаа явах юм уу. Нэг хууль батлахаар нэг татвар өөрчилдөг, нэг компанид үйлчилсэн ийм хууль Монгол Улсын Их Хурал гаргаад байх юм уу гэдэг асуудал ярьж байгаа юм. Тэрнээс биш энд хөдөө орон нутагт хямд үйлчилгээтэй ийм зүйл бий болгох энэ ард түмний эрх ашгийг маш их дэмждэг.

Тэгэхдээ энэ дээр Засгийн газрын ийм 2 өөр бодолтой 2 сайд нь ингээд яриад байгаа нь хамтын нэгдмэл бодлого байхгүй байгаа. Хоёрдугаарт нь нэг компанид зориулсан ийм нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг энэ Улсын Их Хурал баталдаг юм уу? Энэ асуудал байгаа учраас Эдийн засгийн байнгын хороо дэмжээгүй. Би ийм эсрэг санал өгсөн юм.

Тэрнээс биш өнөөдөр хөдөө орон нутагт үнэхээр тэр компаниудыг дэмжих гэж байгаа бол татаас олгоё, татаас олгоё. Татаас олгоё. Тэгэхгүй бол энэ чинь ингээд компанийн гадаадаас түрээсэлж байгаа онгоцны НӨАТ-ыг чөлөөлөөд, нэг онгоцны буудлын НӨАТ-ыг чөлөөлөөд байх юм бол энэ Монгол Улс чинь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль гэж үйлчлэх энэ хууль цаашидаа явах шаардлага байна уу гэдэг ийм л байр суурьтай учраас ажлын хэсэг дээр ч ийм эсрэг байр суурьтай байсан. Эдийн засгийн байнгын хороо ч дэмжээгүй.

Л.Мөнхбаатар: Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн. Тогтохсүрэн гишүүн үг хэлэх юм уу? Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Үгүй, боль гэж наадах чинь ийм байна. Энийг нэгдүгээрт санал хураамааргүй байна. Яагаад гэвэл

энэ чинь аягүй цөөхөн гишүүн. Яагаад гэвэл Байнгын хороо энэ дэмжихгүй болохоор босчих байхгүй юу. Засгийн газар дэмжихгүй гээд хэлж байхад Бямбацогт гишүүн ч гэсэн энэ дээр бас тийм Засгийн газрын гишүүн шиг байх хэрэгтэй байхгүй юу. Засгийн газар дэмжихгүй гээд саналаа өгчихсөн сая. Тэгээд би энэ дээр санал хураалгамааргүй байна. Тийм, дараа гишүүний ирцтэй тийм үед, одоо өдөр ундны цаг болчихсон байна. Тийм учраас би чуулганыг завсарлуулаад үдээс хойш гэж хэлэх гэж байна.

Л.Мөнхбаатар: Шатарбалын Раднаасэд гишүүн үг хэлье.

Ш.Раднаасэд: Би үг хэлье Тогтохсүрэн даргаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд чимээгүй байя. Раднаасэд гишүүнд үг хэлэх боломж олгоё.

Ш.Раднаасэд: Энэ зовлон ойлгохгүй л байгаа юм л даа. Ялангуяа энэ нислэгтэй аймгууд дээр гардаг зовлон шүү дээ. Энэ улсын төсөв дагаж батлагдсан Их Хурлын тогтоол байхгүй юу хийнэ гээд. Цөөхөн аймгууд руу нислэг үйлдэгдэж байгаа. Арай ч би энэ Улсын Их Хурлаар баталсан 23 оны Улсын төсөвтэй холбогдуулж дагаж гарсан тогтоол дээр бид нар нэгийг нь дэмжээд баталчихсан юм шүү дээ энийг чинь. Тэгээд энийг дэмжээд явах ёстой гэж би бодоод байгаа юм. Энэ Адьшаа гишүүн Ховд руу уул нь онгоц нисэж байх ёстой доо. Ховдын ард иргэд уул нь хямдхан нисэж байвал бидэнд хэрэгтэй. Манай аймаг руу бас нисэх ёстой. Нисэхгүй байна. Тийм нисэх ёстой.

Тэгээд та хоёрын зөрчил чинь ерөөсөө энэ аймгуудын нислэгийн асуудал биш байхгүй юу. Та 2-ын зөрчил бол та хоёрын л зөрчил. Энэнээс чинь болж хүмүүс хохирох ёсгүй байхгүй юу. Тийм учраас энийг дэмжээд явах ёстой гэж

бодож байгаа. Энэ дахиад энэ төсөв дагаж гарсан тогтоолын хэрэгжилтийг эргээд бид нар Их Хурал дээр ярих хэрэгтэй болно шүү дээ. Тэгээд эндээс нэгд НӨАТ-д хэдэн хувийн татвар цуглардаг юм гэхээр тэр өттэй ч цугларалт байхгүй байгаа байхгүй юу. Татан төвлөрүүлж байгаа орлогыг нь харахаар татварынх нь. Тийм учраас би энэ заалтыг дэмжээд явах нь зүйтэй гэсэн саналтай байна. Одоо ирч хүрч байгаа юм чинь энэ саналаа хураачихвал ер нь яадаг юм?

Л.Мөнхбаатар: Хөвсгөл рүү яана гэнэ ээ? Хөвсгөл рүү үнэ буурах уу? За. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалтыг. Ганболд гишүүн, Гочоогийн Ганболд гишүүн үг хэлье.

Г.Ганболд: Бид нар аялал жуулчлалын хууль хэлэлцэж байгаа л даа Ганхуяг даргаа. Тэгэхээр бид нар чинь нөгөө жуулчид гэхээр зэрэг орон нутгийн иргэд чинь хамрагдахгүй болчихоод байдаг энд. Орон нутгийн иргэд бол хамрагдахгүй нь байна шүү дээ. Жуулчдад хамрагдах юм бол энэ чинь жуулчин гэхээр чинь бид нар чинь 1-ээс дээш хоногоор л очиж байгаа хүмүүсийг хэлж байгаа биз дээ. Тэгэхээр чинь яг энэ Аялал жуулчлалын хуулиар дагуулж орж ирэх юм бол энэ чинь харин жуулчлалаар очиж байгаа хүмүүст хөнгөлөлт үзүүлээд, орон нутгийн иргэд чинь харин хөнгөлөлт эдлэхгүй юм болно шүү дээ. Би бол яг энэ хуулиар, энэ аялал жуулчлалын хуулиар тэгж л ойлгоод байна шүү дээ. Жуулчин гэж бид нар юуг хэлж байгаа юм. Тэнд ажиллах гэж очиж байгаа, мөнгөө төлөх гэж очиж байгаа хүмүүсийг хэлж байгаа биз дээ?

Гэтэл эсрэгээрээ энэ чинь Бямбацогт сайдын хэлж байгаагаар бол орон нутгийн харьяалалтай иргэдэд нь НӨАТ-аас чөлөөлөх юм яриад, жуулчлалаар очих хүмүүс чинь энэ чинь харин харьяалагдахгүй болох гээд байгаа

юм биш үү? Тэгэх юм бол бүх хүмүүс хамаарагдана гэж ойлгох юм байна тээ? За за.

Л.Мөнхбаатар: Их Хурлын дэд дарга Салдангийн Одонтуяа үг хэлье. Ингээд санал хураалтаа явуулна.

С.Одонтуяа: Тэгэхээр би Монгол Ардын намынханд маш олон удаа хэлдэг энэ татвараар улс орон хөгждөггүй юм. Татвар нэмсэн чинь нэг шальтай нэмэлт ч болохгүй. Бид яаж хөгжих вэ гэхээр энэ аялал жуулчлалаа хөгжүүлье гэж байгаа бол хөгжүүлсэн шиг хөгжүүлье. Тэр байтугай НӨАТ-аас хэмнэснээс чинь байтугай их мөнгө орж ирнэ. Энэ улс орныхоо хилийг нээ, энэ олон онгоцоо нисгэ, гадаад, дотоодын хүмүүст чинь энэ дотоодын нислэг чинь бүүр үнэтэй байна шүү дээ. Тэгэхээр тэр байтугай хэмнэсэн мөнгийг олно гэж бодож том утгаар нь би ажил л гэж хэлмээр байна. Би нарийн ширийн тэр доторх судалгааг нь мэдэхгүй байна.

Гэхдээ бид нар Монгол Улсын хамгийн гол хөгжлийн түлхүүр бол аялал жуулчлалын салбар шүү. Монголд өнөөдөр нэг их олон гайхуулаад байх салбар байхгүй. Энэ Монгол Улсад чинь хүмүүс ирээд энэ сайхан газар нутгийг нь үзье, аялъя, жуулчилъя гэж ирэхэд хэчнээн үнэтэй билеттэй энэ чинь нисэхгүй шүү дээ. Тийм учраас би эдийн засагч хүнийхээ хувьд энэ дандаа татвар, татвар, татвар гэж улс орон хөгждөг юм шиг биш. Тийм учраас энэ заалтыг бол би дэмжиж байна.

Л.Мөнхбаатар: Ер нь одоо цаашаа явъя хэдүүлээ. Одоо 10 санал хураалт явагдаад энэ хууль болон дагалдах хуулиудын санал хураалт дуусна. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хурааж байна. Санал хураалт.

17.5 хувь нь дэмжсэн байна. Уг санал дэмжигдсэнгүй буюу уг Эдийн засгийн байнгын хорооны дэмжээгүй санал дэмжигдсэн гэсэн үг. Дэмжигдээгүй, дэмжигдсэнгүй. Эдийн засгийн байнгын хорооны санал дэмжигдсэнгүй гэсэн үг. Дараагийн санал хураалтдаа оръё.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Биш энэ Зөвшөөрлийн тухай хуульд. Зөвшөөрлийн тухай хууль дээр хуулийн төслийг нь санаачлагч нь буцаах ийм томъёолол байгаа шүү. Санал хураалт.

60 хувиар санал дэмжигдлээ.

Ан амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн үг хэлье.

Д.Тогтохсүрэн: Энэ аягүй чухал хууль байхгүй юу. Ерөнхий сайд бүүр өөрөө хүртэл хэвлэлийн хурлыг зарлаж байгаад явсан шүү дээ Бат-Эрдэнээ, Ганхуягаа. Та нар аягүй лоббид автагдаж байна шүү дээ шуудхан хэлэхэд. Яагаад вэ гэхээр энэ нэгдүгээрт ан амьтныг дуудлага худалдаагаар явуулъя гэсэн юм. Тэр нь үнэ нэмэгдэнэ шүү дээ. Дуудлага худалдаа хэрэгтэй шүү дээ Монголд.

Хоёрдугаарт, орж байгаа орлогынх нь 20 хувийг ан амьтан хамгаалахад өгье гэсэн, орон нутагт нь өгье гэсэн байхгүй юу. Тэгсэн чинь энэ хуулийг буцаая гэж байгаа байхгүй юу Ганхуягаа. Ингээж ашиг сонирхлын зөрчил гаргаж болохгүй. Тийм учраас миний санал бол энэ хуулийг буцааж болохгүй. Хэлэлцүүл гэдэг санал хэлэх гээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Санал хураалтаа явуулъя. Хассуурийн Ганхуяг. Хассуурийн Ганхуяг гишүүн суудалдаа суу. Гишүүд суудалдаа суу. Саналын томъёоллыг уншиж танилцуулсан Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал. Төслийг хууль санаачлагчид нь буцаах санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

23.7 хувиар санал дэмжигдсэнгүй. Цаашаа явъя.

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.1.12 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Тогтохсүрэн дарга, Хассуурийн Ганхуяг гишүүн 2 саналаа өг. Санал хураалт.

55.3 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 1 дүгээр зүйл буюу 29.13 дахь заалтын “отоглох цэгээр” гэсний өмнө “улсын тусгай хамгаалалттай газар нутгаас бусад газарт байрлах” гэж нэмж, заалтын дугаарыг “29.1.12” болгож өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт, санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 2 дугаар зүйлийн “29.1.13,” гэснийг “29.1.12,” гэж

өөрчлөх. Санал гасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 3 дугаар зүйлийн “29.1.1-29.1.12 дахь заалт” гэснийг “29 дүгээр зүйлийн 29.1.1-29.1.11 дэх заалт” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг танилцуулъя. Эдийн засгийн байнгын хорооны дэмжсэн санал байна.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 1 дэх заалт нэмэх:

1/33 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр байгаль хамгаалал, соёл, аялал жуулчлалыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах шаардлагаар төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглахтай холбоотой харилцаанд энэ хуулийн 27.12-т заасан журам үйлчлэхгүй бөгөөд хүсэлтийг үндэслэн гэрээ байгуулж ашиглуулна.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Тэгвэл явлаа шүү. 50 хувиар санал дэмжигдсэнгүй. Цаашаа.

2.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2/33 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10-д заасан аялал жуулчлалын дэд бүтцийг

хөгжүүлэх, бий болгох зорилгоор газар ашиглах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд газар ашиглах эрх олгоход мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д заасан төлөвлөгөөнд тусгагдсан газарт Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 10-т заасныг үндэслэн сонгон шалгаруулалтыг хялбаршуулсан журмаар энэ хуульд заасны дагуу явуулж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52.6 хувиар санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь заалт нэмэх:

3/36¹ дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5.Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах тохиолдолд энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан тухайн тусгай хамгаалалттай газар нутгийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг үндэслэхгүй байж болно.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. Цэрэнпунцаг гишүүн саналаа өгөөрэй.

57.9 хувиар санал дэмжигдлээ. Дараагийн санал хураалтыг явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмэх:

4/36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалт:

“2/Энэ хуулийн 33 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хялбаршуулсан журмаар сонгон шалгаруулалтыг явуулах зарыг уг ажиллагааг явуулахаар товлосон өдрөөс 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар болон өдөр тутмын хэвлэлээр нийтэд мэдээлнэ.” . Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

57.9 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь заалт буюу 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалтыг хасах. Санал гасан ажлын хэсэг. Санал хураалт.

60.5 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 36² дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3 дахь заалтын дугаарыг “3, 4” гэж өөрчилсүгэй.”. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалтыг түдгэлзүүлье. Нямаагийн Энхболд гишүүн уг хэлье.

Н.Энхболд: Тэр амьтны тухай хуулийн юман дээр загас, амьтан 2-ыг ялгаж үзэх хэрэгтэй шүү. Энэ чинь өөр. Бариад тавьчихдаг байхгүй юу. Өөрөө бас тэр чинь зөвхөн гаднын мөнгөтэй улсууд ч биш, дотоодод ч хэрэглэгддэг ийм заалт байх ёстой гэж би бодоод байна. Тэгэхээр энийг яах юм? Сая хууль нь буцчих уу? Энэ чинь яачхав? Тийм үү тэрийг ялгаж үзэх хэрэгтэй шүү. Байнгын хороо Ганхуяг гишүүнээ анхаараарай та ажлын хэсэг дээр. Загас, амьтан 2-ыг.

Л.Мөнхбаатар: Нямаагийн Энхболд гишүүн бас үндэслэлтэй зүйл яриада байна. Тийм учраас сая энэ хуулийг хэлэлцэхээр болсон. Тэр хуулийн төсөл дээр хэлэлцэх үедээ, эцсийн хэлэлцүүлэг дээр гүйцээн боловсруулах чиглэлийг бас өгч байна. Энэ зүйлийг Нямаагийн Энхболд гишүүний хэлсэн үндэслэлийн хүрээнд гүйцээн боловсруулах нь зүйтэй гэдэг чиглэлийг өгч байна.

Саналын томъёоллыг уншиж танилцуулсан. Санал хураалт, санал хураалт гишүүдээ.

63.2 хувиар санал дэмжигдлээ. Эдийн засгийн байнгын хороо саяынхаа

саналын томъёоллыг Улсын Их Хурлын Тамгын газартай ярьж байгаарай. Энэ хооронд би баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсгоё.

1.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Энэ хуультай холбогдуулан боловсруулсан “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Чуулганы хуралдааны дараа Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл хуралдана Улсын Их Хурлын даргын хүрээнд хуралдана. Байнгын хорооны дарга, гишүүд оролцоорой.

Хэлэлцэх асуудал дууссан тул үдээс өмнөх чуулганы хуралдааныг завсарлуулж байна.

13.22 цаг

Баасан гараг 28 Дөрөвдүгээр сар 2023
Төрийн ордон “Их хуралдай” танхим
14 цаг 07 минут.

ҮДЭЭС ХОЙШИХ НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2023 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Дөрөв.Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягаас Эрчим хүчний сайдад хандаж “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын

талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

Асуулт, хариултын цаг эхлэх гэж байгаа учраас гишүүд чуулганы танхим цуглана. Хэлэлцэх асуудалдаа орёё.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягаас “Эрчим хүчний сайдад хандаж эрчим хүчний хангамжийн найдвартай байдлын талаар тавьсан асуулгын хариуг Эрчим хүчний сайд Улсын Их Хурлын гишүүн Баттогтохын Чойжилсүрэн хариулна. Индэрт урьж байна.

Эрчим хүчний асуудал сонирхож байгаа улсууд чуулганы танхимд цуглаарай.

Б.Чойжилсүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ганхуягаас “Эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар” 6 асуулга ирүүлсний дагуу та бүхэнд товч мэдээллийг хүргэе.

Агуулга давхцаж байгаа тул ирүүлсэн асуулгын 2 асуултад хамт хариулъя.

Асуулга 1. Монгол Улс улсын эрчим хүчний хангамжийн найдвартай байдал өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг бүрэн хангах талаар авч буй арга хэмжээний талаар.

Асуулга 4 нь Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар гэсэн асуулгад хариулъя.

Эрчим хүчний салбар нь Монгол Улсын үндэсний аюулгүй, бие даасан байдлыг хангах, стратегийн чухал ач

холбогдол бүхий хөгжлийн тэргүүлэх салбарын нэг гэдгийг та бүхэн мэдэж байгаа.

Улс орны эдийн засагт өндөр ач холбогдол бүхий уул уурхай, зам тээвэр, үйлдвэрлэл технологийн бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг эхлүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, цаашилаад төв суурин газар болон дагуул хотууд шинэ суурьшлын бүсийг бий болгоход эрчим хүчний салбарыг түрүүлүүлэн хөгжүүлэх нь нэн чухал асуудал бөгөөд энэхүү зорилтууд Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудад тусгагдаж, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс баруун, төв, өмнөд болон дорнод бүс, Алтай, Улиастайн гэсэн 5 эрчим хүчний системтэй, нийт 330 гаруй сум суурин газруудыг төвлөрсөн эрчим хүчний системээс хангаж байна. Эрчим хүчний салбар 2022-2023 оны өвлийн их ачаалалд бүх станцуудын 63 зуух, 42 турбо агрегат гэсэн үндсэн тоноглолууд бүрэн ажиллаж, системийн хэмжээний нийт суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглаж, нөөц тоноглолгүй ажилласан.

Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний оргил ачаалал 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр 1387 мегаватт хүрсэн бол 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр 1462 мегаватт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 102 мегаваттаар нэмэгдсэн. Энэхүү ачааллыг хангахын тулд импортын эрчим хүчний хэмжээ 160 мегаваттаар өссөн ба 50 хүртэл мегаватт ачааллыг хэрэглээний оргил цагт хязгаарлаж ажилласан. Монгол Улсын хэмжээнд 2022 оны гүйцэтгэлээр 10.3 тэрбум киловатт цагт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 9.3 тэрбум киловатт цаг цахилгаан эрчим хүчийг түгээсэн. Нийт түгээсэн цахилгаан эрчим хүчний 79.3 хувийг дотоодын эх үүсвэрүүдээс, 20.7 хувийг импортын цахилгаан эрчим хүчээр тус тус хангалаа.

Эрчим хүчний дотоодын үйлдвэрлэлийг эх үүсвэрийн бүтцээр нь авч үзвэл 90.09 хувийг дулааны цахилгаан станцууд, 9.07 хувийг нар, салхи, усны эх үүсвэрүүд, тэг бүхэл, тэг гурван хувийг дизель эх үүсвэр тус тус үйлдвэрлэсэн байна.

Монгол Улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хангамжийн нөхцөл байдлаас гадна дулааны хангамжийн хүндрэлтэй байдал тулгамдсан асуудал болсон байна. Улаанбаатар хотод төвлөрсөн дулааны хангамжийн системд жилд дунджаар 150-230 гига калори цаг хэрэглээ бүхий 250-300 барилга, объект шинээр холбогдож байна.

Гэтэл сүүлийн жилүүдэд Амгалангийн дулааны цахилгаан дулааны станц, дулааны цахилгаан станц-III, IV-ийн труба генераторуудын шинэчлэлтээр дулааны үйлдвэрлэлийн хүчин чадал бага хэмжээгээр нэмэгдсэн боловч хэрэглээний өсөлтийг хангаж чадахгүй байна.

Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогуудад өмнөд бүсэд Тавантолгойн дулааны цахилгаан станц, Улаанбаатар хотод дулааны- III дугаар цахилгааны станцыг шинэчлэн 325 мегаваттын шинэ станц барих, Амгалан дулааны станцын хүчин чадлыг 116 гига калори цагаар нэмэгдүүлэх, дулааны IV-дүгээр цахилгаан станцын уурын хүчин чадлыг 500 тонн цагаар тус тус нэмэгдүүлэх, оргил ачааллын үед ажиллах дулааны эх үүсвэрүүдийг барих, дулааны II дугаар цахилгаан станцын дэргэд 100 мегаваттын хийн цахилгаан станц барих төслүүд тусгагдсан.

Түүнчлэн баруун бүсэд Ховд гол дээр Эрдэнэбүрэний 90 мегаваттын усан цахилгаан станцыг эхлүүлсэн. Энэхүү төсөл нь эрчим хүч үйлдвэрлэхээс гадна цэвэр усны нөөц, гадаргын усны нөөц харьцангуй багатай хуурай уур

амьсгалтай манай орны хувьд гадаргын ус хуримтлуулах экологийн ач холбогдолтой төсөл болно. Төслийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр барина. Барилга угсралтын ажлын гүйцэтгэгчтэй 2021 онд түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ байгуулсан. Бүгд Найрамдах Хятад Ард Улсын “Экзим” банктай 2023 онд зээлийн тусгайлсан гэрээ байгуулахаар ажиллаж байна. Иргэдийн нөхөн олговортой холбогдох асуудлыг Засгийн газрын зүгээс шийдвэрлэсэн.

Дорнод бүсэд одоо ажиллаж байгаа Чойбалсангийн дулааны цахилгаан станцыг түшиглэн 50 мегаваттын дулааны цахилгаан станцыг барьж байна. 2024 он гэхэд ашиглалтад оруулна.

Төвийн бүсэд Багануурын 400 мегаваттын дулааны цахилгаан станцыг концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр гэрээнд 2021 онд нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Мөн Хятад улсын нүүрсний станцын хөрөнгө оруулалтын хязгаарласан бодлогоос шалтгаалаад хэрэгжилт удааширч байна. Концесс эзэмшигчийн зүгээс хувьцаагаа шилжүүлэх замаар асуудлыг шийдвэрлэхээ, төслийг зогсоохгүй гэдгээ мэдэгдсэн. Мөн Төв аймгийн Баянжаргалан суманд Бөөрөлжүүтийн 300 мегаваттын цахилгаан станцыг хувийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулахаар 2022 онд барилгын ажлыг эхлүүлсэн. 2024 онд эхний блоккийг ашиглалтад оруулахаар зорьж байна.

Эрдэнэбүрэн-Мянгад-Улиастай цахилгаан дамжуулах агаарын төслийг Азийн хөгжлийн банктай, Чойр-Сайншанд, Сайншанд-Цагаан суваргын чиглэлийн шугамыг Европын сэргээн босголт, Хөгжлийн банктай, Багануур-Налайх-Улаанбаатар чиглэлийн шугамыг Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлэхээр яриа хэлэлцээг эхлүүлсэн.

Улсын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, төсвийн хязгаартай байдлаас шалтгаалан дээрх төслүүдийг үе шаттайгаар хугацаа сунган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Эхний ээлжид Эрдэнэбүрэн-Мянгад, Чойр-Сайнишанд, Багануур-Чойрын шугамыг эхлүүлэхээр шийдвэрлээд байна. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн сүлжээг горим ажиллагааны хувьд тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий систем болгон бүрдүүлэх зорилгоор усан цахилгаан станц, усан цэнэгт цахилгаан станцтай болох, түргэн маневрлах боломжтой хийн цахилгаан станц барих, цэнэг хураагуурын станц барих шаардлагууд байна.

Хамгийн түрүүнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр төвийн бүсэд 200 мегаватт цаг багтаамжтай цэнэг хураагуурын төслийг Улаанбаатар хот дахь Сонгино дэд станцын дэргэд барих төслийг амжилттай хэрэгжүүлнэ. Энэ онд ашиглалтад оруулахаар зорьж байна.

Асуулга 2. Өмнөд говийн бүс нутгийн уул уурхайн цахилгааны хэрэглээг хангах, Тавантолгойн уурхайн нүүрсээр ажиллах цахилгаан станцыг барих талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, Улаанбаатар хотыг тэлэх хөгжлийн бодлогын хүрээнд барихаар төлөвлөж байсан дулааны цахилгаан станц-V төслийн талаар ийм асуулга тавьжээ.

Монгол Улсын эдийн засагт хамгийн чухал ач холбогдол бүхий төсөл бол Тавантолгой дулааны цахилгаан станцын төсөл юм. Энэ станц баригдсанаар Оюу толгойн эрчим хүчийг дотоодоос хангаж, импортын эрчим хүчний төлбөрт төлж буй 110-120 сая ам доллар дотооддоо үлдэнэ. Мөн экспортын шаардлага хангахгүй байгаа хүрэн нүүрсийг эрчим хүч үйлдвэрлэж, эдийн засгийн эргэлтэд оруулна.

Тавантолгой дулааны цахилгаан станц компанийн нийт хувьцааны 51 хувийг Эрчим хүчний яам, 30 хувийг “Эрдэнэс Тавантолгой” хувьцаат компани, 19 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар эзэмшиж байна. Станцын ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2021 оноос 2 удаа зохион байгуулсан ба шаардлага хангасан тендер ирүүлээгүйгээс амжилтгүй болсон.

Тендер зохион байгуулах үед дэлхийн уур амьсгалын өөрчлөлттэй холбогдуулан нүүрсээр ажиллах цахилгаан станцын төслийг санхүүжүүлэхээс гадаад орнуудын засгийн газрууд болон олон улсын банк санхүүгийн байгууллагад татгалзаж, төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэхэд хүндрэлтэй нөхцөл байдал үүсгэсэн.

Мөн 2021 оны 9 дүгээр сард Нэгдсэн Үндэстний байгууллагын Ерөнхий Ассамблейн 76 дугаар чуулган дээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Си Жиньпин Хятад улс гадаад улсад оронд хатуу түлшээр халддаг цахилгаан эрчим хүчний шинэ төслийг хэрэгжүүлэхгүй гэж мэдэгдсэн нь Хятад улсаас хөрөнгө оруулах боломжийг бас хязгаарласан.

Дээрх хүндрэлтэй нөхцөл байдлыг харгалзан төслийг 300 мегаваттаар нэмэх нь 150 мегаваттаар хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэх нь эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, Оюу толгой болон өмнөд бүсийн бусад хэрэглэгчийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг хангаж, хөрөнгө оруулалтын хэмжээг бууруулах, төслийн хоёрдугаар үе шатын 150 мегаваттын блокыг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэн барих боломжийг бүрдүүлэх зэрэг ач холбогдолтой байна гэж үзээд гурав дахь удаагийн төслийн тендерийг зарлахаар бэлтгэж байна.

Улаанбаатарын дулааны цахилгаан станц-V төслийн талаар асуусан байна.

Улаанбаатар хотын цахилгаан дулаан хангамжийг шийдвэрлэх зорилгоор 2010 онд дулааны цахилгаан станц-V төслийг дулааны цахилгаан станц III-ын дэд бүтцийг ашиглан барихаар концессын гэрээгээр эхлүүлсэн. Монголын талаас станцын газрыг өөрчилснөөр төслийн техник, эдийн засгийн үндэслэл дахин хийгдэж, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх явцад гаднын хөрөнгө оруулалтын нөхцөл байдал өөрчлөгдөн нүүрсний станцын төслийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдэхгүй байдалд хүрснээс консорциум тарж, төсөл Дулааны цахилгаан станц-V нэрээр хэрэгжих боломжгүй болжээ.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Улаанбаатар хотын дулааны хангамжийг шийдвэрлэхээр дулааны-III дугаар цахилгаан станцыг шинэчлэн 325 мегаваттаар шинэ станц барих төслийг Оросын Холбооны Улстай хамтран хэрэгжүүлэхээр яриа хэлэлцээг эхлүүлсэн. Засгийн газар хоорондын хэлэлцээр хийхээр ажиллаж байна.

Асуулга 3. Эрчим хүчний салбар 2020 онд 92 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан бол 2021 онд 75.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Энэхүү алдагдлыг бууруулах эрчим хүчний үр ашигтай загварыг хөгжүүлэхэд чиглэлд хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл ирүүлэхийг хүсжээ.

Хэрэглэгчдийн цахилгаан дулааны тарифыг бодит өртгөөс доогуур тогтоож байгаа нь эрчим хүчний компаниудад нүүрс нийлүүлэгч уурхайнууд, бэлтгэн нийлүүлэгчид, банк санхүүгийн байгууллагуудад төлөх зээл, зээлийн хүүгийн төлбөр жил ирэх тусам

нэмэгдэж байна. Компаниуд хөрөнгийн дутагдлаас шалтгаалж техникийн засвар, үйлчилгээг цаг тухайд нь бүрэн хийхгүй байгаа нь насжилт өндөртэй, хуучин тоноглол бүхий үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд гэнэтийн аваар, саатал гарах эрсдэл нэмэгдсээр байна.

Сүүлийн жилүүдэд үнэ, тарифт өөрчлөлт оруулалгүй тогтвортой мөрдөж ирсний улмаас эрчим хүчний салбар 2019 онд 59 тэрбум төгрөг, 2020 онд 92 тэрбум төгрөгийн, 2021 онд 78 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. 2022 оны дүнгээр 1 их наяд 339.7 тэрбум төгрөгийн орлоготой, 1 их наяд 525.6 тэрбум төгрөгийн зардалтай, 189.6 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан.

Эрчим хүчний үйлдвэр компаниудын авлага 159 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 21.8 хувиар буурсан бол богино хугацаат өр төлбөр 361.2 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 26.6 хувиар нэмэгдсэн.

2022 оны 10 дугаар сараас Эрчим хүчний зохицуулах хорооноос инфляцад огцом нөлөө үзүүлэхгүй байлгах зорилгоор айл өрхийн цахилгаан, дулааны тарифт өөрчлөлт оруулалгүйгээр аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны үнэ, тарифыг тодорхой хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү тарифын өөрчлөлтийн үр дүнд 2023 онд түли, тээврийн нэн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхээр тооцоолсон. Салбарын өмнө санхүү, эдийн засгийн тулгамдсан асуудлууд нэлээдгүй байсаар байна.

Цаашид хэрэглэгчийн цахилгаан дулааны үнийг бодит түвшинд тогтоож, эрчим хүчний салбарыг хэвийн үйл ажиллагааг хангахгүйгээр улс орны нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах боломжгүй юм.

Асуулга 5. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний салбарт тусгагдсан төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудлын талаар асуулга тавьжээ.

Монгол Улсын 2021-2025 оны 5 жилийн үндсэн чиглэлд эрчим хүчний салбарын чиглэлээр тулгамдсан 7 арга хэмжээ, 2022 оны жилийн эцсийн байдлаар 38.6 хувийн хэрэгжилттэй байна. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Эрчим хүчний яамны үндсэн хэрэгжүүлэх 9 зорилтын хүрээнд тусгагдсан 36 арга хэмжээний 2022 оны хэрэгжилтийн дундаж 76.2 хувьтай байна.

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хүндрэл үүсгэж буй асуудлуудыг та бүхэнд танилцуулъя.

Бараа материалын үнэ, валютын ханшийн өсөлтөөс шалтгаалан тендер амжилтгүй болох, төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширах, хугацаандаа хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэж байна.

2.Даланзадгад, Ноён чиглэлийн 220 километр 110 киловаттын цахилгаан дамжуулах агаарын шон барих, Дулааны-II дугаар цахилгаан станцын дэд бүтцийг түшиглэн хийн цахилгаан станцын ажлыг эхлүүлэх, нийслэлийн Багануур, Налайх дүүргүүдэд дулааны станцын өргөтгөл шинэчлэлт хийх, эрчим хүчний шинэ эх үүсвэр, дэд станц барих зэрэг төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал одоогийн байдлаар шийдвэрлэгдээгүй байна.

Улсын эдийн засгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт их шаардах төслүүдийн хугацааг хойшлуулж байна.

Дөрөв дэх шалтгаан нь гадаадын улс орнуудын уур амьсгалын өөрчлөлтийн талаар баримталж буй бодлого, нүүрсний станцуудад хөрөнгө оруулалт оруулахгүй байх зарчим, мөн том төслүүдийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Асуулга 6. Сэргээгдэх эрчим хүчнийг хөгжүүлэх чиглэлд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэхийн давуу тал болон сул талууд тулгамдаж буй асуудлууд талаар асуулга тавьжээ.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль 2007 онд батлагдсанаар өнөөгийн түвшинд Монгол Улсын хэмжээнд нийт 260 мегаваттын нар, салхины цахилгаан станц ашиглалтад орсон. Үүнээс хувийн хэвилийн хөрөнгө оруулалтаар 90 мегаваттын нийлбэр чадалтай 6 нарны цахилгаан станц, 155 мегаваттын нийлбэр чадалтай 3 салхины станц нэгдсэн сүлжээнд холбогдон ажиллаж байна.

Нар салхины 9 станц, төвийн бүсийн нэгдсэн сүлжээний нийт суурилагдсан хүчин чадлын 16 хувийг эзэлж байна. Нийт цахилгаан, эрчим хүчний үйлдвэрлэлийн 8.6 хувийг үйлдвэрлэж, салбарын эрчим хүчний борлуулалтын орлогын 27 хувийг авч байна. Эдгээр станцууд 2022 онд татварын дараах дүнгээр 60.6 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан дүн мэдээ байна. Нарны станцуудаас нэгдсэн сүлжээнд гэрээгээр 1 киловатт цаг цахилгаан эрчим хүчийг 14.2-17.3 цент буюу 495-602 төгрөгөөр, салхин станцуудаас 1 киловатт цаг цахилгаан эрчим хүчийг 9.4-9.5 цент буюу 328-331 төгрөгөөр тус тус худалдан авч байгаа нь дулааны цахилгаан станцуудын үйлдвэрлэж буй дундаж тариф болох 83.6 төгрөгөөс 4-7 дахин өндөр байна.

Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 2015 оны нэмэлт, өөрчлөлтөөр сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифын хөтөлбөрийг хэрэглэгчдээс авахаар хуульчилсан. Одоогоор дэмжих тариф 1 киловатт цаг тутамд 23.79 төгрөг байгаа ба 2022 онд 150 тэрбум төгрөгийн орлогыг цахилгаан эрчим хүч хэрэглэгчдээс төвлөрүүлсэн. Ашиглалтад орсон нарны 6, салхины 3 станцуудад 2022 онд нийт борлуулалтын орлогын 27 хувийг, үлдсэн 73 хувийг нийт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэлийн 91.4 хувийг хангасан төрийн өмчийн компаниудад хуваарилсан. Үүнээс шалтгаалан төрийн өмчит компаниуд 2020 онд 88 тэрбум төгрөг, 2021 онд 78 тэрбум төгрөг, 2022 онд 187 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан.

Мөн нар, салхины цахилгаан станцаас үйлдвэрлэсэн цахилгааныг ам доллароор худалдан авах хатуу гэрээг байгуулсан болон валютын ханши, инфляц зэргээс шалтгаалан салбарын алдагдал нэмэгдэж байна. Алдагдал нэмэгдсэнтэй холбогдуулан аж ахуйн нэгж байгууллагуудад борлуулах тарифыг 2022 оны 4 дүгээр улиралд нэмэгдүүлсэн ч 2023 онд алдагдал нэмэгдэж оны сүүлээр төвийн бүсийн нэгдсэн сүлжээний нэг худалдан авагчийн данс, мөнгөн хөрөнгийн дутагдалд орохоор байна. Одоо ашиглалтад байгаагаас гадна хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр Эрчим хүчний зохицуулах хорооноос тусгай зөвшөөрлөө сунгуулсан нийт 3 салхи, 8 нарны эх үүсвэрийн нийлбэр чадал 495.4 мегаватт байна.

Эдгээр төслүүдийг нэгдсэн сүлжээнд холбоход техникийн болон санхүү эдийн засгийн хүндрэл үүсгэж байна. Үүнд:

1. Нар салхины станцууд эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд цаг уурын буюу нар, салхины өөрчлөлтөөс хамааран тогтвортой ажиллахгүй. Тэр нь эрчим хүчний нэгдсэн сүлжээний

тогтвортой, найдвартай ажиллагаанд шууд сөргөөр нөлөөлж, хэрэглээний оргил ачааллын цагуудад оролцоо багатай оролцож, хэрэглээний бага ачааллын үед шаардлага багатай үйлдвэрлэл явуулж байна.

Үүнийг зохицуулах горим, тохируулгын эх үүсвэр барьж байгуулан үе шаттайгаар нэгдсэн сүлжээнд залгах шаардлага зүй ёсоор тулгамдаж байна. Төслүүд ихэнхдээ Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Дундговь, Төв аймгийн урд сумдын нутгуудад буюу цаг агаарын нэг бүсэд байгаа нь нэгдсэн сүлжээний горимд үзүүлэх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл өвлийн хоногийн их ачааллын цагуудад нарны цахилгаан станцууд үйлдвэрлэлд оролцдоггүй. Салхин цахилгаан станцууд нь системийн оргил ачаалалд оролцох оролцоо тогтворгүй байна. Олон улсад сэргээгдэх эрчим хүчийг амжилттай хөгжүүлж буй туршилага нь ердөө тохируулгын эх үүсвэртэй байгаа явдал юм. Өөрөөр хэлбэл усан цахилгаан станцтай, хийн станцтай улсууд байна.

Иймээс эрчим хүчний нэгдсэн сүлжээний эх үүсвэрийн бүтцэд оновчтой хувь, хэмжээг барьж хөгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Мөн цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугамыг барьж байгуулна. Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийн оролцоог нэмэгдүүлэхэд бэлэн байх шаардлагатай байна. Төвийн бүсийн эрчим хүчний систем, горим тохируулгын түргэн маневрлах цахилгаан станцгүй тул Оросын Холбооны Улстай холбогдсон 220 киловаттын цахилгаан дамжуулах агаарын шугамаар эрчим хүч импортлож, горимын тохируулгаа хийж, чадлын дутагдлаа нөхдөг.

Сүүлийн жилүүдийн хэрэглээний өсөлтөөс шалтгаалан тус дамжуулах шугамаар авах чадлын дээд хязгаар 310 мегаватт хүрч ачаалал буусан. 2022-2023

оны өвлийн горимд нөөц тоноглолгүй зарим хэрэглэгчийг хязгаарлаж ажилласан. Ийм нөхцөлд тогтворгүй, хувьсах эх үүсвэр болох нар, салхины цахилгаан станцуудыг системд нэмж холбох тохиолдолд системд үүсгээж буй савлалтын хэмжээг нэмэгдүүлэх тул суурь горимд ажиллах 300 мегаваттаас доошгүй дулааны цахилгаан станц шинээр ашиглалтад оруулах, системд горим тохируулгын үүрэг гүйцэтгэх хийн болон усан цахилгаан станц, батарей хуримтлуурыг барьж ашиглах шаардлагатай байна.

2.Өнөөдрийн байдлаар сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийн нэгжийн өртөг өндөр байгаа нь эрчим хүчний салбарын санхүүгийн чадавхад шууд нөлөөлж байна. Хэрэглэгчийн үнийг нэмэх эсвэл үнийн зөрүүгээс үүсэх алдагдлыг Засгийн газраас шийдвэрлэх шаардлагатай байна. Сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулагчдын баталгааг хангахын тулд урт хугацаанд тогтвортой үнэ тарифаар гэрээ байгуулж байгаа нь эрчим хүчний салбарыг өрсөлдөөнт зах зээлд шилжүүлэх боломжийг мөн хугацаагаар хойшлуулж байна.

Эрчим хүчний салбарт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, эрх зүйн орчин хөрөнгө оруулагчдад нэн тааламжтай байгаа. Тийм учраас өнгөрсөн хугацаанд тусгай зөвшөөрлүүд олноор олгогдсон нь бодит амьдралд эрчим хүчний зах зээл дээр хүндрэл үүсгээж байна.

Шинээр холбогдох тусгай зөвшөөрөлтэй нар, салхины станц шинээр ашиглалтад орвол хэрэглэгчийн тарифыг тухай бүр индексжүүлж, нэмэгдүүлж байх шаардлагатай. Тухайлбал, тусгай зөвшөөрөл авсан 100 мегаваттын салхины станцыг нэмж ашиглалтад оруулбал одоо байгаа хэрэглэгчийн тарифыг 10 төгрөгөөр, 50 мегаваттын нарны станцыг ашиглалтад оруулбал

хэрэглэгчийн тарифыг 5 төгрөгөөр нэмэгдүүлж, индексжүүлэх шаардлагатай байна.

Шинээр холбогдох тусгай зөвшөөрөл авсан бүх нар, салхины эх үүсвэрийг ашиглалтад оруулбал дэмжих тарифыг 23.79 төгрөгөөс 3 дахин нэмэгдүүлж, 70.34 төгрөг болгоно.

Ингэснээр эрчим хүчний салбарын нийт орлогын 45 хувийг сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэгчдэд хуваарилахаар байна. Цаашид нар, салхины цахилгаан станцыг шинээр барьж байгуулах тохиолдолд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд 2019 онд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу өрсөлдөөнт сонгон шалгаруулалтаар хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Батмөнхийн Насантогтох газрын дарга, Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Батмөнхийн Ерэн-Өлзий яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга, Зоригийн Мөнх-Оргил Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Эрдэнэчулууны Түвшинчулуун Эрчим хүчний зохицуулах хорооны дарга.

Асуулгаа хариулттай холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү. Тогмидын Доржханд гишүүнээр тасаллаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Чойжилсүрэн сайдын мэдээллийг сонслоо. Их чухал мэдээлэл өглөө гэж бодож байна. 3 асуулт асууя.

Нэгдүгээрт нь бидэнд хамгийн чухал 1 номерын асуудал эрчим хүчний асуудал. Бид нар эрчим хүчнийхээ хангамжийг сайжруулж чадах юм бол

юуг ч хийх бололцоотой. Монгол Улсын эрчим хүчний хэрэглээ байнга өсөн нэмэгдэж байгаа. Улс орон маань ч гэсэн хөгжсөөд эрчим хүчний хэрэглээ өдөр ирэх тусам л байнга л нэмэгдээд явж байгаа юм. Тэгэхээр бидэнд хамгийн том асуудал бол эрчим хүч.

Тийм учраас Монгол Улс бол нэг номерт бол эрчим хүчээр өөрийгөө хангах энэ бодлогоо хамгийн түрүүнд хэрэгжүүлж явах ёстой гэж ингэж бодож байгаа юм. Энэ хүрээнд нь Чойжилсүрэн сайд энэ шинэ эх үүсвэрийг бий болгох, цаашид энэ байнгын өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний хэрэглээгээ цаашид хангах чиглэлээр ойрын хугацаанд юу юуг төлөвлөсөн байна вэ гэдэг асуудал байгаа юм. Нэг дэх асуудал. Энэ хамгийн чухал. Энэ дээр нь ер нь Улсын Их Хурал, Засгийн газар цаашид хөрөнгө оруулалтынхаа үндсэн том бодлогыг энэ рүү чиглүүлж явах ёстой гэж ингэж бодож байгаа юм байна.

Хоёр дахь асуудал нь Бүгд Найрамдах Солонгос Улсын зээлээр 10 аймагт дулааны станц баригдаж байгаа. Өнгөрсөн жил гүйцэтгэгчийн сонгон шалгараад “Бьюксан” гээд Солонгосын компани шалгараад ингээд ажлаа эхлээд явж байна. Орон нутгуудад бол харьцангуй янз янзаар л явж байна. Би саяхан тойрогтоо ажиллах явцдаа Өвөрхангай аймагт баригдаж байгаа дулааны станцын ажилтай танилцсан. Ажил яах вэ графикийн дагуу явж байна. Тэгэхдээ жаахан хоцрогдолтой байна. Хамгийн том асуудал юу байна вэ гэхээр энэ Солонгосын нөгөө “Бьюксан” компани үнээ нэмнэ гэдэг нэг ийм асуудал гараад байгаа юм байна. Өөрөөр хэлбэл энэ КОВИД-оос өмнө энэ дэлхий нийтийг хамарсан энэ үнийн өөрчлөлтөөс өмнө хийгдсэн зураг төсөвтэй учраас үнэ нэмэгдэх шаардлага байна гээд. Энэ үйл явдал нь энэ станцуудын хугацаандаа баригдахад нөлөөлж болзошгүй байна. Энэ дээр яамны зүгээс ямар арга хэмжээ

авахаар төлөвлөж байна вэ? Солонгосын талтайгаа ярилцаж, хөөрөлцөж энэ чиглэлээр гарц гаргалгаа гаргаж байгаа юм байна уу? Хоёр дахь нь.

Гурав дахь нь Дэлхийн банкны төслөөр манай Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархоринд 2-т эрчим хүчний төсөл хэрэгжиж байгаа. Бас үнийн өөрчлөлт гээд энэ 2 нөхөр ажил нь бас түр зогсчихсон байж байгаа. Энийг эрчимжүүлэх, хурдтай явуулах ийм зайлиггүй шаардлага байна.

Дөрөв дэх асуудал нь сая Чойжилсүрэн сайдын төгсгөлд нь дурддаг их чухал асуудал байгаа юм. Энэ нар, салхины станцуудыг ажиллуулахтай холбоотой асуудал байгаа юм. Та бол маш их алдагдалтай байна, улсын төсвөөс их хэмжээний татаас энд өгөх шаардлага үүсэж байна. Ийм учраас бол.../минут дуусав./

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулъя. Баттогтохын Чойжилсүрэн Эрчим хүчний сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Тогтохсүрэн даргын асуултад хариулъя. Тогтохсүрэн даргаа ер нь манай эрчим хүчний хэрэглээ сүүлийн 15 жилийн судалгаа гэж үзсэн. Дунджаар жил бүр харилцан адилгүй. Гэхдээ дунджаар 6-7 хувиар өсөж байна 6.8 бүр жилдээ. Ингээд энэ маань бид нарын 8-н дулааны цахилгаан станц байна. Суурилагдсан хүчин чадал нь 1264 мегаватт. Энэ хэмжээ бол ойрын үед ингээд тулчихсан. Импортлоор авч байгаа. 2035 он хүртэл бид нар хэрэглээний таазыг гаргаж үзсэн. Энэ хэмжээ 2500, 3000 орчим мегаватт хүрч нэмэгдэх юм байна. Тэгэхээр одоо бид нарын Эрчим хүчний яам дээр бол хэдэн төслүүдийг хэрэгжүүлэхээр явж байна. Эхний төсөл бол энэ ТЭЦ-III-ыг 325 мегаваттаар нэмэгдүүлэх цахилгаан эрчим хүчний хувьд. Дулааны хувьд бол 500 мегаваттаар яг 500 гига кил цагаар

нэмэгдүүлэх энэ ажлыг Оросын Холбооны Улсын экспортын зээлээр санхүүжүүлэхээр хэлэлцээр явж байна. Энэ 6 сарын 14-17-ны хооронд Санкт-Петербургийн эдийн засгийн форумд оролцох байх 6 сард урилга ирүүлсэн. Энэ хэлэлцээр энэ хавиар, энэ үеэр эцэслэх болов уу гэсэн ийм баримжаатай нэг.

Дараагийн станц бол энэ Тавантолгойн дулааны цахилгаан станц байгаа. 450 мегаваттын 3 блоктой станцыг 300 ба нэмэх нь 150 гэдэг ийм байдлаар зарлая. Эхний ээлжид 300-г ашиглалтад оруулъя гээд Засгийн газарт энэ Тавантолгойн дулааны цахилгаан станцыг зарлах талаар тогтоол оруулсан 3 сарын 22-ны өдөр. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл албажиж өгөхгүй байна. Энэний дараа бид нар тендер зарлаад энэ оны 8, 9 сар гэхэд сонгон шалгаруулчих болов уу гэсэн ийм хүлээлттэй байгаа. Энэ 300 мегаватт. Ингээд 300, 300 болоод явж байгаа юм.

Дараа нь энэ Бөөрөлжүүт дээр нэг хувийн аж ахуйн нэгж байгууллага 300 мегаваттын цахилгаан станц бариад явж байгаа. Хамгийн наана орох эх үүсвэр бол энэ. 2024 оны 4 дүгээр улиралдаа багтаагаад ашиглалтад авна гэсэн ийм зорилттой явж байгаа. Нийт олгогдсон хүчин чадал нь 600 мегаватт, энэнээс 300 мегаваттыгаа ирэх жилийн 4 дүгээр улиралд ашиглалтад оруулъя гэсэн ийм төсөл байна.

Дараагийн төсөл бол энэ Багануурын дулааны цахилгаан станцын төсөл 2017 онд эхлээд явж байсан. Зогсчихсон байгаа шалтгааныг нь та бүхэн мэдэж байгаа. Хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нь солигдоод шинэ хувьцаа эзэмшигч гарч ирж байгаа. Одоо энэ 5 дугаар сардаа багтаад Монгол Улсад ирнэ гэсэн. Сая би 2023 оны 2 сарын 10-15-ны хооронд Хятадад айлчлах үед бол шинэ хөрөнгө оруулагч болон хуучин хөрөнгө оруулагч нартай нь уулзсан. Төслийг цаашид үргэлжлүүлнэ гэсэн.

Гэхдээ эхний ээлжид бол 400 мегаваттаар явуулна. Цаана нь үлдэж байгаа 2 дугаар үе шатдаа 300 мегаваттаар явуулъя гэдэг ийм тохиролцоонд хүрээд явж байгаа.

5 дахь эх үүсвэр бол Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц 90 мегаваттаар явж байгаа. Одоо ингээд зээлийн тусгайлсан хэлэлцээр ерөнхийдөө байгуулагдах шатад бүх юм Монголын талаас бараг бэлэн болчихсон. Хятадын талаас энэ асуудлыг түргэвчилнэ гэдгээ ярьсан. Худалдааны яам “Экзим” банкнаас нь төв байгууллага руугаа, төрийн зөвлөл рүүгээ хүргүүлчихсэн хариу хүлээж байгаа ийм иймэрхүү байдалтай байгаа.

Дорнод бүс дээр бол 50 мегаватт энэ Дорнодын цахилгаан станцын өргөтгөл явж байгаа ийм 6 станц байна.

Нар, салхины станцуудыг бид нар нөгөө холбох бололцоогүй байгаа болохоос биш 495.4 мегаватт цагийн хүчин чадалтай 11 станц ашиглалтад оруулъя гэдэг ийм явж байгаа. Сая би танилцуулга дээр уншсан. Хүндрэлүүд байгаа. Техникийн хүндрэл, санхүүгийн хүндрэл ийм хосолсон хүндрэл байгаа учраас нар, салхины станц дээр одоохондоо энэ тохируулгын функцийг шийдэхээс өмнө бид нар төвийн эрчим хүчний системд холбуулах бололцоогүй байна гэдгийг бас танд хэлье.

Энэ 10 аймгийн дулааны станцын талаар Солонгос улсын Korea Эксим-ийн санхүүжилтээр 9 аймаг дээр нь хэрэгжиж байгаа. Архангай аймаг бол ингээд энэ төсөлд хэрэг нэгдэх үү, нэгдэхгүй юу гэдгээ ойрын хугацаанд мэдэгдэх байх. Энэ үнэ нэмэгдэнэ гэдэг асуудал ярьж байгаа. КОВИД-ын өмнө энэ техник эдийн засгийн үндэслэл, тендерүүд шалгарчихсан юм байна лээ. КОВИД-ын үеэр бол дэлхий даяар үнэ нэмэгдсэн учраас үнэ нэмэхээс аргагүй

гэдэг ийм шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч компани ярьж байгаа. Бид зориулаад харж үзье, магадлан хийе. Гэхдээ та бүхэн зургаа дуусгаад магадлалаар оруулчих, дараа нь зураг дууссаны чинь дараа төсвийн чинь магадланд хийчихье. Ямар үнээс, ямар өөрчлөлт гарах гээд байгааг чинь судлаад, боломжтой бол үнэ нэмэгдэх асуудлыг шийдэх боломжгүй бол энэ асуудлыг яах ёстой юм ийм төвөгтэй байдалд орчихсон байгаа. Яг бодит байдал бол ийм байна.

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд, Чойжилсүрэн гишүүн, сайд гүйцээж хариулна.

Б.Чойжилсүрэн: Үүнээс шалтгаалаад энэ ажил нь явж байгаа 9 аймгууд дээр төслийн ажил тодорхой хэмжээгээр удааширалтай ийм байгаа нь үнэн. Энэ үнийн өсөлтийн асуудлыг бид нар ямар ч байсан шийдэх учиртай. Гэрээгээрээ зургаа энэ Йи Би Си гэрээгээр хэрэгжүүлж байгаа энэ компани Солонгос улсын компани өөрөө зураг, төсвөө хийлгэх тэгээд магадлалаар батлуулах учиртай. Энэ ажил жоохон хүлээгдээд байгаа. Эрчим хүчний яамнаас бол энэ ажил дууссаны дараа бол бид нар цаг алдахгүй шийдвэрлэхэд бэлэн байгаа.

Эрчим хүчний төсөл, арга хэмжээний хувьд бас л үнийн өсөлт ярьдаг юм. Гэхдээ Дэлхийн банк болон Азийн хөгжлийн яам, Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа төслүүд дээр үнийн өсөлт гарсан ч тэр нөгөө магадалиггүй ажлын зардлууд нь анх төсөлтэйгөө цуг суусан учраас энэ Korea Экзим-ийн санхүүжилтийг бодоход арай илүү хялбар, хурдан шийдэх бололцоотой ийм байна. Ажлыг хурдасгахаар бид нар манай яаман дээр бүс бүсээр нь ажлын хэсгийн газрууд хувааж аваад ажлаа хийж байгаа гэдгийг хэлье.

Нар, салхины станцын талаар сая тодорхой танилцуулга уншсан учраас хариулчихлаа гэж. Хариулж дууслаа даргаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Эрчим хүчний асуудал яах аргагүй бидний онцгой анхаарах ёстой асуудал. Энэ хөгжлийг дэмжих энергийн эх үүсвэрийн найдвартай байдлыг хангах тухай хамгийн гол зүйл мэдээж эрчим хүчнийхээ салбарын хөгжлийг хангах, дотоодоосоо эрчим хүчээ хангах төлөвлөлт, хөгжлийн бодлого, шинэ эх үүсвэрүүдийн бүхий л чиглэлүүд гарсан ажлууд түрүүчээсээ эхэлж байгаа. Үүнийг шуурхай явах ёстой гэж ингэж ойлгодог.

Гэхдээ аль болохоор богино хугацаанд ашиглалтад орох, тэгэхдээ эрчим хүчний том системдээ ямарваа нэгэн сөрөг нөлөөгүйгээр блокуудыг нь жижигсгэж хийх замаар л явах тусмаа биднүүс жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээгээ нөхөн хангаад явах бололцоо бүрдэх ёстой. 1 том блокоор тавьчихаад 2, 3 жил хүлээдэггүйгээр жил жилд ашиглалтад орж чаддаг гэдэг юм уу тийм блокуудаар нь төлөвлөж хийвэл илүү л үр дүнтэй болох болов уу гэсэн ийм бодол байгаа. Энэ дээр ямар төлөвлөлт юмнууд байна вэ гэж.

Хоёр дахь асуудал. Мэдээж энэ эрчим хүчний эх үүсвэрийн нөөцүүдээ түшиглэсэн хувийн хэвшлийн, хувийн хөрөнгө оруулалттай станцуудыг дэмжих хэлбэрээр бид бас энэ дотоодын эх үүсвэрийн нэмэгдүүлэх бололцоо, боломж байгаад байх шиг байгаа юм. Тэр Бөөрөлжүүтийн станцтай адил төстэй ийм станцыг дамжуулах шугамынхаа хүчин чадлыг түшиглүүлээд байгуулчихвал болно доо. 110 ч гэдэг юм уу ийм дамжуулах шугамтай газруудад холболтынх нь дэд станцыг шийдээд л

холбочиход би бололцоо бүрдэх юм байна. Энэ талаас нь судалгаа ер нь манай дээр хэр хийгдэж байна вэ гэсэн нэг ийм асуудал байна.

Гурав дахь асуудал. Эрчим хүчний нүүрс экспортод гарч байгаатай холбогдуулаад дотоодын дулаан үйлдвэрлэлийн жижиг аж ахуйнууд дээр нүүрсний чанарын асуудал яригдах гээд байна. Би бол ингэж хараад байгаа. Тэгэхээр чанартай нүүрсээ гадагш нь экспортлох, дараагийнхыг нь энэ төвийн эрчим хүчний системийн байгууллагууд руу нийлүүлэх, тэгээд цаашаагаа орон нутгийн дулаан үйлдвэрлэлийн байгууллагууд руу нийлүүлэх нэг ийм л ангиллын юм руу явчих гээд байна. Тэгэхээр энэ дээр эрчим хүчний бодлого зохицуулалтаа хангаж байгаа байгууллага ямархуу байдлаар харж байна вэ? Ямар зохицуулалт юмнууд байна вэ гэдэг нэг ийм асуудал байна.

Дараагийн асуудал тэр 10 аймгийн дулааны станцын явц дээр яг Тогтохсүрэн гишүүнтэй адилхан санал байсан. Дээр нь энэ асуудал нь шийдэгдээд явлаа гэхэд 24 оны 9 сарын 15 гэхэд ашиглалтад орно. Тэгэхээр зэрэг 2, 3 дугаар конторууд чинь энийгээ хүлээж авах боломж их муу байгаа шүү. Үүнийг 24 оны төсөв ярихдаа холбогдох яамнуудынх нь хөрөнгө оруулалт тал дээр тусгуулмаар байгаа юм.

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Батжаргал гишүүнээ энэ жижиг блокуудаар яваад байхаар бас нэг хүндрэл байна. Таны ярьж байгаа нөгөө богино хугацаанд барьж ашиглах санхүүгийн хүндрэл багатай гэдгээрээ уян хатан боловчиг энэ жижиг станцуудын нэгжсийнх нь үнэ өндөр гараад байна. Одоо тэр нүүрсний цахилгаан станцууд дээр бол 4 дэх үеийн тоноглолууд гээд ингэх юм бол 350

мегаватт ба түүнээс дээш болоод явах юм бол тэр ультра супер критикал гэдэг сэдвээр явах юм бол эрчим хүчний ашигт үйлийн коэффициент жишиг дээрээ жишигээлбэл 30 хүрэхгүй байгаа бол зарим дээр нь 47, 8 хувь хүрээд нэгжсийнх нь үнэ буудаг ийм 2 талтай асуудал бий.

Гэхдээ манай улсад баригдаж байгаа, шинээр баригдаж байгаа турбины дээд талын хэмжээ бол бид нар 150 дотор л байна шүү дээ. Тэгэхээр манайд нэгжсийн үнэ бол энэнээс шалтгаалаад бууж өгөхгүй ийм хүндрэл байгаа шүү гэдгийг хэлье. Энэ эрчим хүчний салбар нэг хүндрэл байгаа нь зардал нь зах зээлийн ханшаар гардаг. Үнэ дээрээсээ тохируулгатай учраас зах зээлийн үнэдээ очиж өгдөггүй. Энэнээс шалтгаалаад нөгөө bankable гэдэг шиг хувийн салбарынхан хөрөнгө оруулаад ашиг олоод гарах ийм нөхцөл байдал тун хомс байгаа. Хамгийн анхны хувийн салбарын хөрөнгө оруулалт бол энэ цахилгааны салбартаа бол энэ Бөөрөлжүүтийн төсөл байна. Танай аймагт баригдаж байгаа. Хоёрдугаарх нь тэр Багануурын бас Хятадын хөрөнгө оруулагчтай, хувийн хөрөнгө оруулагч нар байгаа. Эдний үнэ, тариф бол ер нь ерөнхийдөө бол 9 цент орчмоор худалдаж авахаар төвийн эрчим хүчний системд нийлүүлэх ийм үнийг бий болгосны хүчинд энэ 2 төсөл явж байгаа.

Ер нь бол бидний одоо бид нарын 213 төгрөг маань яг 5.7 центээр бид нар дунджаар цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчид нийлүүлж байгаа. Энэ тоо олон улсын дундаж руу явах юм бол 9.5, 10 цент хүрсэн тохиолдолд хувийн хөрөнгө оруулалтууд энэ эрчим хүчний салбарт хөрөнгө оруулаад хэвийн бизнесийн ашигтай ажиллах ийм нөхцөл бүрдэхээр юм байна лээ. Тэгэхээр энэ эрчим хүчний салбарын бүр либералчлал гэдэг бол магадгүй энэ 6, 7, 10 жилийн хугацаанд хийх байх. Энэ үнийг бол индексжүүлж явахаас одоо аргагүй энэ нөхцөл тулчихсан байгаа гэдгийг хэлье.

Энэ дулааны станцуудын нүүрсний чанарын хувьд бол асуудал бий. Гэхдээ бид нар энэ өндөр чанартай энэ коксжих нүүрсийг бол экспортод гаргаж валютын орлого олох ёстой байх.

Хоёрдугаарт нүүрс маань өөрөө харьцангуй үнэ багатай, тээврийн зардал өндөртэй учраас энэ дулааны станцуудыг аль ойр байгаа нүүрсний станцуудаас нь түрүүчийн үе үеийн Эрчим хүчний яамны салбарынхан үндсэн тэжээлээр ингээд хангаад энэ төслүүдийг дулааны компаниудыг барьчихсан юм байна лээ. Тэгэхээр энэ дээр сүртэй өөрчлөлтүүд бид нар хийж чадахгүй гэдгийг хэлье.

Тэр дөрөвдүгээр нь бол тэр 10 аймгууд дээр дулааны станцууд баригдсан тохиолдолд 2 дугаар конторууд хэрэглээний халуун ус авах, бусад хэрэглэгчдийг холбох худаг, дэд бүтцүүд хийх гэх мэт ийм аймгууд орон нутгууд харцуцах ийм бараг зарим аймгууд дээр бол энэтэй холбоотой станц эх үүсвэр баригдаад орсны дараа дахиад 40 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтууд шаардлагатай ийм судалгаа байгаа.

Тэгэхээр энэ улс орны эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаа учраас ямар ч байсан эхний ээлжид эх үүсвэрээ нэгдүгээрт барьчихъя. Хоёрдугаарт үе шаттайгаар аймгийн орон нутгууд бас орон нутгийнхаа төсвөөс тодорхой хэмжээний эх үүсвэр хуваарилах байх боломжтой байна. Боломжгүйчүүд нь улсын төсөв дээр суулгах талаар эдгээр аймгуудаар сонгогдсон гишүүдтэй Эрчим хүчний яам хамтарч ажиллана та бүхэнд.

Г.Занданшатар: Тодруулах уу? Жигжидийн Батжаргал гишүүн 1 минут тодруулна.

Ж.Батжаргал: Биднүүсийн өдрийн цагийн эрчим хүчний ашиглахгүй байгаа эх үүсвэр ер нь хэд байгаа юм бэ? Одоо

бидний шинээр барих гээд байгаа тэр зай хураагуурын станц ер нь ашиглаж чадахгүй байгаа нөөц боломжоо бүтэн хурааж авах бололцоо бий юү тэр 200 мегаватт чинь? Энэ дээр нэг тайлбар аваадахъя.

Г.Занданшатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд.

Б.Чойжилсүрэн: Батжаргал гишүүн ээ, өдрийн цагаар тийм илүүдэл юм байхгүй. Диспетчерийн үндэсний төв дээрээс энийг бүгдийг нь горим хянаж байгаа. Одоо манай хуучин станцууд маань нэлээн тийм хуучирчихсан байгаа учраас бид нар цахилгаан, эрчим хүч илүүдэх тохиолдолд турбинуудыг нэг нэгээр зогсож засварт оруулах гэх мэт ийм байнгын тохируулгатай явж байгаа. Тэгэхээр илүүдээд байгаа юм байхгүй. Энэ дашрамыг ашиглаад энэ 200 мегаваттаар цахилгаан станц оруулж барьж байгаа. Сонсголон дэд станц дээр. Энэ маань 200 мегаваттаар шөнөдөө цэнэглээд, оргил ачааллын үед бол 80 мегаваттаар 2.5 цагаар системийн юу дутагдаж байгаа эх үүсвэрийг нөхөхөд оролцоно.

2023-2024 оны өвлийн улирлын оргил ачааллыг бид нар бол ерөнхийдөө энэ сторэйж дээр суурилж давна гэсэн ийм тооцоолол.../минут дуусав./

Г.Занданшатар: Харцулт 1 минутад л байна гэсэн. Багтана гэж байна. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга.

Б.Энх-Амгалан: Баруун бүс хамгийн үнэтэй цахилгаан хэрэглэдэг бас хамгийн үнэтэй дулаан хэрэглэдэг. Тэр дундаа Говь-Алтай аймаг. Тэгээд энэ Говь-Алтай аймагт өвөл дөхөөд ирэхээр гуйна гэдэг гутамшиг, гуйлгана гэдэг гайхамшиг гэдэг ишг дулааны цахилгаанаа гуйгаад л хувийн компаниудаа царай алдаад л явдаг нэг ийм хачин тогтолцоо байгаа юм. Тийм учраас

хамгийн чухал зүйл бол энэ Солонгосын “Экзим” банкны санхүүжилтээр баригдах баруун бүсийн тэр дулааны цахилгаан станцын асуудал байгаа юм. Одоо бол 10 аймгаас 9 аймагт хэрэгжих юм байна. Тэгээд бид нар чинь баахан тууз хайчлаад нээлтээ хийчихсэн байдаг. Сая сайдын тайлбараар бол үнэ нэмэгдэх нь ойлгомжтой юм байна. КОВИД-ын өмнөх үнэ учраас КОВИД-ын дараа үнэ нэмэгдсэн, үнэ нэмэгдэхгүй бол төсөл хэрэгжихгүй гээд зогсчихсон байгаа юм байна.

Тэгээд төсөл гэж хэрэгжих шаардлагатай байгаа учраас энэ үнээ нэмээд, зураг төслөө дахин боловсруулаад, магадлан хийгээд ингээд оруулъя гэж байна. Хэзээ магадлан дуусгах вэ? Нэг хугацаа хэлээч. Энэ маань ингээд явж байгаад 24 ондоо багтаж ашиглалтад орохгүй болчих вий дээ. Тэгвэл одоо энэ баруун бүсийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах тэгээд нөхцөл байдал нэлээн хүнд байдалд орох нь байна. Нэг дэх нь энэ.

Хоёр дахь нь энэ Дорноговь аймагт байдаг сэргээгдэх эрчим хүчний юмаа цэгцэлж чадаж байгаа юу, чадахгүй байгаа юу? Ашигласан ч мөнгө төлдөг, ашиглаагүй ч мөнгө төлдөг. Тэгээд шүүхдээд баахан мөнгө Монгол Улс төлөх болчихсон ийм гэрээг анх ер нь хэн хийсэн юм? Одоо ер нь тэр өр төлбөр нь хэд болсон бэ? Тэрийг яаж зохицуулах гэж байна? Тэр Монгол Улсад ашиггүй хийчихсэн тэр гэрээний хариуцлага гэдэг юм яригдах уу, яригдахгүй юу? Ийм хоёр дахь асуулт байна.

Гурав дахь нь энэ Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын асуудал бол баруун бүсэд маш чухал ач холбогдолтой. Баруун бүсийн энэ түгээх сүлжээг өргөтгөхгүй бол энэ гаднаас авдаг импортын тог чинь бол асар үнэтэй. Тийм учраас энэ Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын зээлийн хэлэлцээр, зээлийн тусгай хэлэлцээр яваад байна гэж

яриад байдаг. Энэ тусгай хэлэлцээр хэзээ дуусах вэ? Хятадын талаас хариу хүлээж байна гээд байдаг энэ маань явсаар байгаад дахиад 24 оноо даваад явчих вий дээ. Хятадууд яг бодитой хариу өгсөн үү, энэ явах нь уу, яг хийгдэх үү? Бид нар нэг хийж байна, хийх гээд байна, ярилцаж байгаа, хэлэлцэж байгаа гэдэг үг биш нэг тодорхой хугацаанууд баймаар байна. Энэ асуудлаар 3 асуудлаа тодруулж өгөөч.

Г.Занданшатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд, Эрчим хүчний сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Энэ 10 аймгийн дулааны станцын талаар танд тодорхой тайлбар хэлье.

2022 оны 10 дугаар сарын сүүлээр энэ төслийнх нь нэгжийг гүйцэтгэж байгаа компанитай нь дуудаж уулзсан. Манай яамнаас бол Эрчим хүчний хөгжлийн төв болон манай яамнаас байнгын хяналт тавьж байгаа. Би хувьдаа уулзсан. Юу тохирсон бэ гэхээр 2023 оны 3 дугаар сарын 1 гэхэд зургаа магадлал хийгээд дуусгаад аваад ирнэ, үнэ өсөх нь гэдэг асуудлыг ярьсан юм надад. Хурдалъя тэгвэл энэ өвлийн сезоныг ашигла гэсэн. Харамсалтай нь дахиад 2 сар шахам хоцроогоод одоо зургаа дуусгаад Эрчим хүчний хөгжлийн төвд магадлал хийлгэхээр зураг нь өгсөн байна. Тэгэхээр энэ 5 дугаар сарын дунд гэхэд Эрчим хүчний хөгжлийн үндэсний төвийг энэ магадлалыг дуусга гээд ямар ч байсан зургийнх нь хувьд магадлалтай болно, төсвийг нь энэ 5 дугаар сардаа цуг хийгээд явж байгаа юм байна лээ. Магадлал хийгээд дууссан үед хэдий, ямар хямд үнэтэй байж байгаад яаж нэмэгдэх вэ гэдгийг бид нар 6 дугаар сарын дунд гэхэд тодорхой болгоно.

Энэ сэргээгдэх эрчим хүчийг ярих юм бол энэ 4 минутын хариулах горим дээр бол амжихгүй юм шиг байна. Мэдээж энэ

талаар Эрчим хүчний зохицуулах хорооны дарга Түвшинчулуун дарга та 5 минутад, 4 минутад багтаагаад сэргээгдэхийн талаарх бүх мэдээллүүдийг товчлоод бэлтгэж бай. Дараагийн удаа Их Хурлын даргаас микрофон аваад энийг ярья.

Эрдэнэбүрэний усан цахилгаан станцын талаар янз бүрийн асуудлууд бий. Сая 2 сарын 10-15-ны хооронд Хятад улсад би айлчлал хийсэн. Энэ үеэр “Экзим” банк төслийг гүйцэтгэж байгаа “Power China” компанийн төлөөлөлтэй уулзсан. 3 сарын 31-ний дотор Хятадын талаас Худалдааны яам “Экзим” банкнаас Төрийн зөвлөл дээр хүргүүлнэ. Хятадын талынхан бол магадгүй энэ 2023 оны 7, 8 дугаар сард Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас өндөр хэмжээний айлчлал, төрийн айлчлал хийх юм байна. Энэ үеэр амжуулж зээлийн тусгайлсан хэлэлцээрийг зурна гэдэг ийм баримжааг хэлж байгаа.

Манай зүгээс бол энэ наана нь Ерөнхий сайд Хятад улсад айлчлал хийх байх. Гадаад хэргийн сайд энэ талаар илүү нарийвчлал хэлэх байх. Энэ үеэр зээлийн тусгайлсан хэлэлцээрийг зуръя гэдэг ийм санал тавьчхаад л явж байгаа. 2023, 2024 ондоо багтаад Монголын талаас авч хэрэгжүүлэх бүх арга хэмжээг дуусгана. Тухайлбал тэр усан сан бүрэлдэх хэсэг дээр байгаа соёлын өвийг бол бид нар 2023, 2024 ондоо багтаагаад нүүлгэн шилжүүлэн, авран хамгаалах ажиллагааг бүрэн дуусгана. Иргэдэд өгөх 2 төрлийн нөхөн олговрыг 2023, 2024 онд бүр бүрэн дуусгана гээд Засгийн газрын тогтоол гарсан. 2024 оны төсөвт энэ шаардлагатай эх үүсвэрүүдийг бүгдийг нь суулга гэдэг даалгаврыг Сангийн сайд, Эрчим хүчний сайд бид хоёрт өгсөн. Ийм төлөвлөгөөтэй явж байна. Ямар ч байсан Монголын талаас төслийн бүх урьдчилсан бэлтгэл ажил 2024 ондоо бүрэн дуусна. Бид нар ямар нэгэн булхайгүйгээр Монголын талынхаа ажлыг хийе. Та нар ямар нэгэн шалтгаан хэлэхгүйгээр ингээд энэ ондоо энэ зээлийн

тусгайлсан хэлэлцээрийг байгуулаад ажлыг эрчимжүүлье гэдэг ийм л хамгийн сүүлийн ойлголцолтой байгаа.

Г.Занданшатар: Насантогтох, Түвшинчулуун Эрчим хүчний зохицуулах хорооны дарга. Хороон дарга нь мэддэг юм байна. 85.

Э.Түвшинчулуун: Эрчим хүчний зохицуулах хороо Түвшинчулуун. Энх-Амгалан гишүүний асуултад нэмэлт мэдээлэл өгье.

Ер нь сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрлийг Эрчим хүчний зохицуулах хороо 2007-2017 оны хооронд нийтдээ 38 тусгай зөвшөөрлийг олгосон байдаг. Салхины 7, нарны 31. Үүнээс 9 төсөл нь ашиглалтад орсон. 3 салхи, 6 нар. 18 төсөл бол хүчингүй болсон. Хугацаа нь дуусаад тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаанд ямар нэгэн ажил хийгдээгүй учраас 18 төсөл бол хүчингүй болсон байж байгаа.

Одоо 11 төслийг бол бид суурилагдсан хүчин чадлаас нь бууруулж Диспетчерийн үндэсний төвийн горим ажиллагаа яамтай бас зөвшилцсөн үндсэн дээр 11 төслийг бол бас хугацааг нь сунгасан. Энэ жил ихэнх нь бас дуусна.

Сэргээгдэх эрчим хүчний төслүүд дээр бол гол маргаантай байгаа асуудлууд бол энэ хөрөнгө оруулалт талдаа энэ тусгай зөвшөөрөл хүчинтэй хугацаанд бас хөрөнгө оруулалтаа олоогүй, төслийн талбар дээр ямар нэгэн ажил хийгдээгүй ийм шалтгаанаар бол бас тусгай зөвшөөрлүүдийг бол хүчингүй болгож байгаа. Одоо энэ тусгай зөвшөөрөл хүчингүй болсон 18 газраас одоогийн байдлаар 7 компаниас Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолыг хүчингүй болгох тал дээр шүүхэд хандсан. Үүнээс 5 компанийн нэхэмжлэлийг нь хэрэгсэхгүй болгож, 2 компанийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй шүүхийн шатдаа бол явж байна.

Энх-Амгалан гишүүний саяын асуусан тэр Сайншандын салхин паркийн асуудлыг ярьж байх шиг байна. Сайншандын салхин парк бол тарифаа 9.5 центээр батлуулсан. Энэ бол 2007 оны Сэргээгдэх эрчим хүчний хууль дээр нарны станцыг 15-18 цент, салхины станцыг 8-9.5 цент байна гээд ингээд шууд гадаад валютаар заачихсан байгаа учраас энэ дээр ямар нэгэн тарифын зохицуулалтад орж болохгүй. Ингээд шууд хууль дээрх үнээрээ яваад байгаа.

Сүүлд Сайншандын салхин паркаас зохицуулах хороонд санал ирүүлээд 185 сая киловатт цаг хүртэлх эрчим хүчээ 9.5 центээр, 185-190 сая киловатт цагийг 1.2 центээр нийлүүлэе гэсэн ийм санал ирүүлсэн. Бид энэ саналыг нь хүлээж аваад тарифт нь өөрчлөлт оруулаад явуулсан байгаа. Одоогоор Эрчим хүчний зохицуулах хороон дээр Сайншандын салхин парктэй холбоотой ямар нэгэн гомдол гэдэг юм уу, маргаантай асуудал байхгүй байгаа. Диспетчерийн үндэсний төв дээр эднүүс гэрээндээ өөрчлөлт оруулах талаар хэлэлцээрт орчихсон явж байгаа гэж мэдээлэх байна. Ер нь энэ нар, салхины станцуудын худалдах, худалдан авах гэрээг Диспетчерийн үндэсний төв, тухайн төсөл хөгжүүлэгч байгууллагуудтай хийдэг. Хариулт дууслаа.

Г.Занданшатар: Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Баярлалаа 2 асуулт байгаа юм. Сая бас Энх-Амгалан гишүүн хэллээ. Ерөөсөө л Улаанбаатараас алслагдах тусмаа ард иргэдийн орлого нь буурдаг, зардал нь нэмэгдэх хамгийн өндөр үнэтэй бараа бүтээгдэхүүн, хамгийн өндөр үнэтэй бензин, шатахуун, хамгийн өндөр үнэтэй эрчим хүч одоо энэ баруун аймгийнхан хэрэглэж байгаа юм. Тэгээд үүнийг шийдэх гээд л бид нар бас эрчим хүчний Эрдэнэбүрэний станц, цементийн үйлдвэр, малын гаралтай

түүхий эд боловсруулах үйлдвэр технологийн парк, зам харгуй барих гээд л яваад байгаа юм л даа.

Харамсалтай нь үүнийг эсэргүүцсэн хүмүүс их гарах юм. Сая Монгол Улсын Ерөнхийлөгч Эрдэнэбүрэний станцын төслийн барилга барих газар дээр очсоноос хойш хэсэг нөхдүүд Эрдэнэбүрэний станц ч буруу юм алга, муу юм алга, байгаль орчинд сөрөг нөлөөтэй, Ховд гол, Хар Ус нуур ширгэх нь, цөлжилт бий болох нь гээд яриад эхэллээ. Чойжилсүрэн сайд та бас өөрөө хамт очсон.

Гэтэл таны танилцуулга дээрээс харж байхад сая нар, салхины станцаас илүү усан цахилгаан станц хэрэгтэй. Дэлхий нийтээрээ усан цахилгаан станц илүү хэрэгтэй гэдгээ ойлгож байна. Дээрээс нь дулааны станцаас татгалзаж байна гэдэг асуудал ярьж байдаг. Сая бас танилцуулгад хэллээ л дээ та бас. Гадаргын болон гүний усны нөөцийг нэмэгдүүлнэ, байгаль орчны хувьд орчны чийгшил бий болно. Үүгээрээ бас усан цахилгаан станц Эрдэнэбүрэний станц их зөв юм байгаа юм гээд ярих юм. Тэгээд яг энэ байр суурь чинь зөв үү? Ард иргэдийн ойлголт жоохон өөр ойлголт байгаад байх юм. Энэ байгаль орчны үнэлгээ сайн хийсэн үү? Энэ дээр та бас надаа иргэдэд зөв мэдээлэл өгөөч? Тэгэхгүй бол тэгээд л ерөөсөө л Эрдэнэбүрэний усан цахилгаан станц Ховд гол ширгэнэ, Хар ус нуур алга болох нь, цөлжих нь гэдэг юм сүүлийн үед их явж эхэллээ дээ. Энэ дээр нэгдүгээрт нь хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь тэр нөхөн олговрын асуудал. Нөхөн олговор дээр бас иргэд бас нэлээн асуудалтай байгаа. Тухайн усан сан бүрэлдэх газарт бол гарцаа байхгүй нөхөн олговор олгох ёстой. Тэр Увс аймгийн иргэд, Баян-Өлгий аймгийн иргэдэд. Гэтэл станц барихтай холбоотойгоор тээвэр хийгдэнэ, тээвэр хийгдэхтэй холбоотойгоор түүр зам барина, түүр замын тоосжилт нэлээн

үүснэ. Үүнтэй холбоотой бас Эрдэнэбүрэн сумын иргэд бас тоосжилтын асуудал нэлээн ярьж байна лээ. Үнэхээр асуудалтай шүү.

Тийм болохоор бидэнд бас нөхөн олговор олгооч гэсэн. Тийм болохоор энэ тоосжилттой холбоотой гарцаа байхгүй энэ Эрдэнэбүрэний станц баригдах хүртэл хугацаанд энэ дээр бас нөхөн олговор хэрхэн, яаж олгох вэ энэ гэдэг асуудалд бас хариулж өгөөч. Тэгэхээр байгаль орчны үнэлгээ үнэхээр зөв, сайн хийгдэж чадсан уу? Дээрээс нь нөхөн олговрын асуудлыг дахиж бас ярих бололцоо байна уу. Гарцаа байхгүй бас нөхөн олговор олгох ёстой.

Одоо ингээд бичиж байна л даа. Цахилгааныг нарнаас, салхинаас гаргаж авч болдог. Тэгтэл заавал Эрдэнэбүрэний станцаас гаргаж яах гээд байгаа юм бэ гээд хүмүүс ингээд шүүмж хэлж байгаа юм. Усан цахилгаан станц барьж яах гээд байгаа юм гээд. Эдгээрт та бас иргэдийг бас нэг зөв мэдээлэлтэй, зөв ойлголттой болох, мэдээллийн зөрүүг алга болгох асуудлаар ярихгүй бол, та бүхэн бас энэ тал дээр цаашидаа нэлээн ажиллахгүй бол нэлээн тийм сөрөг хандлага бий болох нь. Ерөөсөө л юу гэдэг юм.

Г.Занданшатар: Чойжоо сайд 6 минут ярина.

Б.Чойжилсүрэн: Бямбацогт сайд энэ 5 өдөр Ерөнхийлөгчтэй цуг сая хэдхэн хоногийн өмнө ажиллаад ирсэн. Одоо цөлжинө гээд ингээд янз бүрийн юу яриад байгаа нь зүгээр улс төрийн юу юм байлгүй дээ. Энэ цөлжихгүй, эсрэгээрээ ус хуримтлагдана. Одоо энэ дээр надад хариулах юу алга. Улс төржүүлж байгаа юм байлгүй гэж л дүгнэхээс, хардахаас.

Нөхөн олговрын тухайд бол тэр усан сан бүрэлдэх газарт бол 270 өрх нөлөөлөлд автаж байгаа. Увс аймгийн Өмнөговь сум, Улиастайн талаасаа 125, Баян-Өлгий аймгийн Баяннуур сум

талаасаа бол Ховд голын баруун талаасаа бол 145 айл, нийтдээ 1241 иргэн энэ усан сан бүрэлдэх эсэхээс шалтгаалаад нөхөн олговор авч байгаа юм.

Энэ 270 өрх ер нь ерөнхийдөө энэ усан сан бүрдсэн тохиолдолд бол бүрэн нүүж явахаас аргагүй юм байна лээ. Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт хийгдэхээс аргагүй. Тийм учраас иргэн бүрд нь 15 сая 200 мянган төгрөг олох ийм шийдвэр Засгийн газраас гаргаад, Их Хурлаас чинь 4-ний 1 нь бол 23 оны төсөвт суучихсан, 4-ний 3-ыг нь бол 24-нд суулгана гээд сая Засгийн газрын тогтоол гаргачихсан ийм байдалтай.

Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум талаасаа бол тэгээд өөрийн чинь ярьж байгаа станц баригдах үед бол тодорхой хэмжээний тоосжилт үүсэхийг үгүйсгэхгүй. Иргэд нөхөн олговор өг гэсэн ийм хүсэлт тавьж байна лээ. Энэ асуудлуудыг бид нар юу эргэж судалъя, төслийн нэгжтэй бид нар төлөвлөгөө гаргаад ир гэсэн ийм асуудал ярьж байгаа. Мөн ялгаагүй тэр Увс аймгийн Өмнөговь сум, Баян-Өлгийн Баяннуур сум дээр бол бид нар дутуу орхигдсон байна, биднийг орхигдуулсан байна гэсэн ийм гомдол байгаа.

Тийм учраас тэр байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн энэ компани нь нэг бол дахин ондоо компани нэмэлт асуудлаар энэ маргаануудыг бид нар энэ 2, 3 дугаар улиралдаа багтааж цэгцэлж, нэг талд нь гаргаж дуусахаар ийм төлөвлөгөөтэй ажиллаж байгаа юм.

Нар, салхины станцын тухайд бол ойлгомжтой шүү дээ. Нар орохоор цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээ байна. Салхи зогсохоор цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээ байна. Ямар ч хэрэглэгч өнөөдөр нар орохоор юм уу, эсвэл салхи зогсохоор миний цахилгаан эрчим хүчний хэрэглээг хязгаарла, би цахилгаангүй сууж

байя гэдэг ийм зөвшөөрдөг хэрэглэгч алга байна. Тийм учраас нар, салхитай тэнцэх хэмжээний чадлыг хаа нэг газар нөөцөлж, захиалах шаардлагатай. Ус бол шаардлагатай давуу тал нь бол, усан цахилгаан станцын давуу тал бол хэрэглээ өсөнгүүт усаа нэмээд л, турбин нэмж ажиллаад л үйлдвэрлэх хүчин чадлаа бол маш богино хугацаанд маневрлах чадвартай. Нар, салхи, ус 3-ыг бол нэг ангилалд орохгүй.

Хэдийгээр бүгдээрээ сэргээгдэх боловчиг тохируулгын хувьд бол нүүрснээсээ ч илүү давуу чадалтай юм байгаа юм. Эрдэнэбүрэнийн усан цахилгаан станц орох юм бол магадгүй ямар ч Оросын Холбооны Улсаас болон Хятадаас ямар нэгэн тохируулгын функцгүйгээр бие даан ажиллах бололцоотой. Яагаад гэвэл хэрэглээ өссөн үед үйлдвэрлэх хүчин чадлаа нэмчихнэ, хэрэглээ буурсан үед үйлдвэрлэх хүчин чадлаа багасгана усаа л хаах энэ тохируулгыг нь давхар ийм давуу талтай.

Г.Занданишатар: Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууна. 1 минут.

С.Бямбацогт: Дулааны станц бол угаасаа нүүрс түлдэг учраас байгаль орчинд сөрөг нөлөөтэй нэгэнт ойлгомжтой. Дэлхий нийтээр татгалзаж байгаа. Сэргээгдэх эрчим хүчнээс нар, салхины талаар та үндсэндээ бол бас зүгээр жоохон усан цахилгаан станцаас сул талтайг бас нэлээн сайн тайлбарлачихлаа. Усан цахилгаан станцыг та харин бас илүү байгаль орчинд ээлтэй гэдэг тал дээр нэмэлт хариулт өгөөч.

Одоо ялангуяа баруун бүс нутагт Тайширын усан цахилгаан станц баригдсан, Дөргөний усан цахилгаан станц баригдсан. Энэ бүгдээрээ л асуудалгүй ажиллаж байна гэж би ойлгож байгаа. Энэ дээр үнэхээр давуу талтай нь юу байна, сул талтай нь юу

байна, байгаль орчинд болон ард иргэдэд тийм сөрөг зүйл байсан уу, байгаагүй юу? Энэ ямархуу байдаг юм? Энийг нэг хариулж өгөөч.

Яах аргагүй Эрдэнэбүрэний станц 1968 оноос хойш яригдсан, 50 гаруй жил яригдаж байгаа. 2014 онд энэ Эрдэнэбүрэнийн станц барих шийдвэр гарч байсан. 2018 онд Монгол Улсын Ерөнхийлөгч Ерөнхий сайд байхдаа санхүүжилтийн асуудлыг нь шийдэж байсан. Ингээд арай чүү тийм үү 50 гаруй жил яриад ингээд явж байгаа төслийг цааш нь ингээд явуулчих гээд ингээд оролдоод хөөцөлдөхөөр тэгээд дундаас нь ингээд гацаа, саад гарч ирээд байх юм. Энийг зөв.../минут дуусав./

Г.Занданишатар: Баттогтохын Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Бямбацогт сайд тантай манай Эрчим хүчний яамны бүрэн дүүрэн санал нэг байгаа юм. Зүгээр нэг зүйлийг нэмээд хэлэхэд усан цахилгаан станц ийм онцлогтой юм байна. Одоо энэ 271 орчим сая доллароор баригдаж байгаа юм энэ станц. Мянгад хүртэл цахилгаан эрчим хүчний шугамын хамт. Эхний 18, 19 жил 2045 он хүртэл гэсэн үг. Ашиглалтад орсноос хойш 18 жилийн дотор эрчим хүчний үнэ, тариф бол өндөрдүү явна. 7-8 центээр баруун бүс рүү нийлүүлнэ. Эхний хөрөнгө оруулалтаа нөхөөд дууссаны дараа бол урсгал зардал их багатай. Цаашид дахиад 80, 90 жил бараг 100 жил гээд бодох юм бол 80, 90 жилийн аягүй хямдхан цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх ийм бололцоо бүрдэнэ.

Хоёрдугаарт би сая хэлсэн тохируулгын функцээ хадгална. Өөрөөс нь гарах цахилгаан эрчим хүчний үнэ хөрөнгө оруулалтаа нөхсөний дараа 2045 орчим он.../минут дуусав./

Г.Занданишатар: Хөөш энэ Эрдэнэбүрэнгээ барихгүй бол тэр Баянхонгорын Байдрагийн гол дээр усан

цахилгаан станц барьчаач. Тийм. Хассуурийн Ганхуяг гишүүн. Нээрээ Байдрагийн голын усан цахилгаан станцын ТЭЗҮ юу болж байна? Тэрнийг нэг.

Х.Ганхуяг: Ер нь асуулга тавьсан бас асуулга дээр бас мэдээллүүд бас жоохон дутуу байна гэж харж байна. Яагаад тэгж байна гэхээр бол одоо бид нар чинь манай хамгийн хөгждөггүй яг байран дээрээ очоод гацчихсан салбар бол ялт ч үгүй эрчим хүчний салбар байгаад байгаа юм. Тэгээд л өвөл энэ утаа бол энэ манай эрчим хүчний салбарын байж байгаа байдал, нүүр царай л гэсэн үг.

Оросоос юмаа импортлоод байдаг Өмнөговьд нь бэлэн худалдан авагч нь байдаг цахилгаан станцаа барьж чаддаггүй. Тэгээд энэ Өмнөговийн цахилгаан станц бол нүүрсээр галлана гээд байдаг. Нүүрсээр галладаг цахилгаан станцын санхүүжилт дэлхий даяар өгөхөө больчихсон байгаа. Тэгсэн мөртөө манай энэ хөгжлийн зорилтуудад дандаа нүүрсээр галладаг цахилгаан станцууд орчихсон яваад байгаа байхгүй юу. Надад ирсэн асуулгын хариултууд дандаа л ихэнх нь нүүрсээр галладаг цахилгаан станцууд байгаад байгаа юм.

Тэгээд дэлхий дээр санхүүжилт нь байхгүй болчихоод байхад энэ юмнуудаа эргээж харах ер нь бодлого байна уу, байхгүй юу? Тэгээд энэ тендерт чинь 2 удаа зарласан гээд хүн ороогүй гэж байна. Тэн дээр яг тэрийг ер нь яах юм? Энэ Улаанбаатар хотын яг энэ дулааны асуудлыг хэрхэн яаж шийд гэж байгаа юм? Сайжруулсан түвшний технологийн горим алдагдсан гэж яригдаж байсан. Тэрийг яаж шийд гэж байгаа юм? 75 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа эрчим хүчний салбар. Тэгээд энэ ер нь цаашидаа яаж алдагдлыг бууруулах вэ гэхээр эрчим хүчний үнээ нэмэх гээд оруулаад ирж байгаа юм.

Гэтэл яг энэ танай энэ салбарын сэргээгдэх эрчим хүч буюу энэ нар, салхиар хангаж байгаа яг тэр хэсэг чинь 9.9-10 центийн хооронд байгаад байгаа байхгүй юу. Нүүрсээр галладагаас энэ чинь 3, 4 дахин үнэтэй гэж сая танай мэргэжилтэн хэллээ. Энэ яг нар, салхиар галладаг эрчим хүч өгдөг энэ технологи чинь дэлхий даяар нэлээн хямдарчихсан шүү дээ ер нь. Одоо ер нь бараг 2-4 центийн хооронд нийлүүлдэг эрчим хүч үйлдвэрлэх боломжтой болчихоод байгаа шүү дээ технологийн хувьд.

Яагаад гэхээр тэр тоног төхөөрөмж нь ч хямдарчихсан, тэгээд тэрнээс гаргаж байгаа нөгөө үр өгөөж нь ч нэмэгдчихсэн. Гэсэн мөртөө манайх ингээд хуулиараа ингээд аягүй өндөр үнэ тавьчихаад тэгсэн мөртөө энэ сэргээгдэх эрчим хүчний энэ компаниуд болохоор салбарын хувьд ноднин жил бараг 80-аад тэрбум ашигтай ажиллачихсан байгаа байхгүй юу. Үгүй яах вэ би тэр компаниудыг буруутгаад байгаа юм биш. Тэгээд энэ үнийн тарифаа ер нь хэзээ эргээж харах юм энэ чинь? Хүмүүсээс зүгээр ингээд л айл болгоноос, кармагаас нь сар болгон цахилгааныхаа төлбөр дээр нэмээд л авчихдаг. Энэ нөгөө цаг үетэйгээ хэзээ ер нь хамт алхаж явах вэ? Яагаад ингээд бид нар дандаа хоцорч яваад байна гэдэг нэг асуултууд байгаад байна л даа.

Тэгээд эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хэзээ, яаж хангах вэ гэдэг дээр нөгөө л нэг яриад байгаа тэр нүүрсэн цахилгаан станцуудын л.../минут дуусав./

Г.Занданшатар: Хассуурийн Ганхуяг гишүүн тодруулъя. Гүйцээж хариулъя гэж үү?

Х.Ганхуяг: Тэгээд энэ найдвартай ажиллагааны талаар бол энэ бүрэн эрчим хүчтэй хангах тал дээр ингээд цаашидаа бүүр энэ метан хий гээд манайд чинь замбараагүй их нөөц байдаг шүү дээ. Тэгээд энэ тал дээр ер нь ямар ажил хийгдэж байна? Тэгээд энэ уран энэ тэр

эд нараа ер нь ашиглах юм уу, ашиглахгүй юм уу? Яг одоо бол зүгээр бодитойгоор ингээд бид нар өмнөхөө харвал нүүрс угаасаа санхүүжилт байхгүй. Одоо хамгийн экологийн цэвэр эрчим хүч бол тэр метан хий болон тэр уранаас л гарахаар байна шүү дээ яг өнөөдрийн байдлаар.

Усан цахилгаан станцыг Оросууд явуулахгүй гэдэг нь тодорхой байна. Тэгээд бид нар чинь ингээд уран байна, метан хий байна, метан хий манайх хангалттай их нөөцтэй. Тэгсэн мөртөө энэ тал дээр ерөөсөө төсөл, хөтөлбөр энэ дотроо харагдахгүй байгаад байна л даа. Яах вэ судалж байгаа гэсэн л юм харагдаад байна л даа. Хариултаа авчихъя.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн. Хариулах нь Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Ганхуяг гишүүний асуултад хариулъя. Яг бодит байдлаа шулуухан ярьсан нь дээр байх. Одоо ингээд нар, салхи дэмжих гэхээр тохируулын функцгүй болчихоод дэмжиж чадахгүй байгаад байгаа байхгүй юу бид нар. Тийм учраас нүүрс рүү явж байгаа юм. Энэ Бөөрөлжүүтийн цахилгаан станцын тухайд бол Хятад улсын дарга Си Жиньпин дарга 21 оны намар НҮБ-ын тэр юу амлахаас өмнө Хятадууд санхүүжүүлээд эхэлчихсэн байгаа учраас Хятадын Хөгжил шинэтгэлийн хороо болон SINOSURE-оор нь бол дэмжигдээд гарчихсан 1 төсөл.

Хоёрдугаарт тэр Багануурын цахилгаан станцыг бас эхэлчихсэн байсан учраас 21 оноос өмнө эхэлчихсэн байсан учраас Хятадад SINOSURE-оор, Хөгжил шинэтгэлийн хороо 2-оор нь дэмжигдчихсэн байгаа 2 төсөл. Энэ 2 эх үүсвэр нь бүтэх учраас би ярьж байгаа юм.

Тавантолгойн цахилгаан станцын тухайд бол 30 хувийг нь бол “Эрдэнэс Тавантолгой” компани гаргана гэсэн ийм тогтоолын төсөл Их Хуралд оруулчихсан байгаа. 70 хувийг нь Ий Би Си дээр нэмэх нь Файнансинг гэдэг ийм хэлбэрээр санхүүжүүлъя. 400 орчим сая долларын санхүүгийн эх үүсвэрийг бол босгоод ороод ирэх бололцоотой гэсэн ийм хэд хэдэн компанитай бид нар. Би 8 сард уулзсан. 8 сарын 30-нд Эрчим хүчний сайдаар томилогдсоноос хойш энэ Тавантолгойн цахилгаан станцыг яаж явуулах вэ гэдгээр л хайгуул хийж яваад ерөнхийдөө боломжтой юм болов уу гэж бодоод ийм байдлаар зарлаж байгаа. Энэ Тавантолгойн цахилгаан станцын тухайд, нүүрсний станцын тухайд ярьж байна.

ТЭЦ-III -ын өргөтгөлийг бол Оросын Холбооны Улс бол энэ барууны улс орнуудын хоригт ороогүй, Киотогийн хэлэлцээрт ороогүй Хятадуудтай адилхан амлалт гаргаагүй учраас Оросын Холбооны Улсын Засгийн газрын экспортын зээлээр санхүүжүүлнэ гэсэн ийм хэлэлцээр явж байгаа юм. Энэ 4 станцын тухайд.

Энэ станцуудыг ашиглалтад оруулчих юм бол бид нар энэ ерөнхийдөө эрчим хүчний дутагдлаасаа гарна. Нэгэнт энэ микрофоныг ашиглаад та бүхэнд хэлье. 2022-23 оны өвлийн эд оргил ачааллыг бид нар эрчим хүчний салбарынхан ямар ч байсан амжилттай давлаа. Багахан шиг хязгаарлалт хийгээд. 23-24 оны өвлийн улирлыг бид нар бас давна. Бэлтгэл ажлаа бүгдийг нь хийж байна. Энийг давахын тулд энэ хэрэглээний өсөлтийг бид нар энэ Сонгино дээр барьж байгаа батарей сторэжээр шууд 80 мегаваттаар бид нар оргил ачаалалд 80 мегаваттаар оролцоно. 2.5 цаг энэ дээр том найдлага тавьж байгаа.

Мөн шаардлагатай тохиолдолд 1-2 жил Оюу толгойн шугамаар дамжуулаад Өвөр Монголын эрчим хүчний системээс

дутагдаж байгаа эх үүсвэрийг импортлохыг үгүйсгэхгүй. Ямар ч байсан импортлох эсэх нь бол тусдаа шийдье, импортлох шийдвэр гаргасан тохиолдолд техникийн хувьд бэлэн байя гэдэг ийм хэлэлцээрийг бид нар явуулж байгаа. Ингээд 23-24 оны өвлийн их ачааллыг бид нар нэгдүгээрт давна. 24-25 оны өвлийн их ачааллын үед Бөөрөлжүүтийн цахилгаан станцыг 300 мегаваттаар нь оруулж чадахгүй байг гэхэд 150 мегаваттыг нь ямар ч байсан 24 оны 4 дүгээр улиралдаа ашиглалтад оруулна гэсэн ийм төлөвлөгөөтэй. Тэгэхээр 25 оны 1 дүгээр улирал, 2 дугаар улиралдаа багтаагаад дахиад 1 турбинд залгагдах болов уу гээд.

Ер нь ерөнхийдөө энэнээс цаашаа бол манай өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ бид нар эх үүсвэрийн юугаа бид нар урд талд нь гарч амжина. Ийм л баримжаатай байгаа. Түүнээс энэ ер нь бүх дэлхий бол мэдээж байгаль орчиндоо хайргүй хэн байх вэ. Энэ нар, салхины цахилгаан станцыг гол асуудал энэ тохируулын функцгүйд байгаа юм.

Хоёрдугаарт одоо байгаа 2019 онд орсон Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд орсон өөрчлөлтөөр ямар нэгэн сэргээгдэх эрчим хүч шинээр зарлах юм бол уралдаан, тендер зарлана. Тендер зарласан тохиолдолд таны яриад байгаа магадгүй 2-4 центийн ийм үнэтэй нийлүүлэгдэх байх гэдэг нь ойлгомжтой байна. Одоо асуудал үүсгээд байгаа юм бол ашиглалтад орчихсон 9 станц байна. Нарны 6, салхины 3. Нэмэх нь тусгай зөвшөөрлөө авчихсан сая Түвшинчулуун даргын танилцуулдаг 3 салхи, 8 нарны станц байгаа юм. Эд нар тэр өндөр үнээр 2007 онд батлагдсан үнээр гэрээгээ хийчихсэн байгаа байхгүй юу.

Тийм учраас эхний ээлжид тохируулгыг нь ресурсгүй байгаа учраас бид нар хямдхан байсан ч энийг цахилгаан эрчим хүчинд холбоод хэрэглэгчийг найдвартай цахилгаан эрчим хүчээр холбож чадахгүй байгаа ийм тохируулгын

функцийн дутагдалд хос хүндрэл байгаа байхгүй юу. Санхүүгийн хүндрэлээс гадна, техникийн хүндрэл. Энэнээс шалтгаалаад ийм болж байгаа юм.

Тэгэхээр бидний нар, салхины станцыг дэмжих бололцоо хэдийд үүсэх вэ гэвэл эсвэл газаар түргэн маневрлах чадвартай газрын станц эсвэл усан цахилгаан станцууд, тухайлбал Эгийн голын усан цахилгаан станц. Энэ дээр Оросын Холбооны Улстай маргаантай байгаа.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Дамбын Батлутын урилгаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын Дэнж, Шанд, Даваат багийн залуучуудын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт залуучууд та бүхэндээ нутаг амьтай, орон нутгаа хөгжүүлж, чин сэтгэлээсээ зүтгэж байгаа та бүхний ажил үйлс өөдрөг бүтэмжтэй байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлье.

Коммент Пүүжээ гэдэг хүн. Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна.

О.Цогтгэрэл: Эрчим хүчний салбарын яг өнөөгийн бодит байдлыг нэг тоймлоод харвал жилээс жилд хэрэглээ нэмэгдсэн. Тэр тусмаа гадаадаас худалдаж авдаг хэмжээ гадаад улс орноос хамаарал, гадагшаа валют төлдөг нөхцөл байдал нь бүр ихэдчихсэн. Ер нь энэ өөрөө тийм үнэ, бодлогын хувьд зах зээлийн харилцаанд байтугай ойртоо ч үгүй, 30 жил улс төрийн арга хэрэгсэл болж явж ирсээр байгаад энд ямарваа нэгэн гадаадын хөрөнгө оруулалт байтугай ер нь бусад бизнесийн оролцоо байхгүй болчихсон, бүүр явсаар явсаар байгаад энэ нь зөвхөн нэг эрчим хүчний асуудал биш энэ Улаанбаатарт байгаа түгжэрэл, утаа эд нар чинь бүгд эрчим хүчний дутагдлаас гарч байгаа.

Уг нь хөгжлийг угааж хөгжлийг түрүүлээд чирч явах ёстой энэ эрчим хүчний салбар маань хөгжлийг боомилогч болоод хувирчихсан. Яг ийм л нөхцөл байдалтай салбар өнөөдөр зогсож байгаа. Ямар ч байсан гал алдахгүй явж байгаагаа бид нар гавьяа гэж тал талдаа боддог.

Гэтэл энэ чинь өөрөө хөгжлийг урагш нь чирч явах ёстой, угааж хөгжиж байх ёстой салбар. Бүүр нийгмийн олон асуудлуудынхаа эх суурь, яг эрчим хүчний энэ салбартай ингээд холбоотой болчихсон ийм л нөхцөл байдалд. Одоо яригдаж байгаа төслүүдийг яг харвал нөгөө алдарт V-дугаар цахилгаан станц нь сураг ч байхгүй, Тавантолгойн цахилгаан станц бид нарын улс төржилт олон зүйлээс болоод цаг алт. Тэр дахиад үнэ хувийнхан болоод бусад санхүүгийн байгууллагууд орох боломжгүй үнэ тавьж байна. Олон зүйлээр цаг алдсаар байгаад нүүрсний цахилгаан станцын санхүүжилт гэдэг зүйл нь байхгүй болчихсон.

Яг үнэндээ Эрдэнэбүрэний цахилгаан станц нь одоо явж байгаа ч юм шиг байгаа мөртөө яг санхүүжилт нь яг эцэслэж шийдэгдээгүй байдалтай. Энд ингээд гоё гоё эрчим хүчний удахгүй сайхан болчихно гэж байгаа мөртөө яг бодитой явж байгаа, бодитой хөдөлж байгаа төсөл тэр Бөөрөлжүүлт нь байгаа юм уу, үгүй юм уу? Ер нь бол ингээд ямар ч байсан улсаас хамааралтай зүйлс нь ор тас байхгүй нэг ийм л нөхцөл, бодит байдал ийм л байна.

Тэгээд гол нь тэгээд цаашидаа яг яах юм? Тэр их том либералчлал энэ тэр гээд үнэ чөлөөлөлт гээд супер супер юмыг ярихаа больё л доо. Зүгээр ойрын үед ер нь энэ зах зээлийн харилцаа болоод жам ёсны харилцаа руугаа болж өгвөл бизнесүүдийг татан оролцуулах, болж өгвөл гаднын хөрөнгө оруулалтыг авчрах энэ нөхцөл бололцоог ер нь юу гэж харж

байгаа юм бол? Тэр том либералчлал энэ тэрийг нь зүгээр больчихъё. Зүгээр л нэг өөрчлөлт яг ямар зүйлүүд энд харагдаж байгаа юм?

Хоёрдугаарт нь нүүрс дээр үнэхээр ийм төвөгтэй байдал үүсчхээд байх шиг байна. Уг нь бол улс орон даяараа ийм нүүрсний бассейнтай л ийм орон байдаг. Тэгээд нүүрсээрээ юм хийж чадахгүй байсаар байгаад ийм байдал руу орчихсон.

Тэр атомын цахилгаан цахилгаан станц гээд уг нь дэвшилтэт зүйл ингээд яригддаг. Атомын цөмийн энерги, манайд бас түүхий эд олон зүйлүүд нь бас зарим талаараа анхдагч хэлбэрээр ч гэсэн байдаг. Энэ дээр ер нь Эрчим хүчний яам цаашидаа бид нар.../минут дуусав./

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулъя. Атомын цахилгаан станц.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ихэнх нь санал байна. Энэ V-дугаар цахилгаан станцын тухайд бол Цогтгэрэл гишүүнээ ийм юм байна лээ. Хотоос зүүн тийшээ Хонхорын наад талд нэг газар авсан юм байна. Цахилгаан станц маань өөрөө хоёрхон төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа. Цахилгаан эрчим хүч, дулаан.

Энэ дулаанаа энэ 20 гаруй километр нааш татаад, дулаанаа борлуулах тийм трассгүй учраас ер нь ерөнхийдөө зогсчихсон юм байна лээ. Үндсэн шалтгаан нь. Тэгээд түүний дараа үе үеийн Эрчим хүчний яаман дээр ямар шийдвэр гарсан юм бэ гэвэл ТЭЦ-V гэхээсээ түрүүлээд ТЭЦ-III-аа өргөтгөчихъё. Одоо байгаа яг хэрэглэгчдээ эрэлттэй байгаа дулаан, цахилгааны хэрэглэлтэй байгаа хэрэглэгчдээ ойртъё гээд ТЭЦ-III-ыг 300 мегаваттаар өргөтгөө гэдэг ийм шийдвэр гараад явж байгаа. Би ч гэсэн Эрчим хүчний сайд болоод энэ ТЭЦ-V-ыг ямар учиртай, юу болсон талаар түүхийг

нь сөхөж үзсэн, газруудыг нь явж үзсэн. Би бас энэ удаадаа бол дэмжиж чадахгүй тэр ТЭЦ-V гэдэг хуучин сонгодог утгаар нь ийм байгаа юм.

Цаашидаа яах вэ гээд ингэхлээр шулуухан хэлэхэд тарифыг индексжүүлэхээс л ондоо аргагүй. Үнэ нэмэхгүйгээр энэ салбар руу хэн ч хөрөнгө хийхгүй. Хувийнхан орохгүй болохлоор дандаа төрийн нуруун дээр байна. Ийм л хүндрэлтэй байна. Одоо Улаанбаатар дулааны цахилгаан сүлжээний тухайд ийм байна шүү дээ. Яг системийн үед аваад үзэх юм бол 100 төгрөгөөр үйлдвэрлэхээд 42 төгрөгөөр зарж байна шүү дээ. Өртгийнх нь 42 төгрөгөөр. Улаанбаатарын дулааны хувьд. Энэ бол таны ярьж байгаа тэр 30 жил улс төржсөн энэний үр дүн мөн.

Бид нар өнгөрсөн жил 1 удаа тариф нэмэгдүүлсэн. Энэ удаадаа ямар ч байсан эхний 6 сар харъя гэж байгаа. 12 сарын дундаас бүрдэж эхэлсэн өнгөрсөн оны. Одоо ер нь эдийн засгийн нөхцөл байдал гайгүй болоод иргэдийн орлого нэмэгдээд 1 жил гарантаа явсны дараа энэ эрчим хүчний үнийг нэмэгдүүлэхгүй бол иргэдийн маань өөрийнх нь төлбөрийн чадвар их тийм бидний хүссэн хэмжээнд нэмэгдэж чадахгүй байгаа учраас ийм харзсан байдалтай л байгаа юм. Яг үнэндээ бол.

Наадмын цахилгаан станцын талаар бол манай улсад бол тийм хөгжөөсөн сайн туршлага гэх юм алга байна. Манай яаман дээр бол эдийн засгийн хүрээлэн эд нар дээр бол даалгавар өгчихсөн судалж байгаа. Нэг зүйл ойлгомжтой байгаа нь эхний хөрөнгө оруулалт бол өндөр юм байна, урсгал зардал бага юм байна. Нэг.

Хоёрдугаарт бид нар 100, 200, 300 мегаваттын 1 атомын цахилгаан станцтай болчихсон тохиолдолд бас ганц станц цөөхний зовлон манай улс жижиг улс байгаа. Энэ цахилгаан станцыг ганцхан станцыг яахын тулд нүсэр бүтэц

хэрэгтэй, удирдлагын чадавх бас хэрэгтэй юм байна лээ. Тийм учраас энэ судалгаа дууссаны дараа та хүсвэл бид нар бичгээр энэ судалгааны хариуг танд хүргүүлбэ. Атомын цахилгаан станцын дагуу.

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Та сая тэр дулааныг 100 төгрөгөөр үйлдвэрлээд 42 төгрөгөөр нь зарчих гэж байна л даа. Энэ үлдсэн зөрүүг нь яг хэн төлж байгаа юм бол? Тэр цахилгаан хэрэглэгчид нь магадгүй төлөх нь байна. Цахилгаан хэрэглэгчид нь жишээ нь айл өрхөөр харьцуулах юм бол орон сууцанд амьдарч байгаа арай чинээлэг айл өрхийг нь дулааны төлбөрийг гэр хорооллын орлого багатай айл өрх нь төлөөд л явах нь байна шүү дээ. Энэ тэгээд зөв бодлого уу? Жишээ нь энийг гэхэд ядаж тэр жам ёсонд нь л зүгээр оруулъя л даа. Орон сууцын айлын дулааны мөнгийг гэр хорооллын тэр орлого багатай айл төлөх нь байна.

Нөгөө талаасаа тэр тайлан дээр бас харагдаж байсан. Сэргээгдэх эрчим хүчийг нийт эрчим хүчний 9 хувийг нийлүүлээд 27 хувийн орлогыг нь буцааж авдаг гээд. Энэ тэгш бус энэ харилцаанууд чинь одоо яаралтай өөрчлөх л хэрэгтэй биш үү.

Гуравдугаарт нь тэр ер нь дэлхий нийтэд 1 хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ гэдэг ямар ойлголт байдаг юм? Манайх ер нь хаана явдаг юм? Хөгжил, дэвшилийн бас нэг үз.../минут дуусав./

Г.Занданшатар: Санал юм даа тээ. Тэгвэл Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цогтгэрэл гишүүн яг та зөв ярьж байна. Дулаан зохиомлоор доор бариад байна шүү дээ. Тэр алдагдлыг чинь цахилгаан эрчим хүчнээс хэсэгчлэн хааж байгаа юм. Тэгэхээр гэр хороололд

байгаа иргэд бол орон сууцад байгаа иргэдийн дулааны татаасанд оролцож байгаа нь шууд бусаар үнэн. Орон сууцад байгаа 50 метр квадрат орон сууцад амьдарч байгаа айл жилдээ 324 мянга орчим төгрөг төлж байгаа юм. 8 сар дулааны халаалтын төлбөр. Ийм 50 метр квадраттай хувийн орон сууцтай айл бол ойролцоогоос 3.5-4 тонн шахмал түлш хэрэглэж байгаа юм. Энэ нь ойролцоогоор 600 мянга орчим төгрөг болчих гээд байгаа юм. Тэгэхээр ийм зүйл бий. Тэгэхээр гэр хороололд байгаа иргэд нь орон сууцад байгаа иргэдээсээ орлогын хувьд илүү биш байгаа. Тэгэхээр орлого багатай иргэд нь илүү төлдөг, орлого ихтэй иргэд нь бага төлдөг.../минут дуусав./

Г.Занданшатар: Та бол 5 минут хариулж байгаа шүү дээ. Асуулт 3 минут, нэмэлт асуулт 1 минут. Хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байна. Ажлын хэсэг хариулах юм уу? Чойжилсүрэн сайд хариулъя. Чойжилсүрэн.

Б.Чойжилсүрэн: 1 хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр байна шүү дээ. Яг улс орнуудын хувьд бол яг тодорхойлсон, гаргасны албан ёсны статистик алга байна. Зүгээр өмнөд хөрштэй харьцуулахад 1 хүнд ноогдох цахилгаан эрчим хүчний хэрэглээ манайх Монгол Улсын хувьд 4.6 дахин бага байгаа. Хятад улс 2400 орчим гегаватт хүчин чадалтай, манайх 1.3 гегаватт хүчин чадалтай. Оросын Холбооны Улсаас мөн ялгаагүй 4 дахин бага цахилгаан эрчим хүчний хэрэглээтэй ийм байгаа. Тэр сэргээгдэх дээр чинь бид нар ингээд хамгийн үе үеийн Эрчим хүчний сайд нарын хамгийн толгойны өвчин, хүндрэлтэй сэдэв бол энэ.

2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийг баталчихсан юм байна лээ. Тэр хууль дээрээ ингээд яг ингээд тарифыг нь суулгаад баталчихсанаас шалтгаалаад энэ хөрөнгө оруулагч нар тэр үнэд баримжаалаад тэрэнд зориод

хөрөнгө оруулчихсан ийм байна. Одоо нэг талаас энэ хүмүүсийг бол энэ сэргээгдэх эрчим хүчний 9 эх үүсвэр ажиллаж байгаа. Эднийг буруутгах арга бас алга. Монголын төр өөрсдөө тухайн үедээ ийм нөхцөл байдалд орно гэдгээ тооцолгүйгээр ийм тарифуудыг баталчихсан байгаа байхгүй юу. 2007 онд.

Айлууд энийг яахын тулд айлууд дэмжих тариф хэлбэрээр төлөөд байгаа ийм шударга бус явдал бол байгаа нь үнэн. Гэхдээ энэ хүмүүсийг шууд буруутгаад огцом таслах асуудал бол байхгүй байгаа. Миний тухайд бол энэ сая Түвшинчулуун дарга ярьсан нийтдээ 38 сэргээгдэх эрчим хүчний тусгай зөвшөөрөл олгогдсоноос одоо яг хүчинтэй байгаа нь 20 байна. Энэ 20-оосоо 9 нь бол ажиллаж байна. 11 нь бол тусгай зөвшөөрлөө авчихсан, одоо ашиглалтад оруулах янз бүрийн шатдаа явж байгаа иймэрхүү байдалтай байгаа. Дахиад шинээр энэ 20-оос гадна 21 дэх тусгай зөвшөөрөл өгөх юм бол одоо байгаа хуулиараа бол сонгон шалгаруулалт зарлах ёстой ийм л байна.

Г.Занданшатар: Гүйцээгээд тэр Тавантолгой цахилгаан станцаа барихгүйгээс чинь болоод 120 сая доллар гадагшаа төлж байна шүү дээ. Ямар сонирхлоор энэ Тавантолгой цахилгаан станцаа барьдаггүй юм бэ гээд асуугаад байна шүү дээ. Тэрийг дараа нь хариулаарай.

А.Адъяасүрэн: Адъяасүрэн гишүүн. Би үндсэн 3 асуулт асууя. Ингээд энэ Баянхонгор аймгийн говийн сумд болох Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан сумууд төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон боловч сумын төвийн айл өрхүүд нь одоо бараг л лааны гэрлээс доор тог, цахилгаан муутай зутруухан амьдарсаар удаж байна. Эндээс би бас Баянцагаан сумыг онцолж яримаар байна. Манай Баянцагаан сум нийтдээ 4000 орчим хүн амтай. Сумынхаа төв дээр 500 гаруй өрхийн 2200 орчим хүмүүс ингээд амьдардаг ийм сум байгаа юм.

Тэгээд энэ Баянцагаан сум болохоор энэ Шинэжинст сумаас 15 миллиметрийн шугамаар 650 киловаттын хүчин чадлаар тог авдаг. Тэгээд Баянцагаан сумынхан маань байнгын ийм бас санал надад ирүүлдэг л дээ. Энэ нь болохоор зэрэг ерөөсөө тус сумын цахилгааны хэрэгцээгээ ерөөсөө хангаж чадахгүй байна. Эд ачаалалтай үе буюу 18-20 цагийн үед тог нь байнга тасардаг. Плитк дээр тавьсан хоол нь буцалдаггүй. Тэгсэн мөртөөсөө цахилгааных нь үнэ тариф нь маш өндөр байдаг гэж ийм асуудлуудыг тавьдаг.

Баянцагаан сумын бас нэг онцлог гэх юм бол энэ Эрдэнэт, Булганы цахилгаан дамжуулах сүлжээний хамгийн суулийн үзүүрийн шугам нь энэ сумд холбогддог. Мэргэжлийн хүмүүс яг газар дээр нь очоод ямар дүгнэлт хийдэг вэ гэхээр энэ Баянцагаан сумын цахилгааны хүчин чадлыг нь нэмэгдүүлэх шаардлагатай гэж удаа дараа ийм дүгнэлтүүд гарсан боловч ерөөсөө энэ арга хэмжээ авагдахгүй байгаа. Сум орон нутгийн удирдлагууд нь бол миний мэдэхийн сүүлийн 3 жил эрчим хүчний сайдуудад ингээд л хүсэлтүүдийг өгдөг. Тавинбэх сайдад хүсэлтүүд өгч байсан. Хамгийн сүүлд гэхэд сая 3 сард орон нутгийн удирдлагууд нь ирээд дэд сайдтай уулзаад явсан байсан. Бас Чойжилсүрэн сайдад бас ингээд санал тавьсан байгаа. Эд нар яг юу хүсээд байгаа юм гэхээр зэрэг үндсэн 2 л хүсэлт байдаг юм Чойжилсүрэн сайдаа. Нэгдүгээрт нь болохоор энэ Шинэжинстээс Баянцагаан сум дамжуулах хүчин чадлыгаа 1000 киловатт болгоод өгөөч гэдэг. Нэг дэх нь.

Хоёрт нь болохоор энэ Баянцагаан сумын төв дээр 2-оос доошгүй под станцыг нэмж барьж өгөөч гэдэг л ийм хүсэлтүүдийг удаа дараа тавьж байгаа. Гэхдээ бас яг газар дээрээ байдал хэвээрээ л байна. Энэ асуудал дээр ямар арга хэмжээ авах талаар маш тодорхой хариултыг өгнө гэж би найдаж байна.

Хоёрдугаарт нь бас нэг манай Баянхонгор дээр яригддаг нэг асуудал болохоор Байдрагийн голын усан цэнэгт болон усан цахилгаан станцын барих асуудал яригдаад нэлээд удаж байна. Миний сон.../минут дуусав./

Г.Занданшатар: Чойжилсүрэн сайд хариулъя. Байдрагийн усан цахилгаан станц. Тайширын цахилгаан станцтай хамт Зөвлөлтийн үед, социализмын үед урьдчилсан ТЭЗҮ нь хийгдэж байсан. Тайшир, Байдрагийн цахилгаан станц үр ашигтай гэж гарч байсан юм. Тэгээд Тайшир барьчихсан, Байдрагийг хаячихсан.

Б.Чойжилсүрэн: Адьясүрэн гишүүний асуултад хариулъя. Энэ танай аймгийн хэдэн сумууд бий. Хамгийн алсын сумуудыг та нэрлэж байна. Шинэжинст, Баян-Өндөр гээд. Эдгээр сумууд чинь бараг Эрдэнэтээс байна уу, Булганаас салаалаад явж байгаа 900 орчим километр урт сунаж байгаа юм. Тэгэхээрээ тухайн үед юу яг цэгцэлнэ гэдэг ч юм уу, аймаг дээр энэ асуудлыг шийдэгдэхээргүй юм байна лээ. Одоо нэг гаргалгаа бол манай Эрчим хүчний яаман дээр бид нар судалгаа хийгээд явж байна. Дэлхийн банкттай ч ярьж байгаа. Энэ бол эхний ээлжид Мандалговиос Арвайхээрийг холбочих юм бол цаашаа эдгээр сумууд дээр очих эрчим хүчний эх үүсвэрийн нөөц гарч ирнэ. Эс бөгөөс Улсын Их Хурлын даргын сая ярьж байгаа Байдрагийн гол дээр усан цахилгаан станц барих төслийг эхлүүлэх гэж. Энэ хувийн хэвшлийн хүмүүсийн төслийг хийгээд техник, эдийн засгийн үндэслэлийг хийгээд явж байгаа. Энэ талаар эрчим хүчний зохицуулах хороо нэмэлт мэдээлэл өгөх үү Түвшинчулуун дарга? 82 дугаар микрофон дарга ажлын хэсгийн.

Г.Занданшатар: Батмөнхийн Ерэн-Өлзий.

Б.Ерэн-Өлзий: Байдрагийн усан цахилгаан станц буюу энэ Байдраг гол дээр усан цахилгаан станц барих боломжтой байна гэсэн хэд хэдэн хувилбарууд байдаг. Энэ дээр үндэслээд Эрчим хүчний яамны захиалгаар 2022 онд Барилга, хот байгуулалтын яамны санхүүжилтээр техник эдийн засгийн үндэслэл боловсруулах тендер зарлаж, гүйцэтгэх шаардлага оруулж, гэрээ байгуулж ажил нь эхэлсэн. Одоо ТЭЗҮ, гэрээгээрээ энэ оны 6 дугаар сард албан ёсоор дуусгаж хүлээлгэж өгнө.

Г.Занданшатар: Байдрагийнх уу?

Б.Ерэн-Өлзий: Тийм Байдраг 6 сард ТЭЗҮ нь дуусна.

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүн.

Н.Наранбаатар: Даланзадгадын дулааны цахилгаан станцын асуудлын үйл ажиллагааг та бүхэн мэдэж байгаа байх. Одоог хүртэл энэ чинь 20 онд ашиглалтад орсон, 23 жил ажиллачхаж байгаа юм. Тэгээд ажилласан цагаасаа эхлээд л доголдолтой. Жил болгоны өвлийг л орон нутгаас нь, аймгаас нь хөрөнгө төсөв шийдэж засвар үйлчилгээг нь хариуцаж өнөөдрийг хүрсэн. Тэгээд цаашидаа ер нь явахад их хэцүү болчихоод байгаа. Энэ жилийн өвлийг арай гэж бас давсан. 1, 2 дугаар зуухны засварын хөрөнгийг нь орон нутгаас нь шийдэж байж нэг юм давсан. Одоо тулгарсан бас 2, 3 бэрхшээл байна. Энэ анх Солонгосын зээлээр баригдсан зээлийн үлдэгдэл нь станц дээрээ явж байдаг. Энийг Засгийн газрын зээл рүү шилжүүлэх ямар боломж байна вэ?

Хоёрт нь гэвэл энэ алдагдал нь ингээд жил жилд хуримтлагдаж яваад энэ нийгмийн даатгал бусад газруудад нэлээн хэмжээний өртэй болчихоод ажилчид нь өнөө зээл, хууль, хүүхдийн сургалтын төлбөр гэх мэтчилэн нийгмийн халамжийнхаа үйлчилгээг авч чадахаа байчихсан. Тэрнээсээ болоод боловсон

хүчний доголдол, дутагдалд орох ийм аюул нүүрлэсэн ийм байдалтай байна.

Гуравт нь гэвэл цаашидаа ер нь энэ чигээрээ энэ станц маань өсөн нэмэгдэж байгаа Даланзадгадын энэ хэрэглээг бол хангахгүй болчихоод байгаа юм. Тийм учраас цаашидаа нэг бол энэ станцын өргөтгөлийг шинээр барих асуудлыг шийдвэрлэх, аль эсвэл шинээр цахилгаан станц барих 50 хүртэл мегаваттын цахилгаан станцыг шинээр барих нэг ийм замууд байгаа юм. Тэгэхээр та бүхэн мэргэжлийн байгууллагын хувьд цаашидаа ер нь яаж энэ Даланзадгадын станцыг цаашиаа үйл ажиллагааг нь хэвийн болгох тал дээр ямар арга зам хэрэгжүүлбэл зүйтэй вэ гэдэг талаар бас та бүхний саналыг сонсьё.

Орон нутаг өөрийнхөө хөрөнгийг гаргаад 50 мегаваттын дулааны цахилгаан станцын ТЭЗҮ хийлгээд саяхан тэр гүйцэтгэгч компани нь танилчихсан одоо ингээд яамны шинжлэх ухаан техникийн зөвлөл рүү хүргүүлж байгаа юм байна лээ. Тэгээд энийг бас та бүхэн цаашидаа сайн судалж үзээд, ингээд дэмжээд явахыг бас хүсэж байгаа.

Хоёр дахь том асуудал бол манай аймгийн баруун 3 сумын цахилгаан эрчим хүчний асуудал байгаа. Ноён, Сэврэй, Гурвантэс сум Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас авч байгаа нэг компанийн уул уурхайн компанийн хөрөнгөөр тавьсан шугамаас авч байгаа тэгээд цахилгааны тасалдал бол маш их байдаг. Зовлон бэрхшээл тоочих юм бол олон байдаг.

Тийм учраас Даланзадгад Ноён чиглэлийн 220 километр цахилгаан дамжуулах шугамын хөрөнгө, төсвийг бас энэ ирэх жилийн энэ улсын төсөвт суулгаж өгөх ийм боломж байна уу гэсэн ийм хэдэн асуулт байна.

Г.Занданшатар: Сайд хариулъя. Чойжилсүрэн сайд хариулна.

Б.Чойжилсүрэн: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Энэ танай Даланзадгад дулааны станц үнэхээр их уул нь хоцрогдсон ийм яагаад ч тийм ийм юм барьчихдаг юм ийм хүндрэлтэй станц юм байна лээ. Ашигт үйлийн коэффициент байхгүй. Бараг буулгаад шинээр барьсан нь шулуухан юм байна лээ. Ийм байр суурьтай байгаа. Цахилгаан эрчим хүчний тухайд Тавантолгойн дулааны цахилгаан станц 300 мегаваттаар ороод дахиад хэрэглээ нэмэгдэх юм бол 450 болгохоор өгч байгаа учраас Өмнөговь аймгийн тухайд цахилгаан эрчим хүчийг шийдчихэж болох байх. Дулааных нь асуудлыг бол тусад нь дахиж шийдээд танай аймгийн төлөвлөгөөтэй уялдуулаад улсын төсвөөр хийх юм уу, орон нутгийн төсвөөр хийх юм уу гэдгээ эргэж харьцаая. Аймаг, яам 2 хоорондоо гэсэн үг.

Энэ Даланзадгадын дулааны станц дээр нийгмийн даатгалын шимтгэлийн өр, бусад өрнүүд гээд хүндрэлүүд бий. Энэ станц өөрөө ер нь энэ байгаагаар нь цаашид ажиллуулах нь утгагүй юм уу даа гэсэн ийм бодолтой байгаа. Орон нутагт 50 мегаваттын техник эдийн засгийн үндэслэл хийнэ гэж байгаа. Энийг манай яаман дээр ирсэн тохиолдолд бид нар ингээд дэмжих талаар нь бүрэн ажиллая.

Энэ баруун 3 сумын чинь тухайд бол энэ Баянсэврэй, Гурвантэс сум дээр сая өнгөрсөн 7 хоногт “Мак” компанийн захирал Нямтайшир захирал бид нар уулзсан. Тэднийх 30 мегаваттыг нь цахилгаан станц барья, тенхик эдийн засгийн үндэслэлийг хийе, хурдтай баталж өгөөрэй гэсэн. Дэмжье л гээд л гаргасан. Хариулж дууслаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Би энэ V-дугаар цахилгаан станцын санхүүжилтийн механизмыг гайхаад байна л даа. Яригдсан юм болов уу, үгүй

юм болов уу? Энэ мөнгөө босгох болохлоороо Хятадынх болохлоор байхгүй олон улсын санхүүжилт хэцүү нүүрснийх. Тэгээд ганц боломж нь юу байна вэ гээд тэгэхээр нөгөө Оюу толгойн ажлын хэсэг дээр ажиллаж байхад Оюу толгойн худалдан авах тэр гэрээг нь хийчихнэ. Тэр дээрээ үндэслээд мөнгөө босгоод явна гэсэн ийм байдлаар явж байсан санагдаад байх юм. Одоо тэгээд тэр маань хэвээрээ байна уу, үгүй байна уу?

Хоёрдугаарт нь нөгөө тодорхой эх үүсвэрийг нь болохлоор “Эрдэнэс Тавантолгой” компаниас гаргаад, үлдсэн мөнгөө босгоно гэж байсан. Тэгээд “Эрдэнэс Тавантолгой” толгой компани чинь сая оффтейк гэрээ гээд л баахан нууц гэрээнүүд ил болоод тэгээд энэ зарчмаар явахгүй юм байна гэдэг нь тодорхой болчихсон шүү дээ. Өөрөөр хэлэх юм бол нууцлаад оффтейк нүүрсээр хийх нь боломжгүй болчихлоо. Тэгэхээр санхүүжилт нь яах билээ? Ер нь тэгж явах ёсгүй шүү дээ. Энэ дээр та нар яг ямар байр суурьтай байгаа? Улсын төсөв дээр чинь мөнгө байхгүй, шинэ эх үүсвэр гаргана гэдэг Тавантолгой” цахилгаан станцыг ярьж байгаа юм. Том бүтээн байгуулалттай яриад байна л даа. Тэгэхээр санхүүжилтийн механизмын талаасаа яг ямар нэгэн шинэчлэгдсэн зүйл байна уу, байхгүй байна уу гэдгийг нь нэг асуучихмаар байх юм.

Тэр III-дугаар цахилгаан станцын өргөжилт гээд Оросын хойд хөршөөсөө мөнгө босгоод шинэчилгээ хийнэ гээд. Тэрний нөхцөл нь яг ямар байдлаар явж байгаа юм бол? Зээл авах гээд байна уу, аль эсвэл хувийн хөрөнгө оруулалт орох гээд байна уу, тэгээд үр өгөөжийнх нь үзүүлэлтээ санхүүгийнхээ үр ашгийг та нар яаж харж байгаа юм бэ гэдэг дээр нэг хариулт авчихмаар байна.

Сая ингээд орон нутгаар явж байхад энэ Ховдод тухайлбал цементийн үйлдвэр баригдчихжээ. Тэгээд машинууд очирлоод явж байна. Сайн байна. Гэтэл

байсхийгээд л тог нь тасраад байна л даа. Тэгээд цаашаага ийм байдалтай томоохон бүтээн байгуулалтууд тэнд явах юм их хэцүү юм байна даа л гэж харагдаж байсан. Тэгэхлээр энэ нөгөө баруун аймгуудын Эрдэнэбүрээний цахилгаан станц орохоос өмнө ямар байдлаар энэ хангамжаа шийдэх юм бэ гэж нэг асуучихмаар байна.

Гуравт нь энэ Говь-Алтайд яваад уулзалт хийж байсан чинь хөгийн юм болж байна. Арай гээд л хүмүүс цуглаад уулзалт хийх болсон чинь тогоо тасалчихдаг юм. Энэ чинь ямар сонин юм бэ гээд за тэгвэл гараад сайхан ингээд мэдээлэл өгье, live хийе гээд л дахиад л ингээд дахиад тог тасалчих юм. Тэгээд энэ ямар учиртай юм бэ гэсэн чинь тэр Говь-Алтайн түгээгүүрийн л нөхөр байдаг сурагтай байна. Тэгээд ерөөсөө сонгуулийн үеэр байнга тог тасалчихдаг, уулзалт хийхлээр тасалчихдаг, өөр намын хүмүүс ирэхлээр ингээд тасалчихдаг, тасалчихдаг тээ. Тэгээд нэг ийм нөхөр байна. Тэгээд хэтэрхий их улс төржсөн, Их Хурлын гишүүн ажлаа очоод тайлбарлаж байхад тасалчихдаг болохлоор энийг одоо яах вэ? Арга.../минут дуусав./

Г.Занданишатар: Говь-Алтай аймгийн Засаг дарга чинь аль намын хүн юм? Чойжилсүрэн сайд асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Доржханд гишүүний асуултад хариулъя. Тавантолгойн дулааны цахилгаан станцын талаар. Санаа зовж байгаа, ойлгож байгаа. Бүх талаасаа хавчхаж байгаа. Хятад улс хатуу түлшээр цахилгаан станц санхүүжүүлэхгүй гээд 21 онд амлачихсан, барууны улс орнууд санхүүжүүлэхгүй гээд амлачихсан, санхүүгийн байгууллагууд нь санхүүжүүлэхгүй гэсэн ийм хүнд нөхцөл байгаа юм.

Одоо бид нар “Эрдэнэс Тавантолгой” компани урьдын 2 зарлахдаа бүгдийг нь нүүрсээр оффтейк хийе гэсэн ийм төлөвлөгөөтэй байсан юм байна лээ. Одоо энэ оффтейкээр дийлэхгүй “Эрдэнэс Тавантогой” санхүүгийн мөнгөн урсгал дээрээ бол том дарамт авах учраас 30 хувийг нь 3 жилдээ хуваагаад “Эрдэнэс Тавантолгой” санхүүжүүлъя. 30 хувийг нь. Төслийн 70 хувийг Ий Би Си нэмэх нь финансинг гэдэг энэ хэлбэрээр олж ирээч гэдэг ийм тендер зарлаад үзье гэж ийм тогтоолын төсөл засагт оруулсан энэ 3 сарын 22-ны өдөр. Харамсалтай нь өнөөдрийг хүртэл Хэрэг эрхлэх газраас албажуулж өгдөггүй, тендерээ ч зарлаж чадахгүй ийм байна. Энэ хэлэлцүүлгийн дараа би бас дахиад холбогдох хүмүүстэй уулзах талаар явж байгаа юм.

Ер нь бол юу асуудал хүнд, бүх талаар бас хавчиж байгаа. Энэ шийдвэрүүд гарахаас өмнө уул нь барьчих ёстой байсан сэдэв л дээ. Ийм байна.

ТЭЦ-III-ын тухайд бол зээл авна. Экспортын зээл авна. “Интер РАО”-г Оросын Холбооны Улс талаасаа бол төслийн гүйцэтгэгчээр “Интер РАО”-г гэдэг компани байна гэдэг шалгаруулаад, урьдчилсан шийдвэрүүд гараад “Интер РАО”-компани өөрийнхөө хөрөнгөөр техник эдийн засгийн үндэслэлийг өнөөдрийн байдлаар хийчихсэн байна. Хэлэлцээр амжилттай болох юм бол “Интер РАО”-компани энэ төслийг цаашид хэрэгжүүлнэ. Зураг болон бусад нарийвчилсан Ий Би Си гэрээнүүд хийгдэхээр байгаа.

Яг өнөөдрийн байдлаар хэлэлцээр ид шатдаа явж байгаа учраас олон нийтэд нэг мэдээлэл өгөмгүй байна. 6 сарын дунд гэхэд бид нар хэлэлцээр нэг талдаа болох учраас танд нөхөж гишүүдийн чинь хувьд мэдээлэл өгье. Орж ирэлгүй яах вэ. Их Хурлаар оруулж таарна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулна. Гэхдээ хэлэлцээр явж байгаа учраас бас

нөгөө талаасаа ингээд олон нийтэд одоохондоо түр зарлахгүй байж байгаач, хэлэлцээрээ дуусгая гэдэг ийм байр суурьтай байгаа.

Энэ Эрдэнэбүрэнээс өмнө яах вэ гэдэг Эрдэнэбүрэнээс өмнө бол баруун бүсэд маань ялгаагүй цахилгаан эрчим хүчний хэрэглээ 6-7 хувь өсөлттэй байгаа сүүлийн жилүүдэд. Бид нар импортоор энэ өсөн нэмэгдэж байгаа хэрэглээгээ бол Эрдэнэбүрэний усан цахилгаан станц ашиглалтад ортол буюу бараг энэ чинь 2028, 2029 он хүртэл импортоо нэмээд л хугацаандаа бололцоо алга. Импортоо л нэм.

Говь-Алтайд тог тасалсан асуудлыг би анх удаа сонслоо. Энэ талаар бид нар судлаад юу болсон талаар эргэж танд мэдэгдэхээс. Одоо ямар нэг байдлаар юу байхгүй. Зүгээр Алтай, Улиастайн эрчим хүчний системийн одоо ажиллаж байгаа захирал нь бас Авлигатай тэмцэх газраас шалгагдаж байгаа. Тийм учраас саяхан энэ өнгөрсөн 7 хоногийн өмнө бид нар энэ хүнийг түдгэлзүүлээд манай Эрчим хүчний яамнаас бүрэн эрхтэй төлөөлөгч томилчихсон байгаа. Алтай, Улиастайд.

Г.Занданшатар: Тэр Тавантолгойн цахилгаан станц баригдаагүйгээс болоод 120 сая доллар гадагшаа шилжүүлж, валютын урсгалд сөргөөр нөлөөлж байна шүү дээ. Тэгээд энэ ямар шалтгаанаар тэгээд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдээд байхад чинь тэр тогтоол нь албаждаггүй, ямар санаатай ингээд байлгаад байдаг юм? Тэгээд энэ зун өнгөрвөл ингээд бүтээн байгуулалтын ажил ингээд өнгөрлөө. Тендер зарлах хугацаа ч өнгөрлөө. Ингээд тендер, маргаан гэвэл ингээд зун өнгөрөөд бүтэн жил алдаад. 1987 онд V-дугаар цахилгаан станцыг Багануурт барих шийдвэр 5 жилийн төлөвлөгөөнд тусгаж байсан байдаг юм.

Тэрнээс хойш V-дугаар цахилгаан станц барина гээд 36, 7 жил болж байна шүү дээ. 36, 7 жил тэгээд л V-дугаар цахилгаан станц барих гэхээр Тавантолгойн цахилгаан станц барина гээд л зогсоочихдог, Тавантолгойн цахилгаан станцаа болохоор Багануурын цахилгаан станц, Бөөрөлжүүтийн цахилгаан станц гээд солиод л. Энэ эрчим хүчний аюулгүй байдлын асуудал энэ санаатай байдаг юм уу, санамсаргүй байдаг юм уу энэ 30 жилд 3, 4 цахилгаан станц барьчих хугацаа ингээд үрэн таран болоод, тэгээд хамаг валютаа гадагшаа алдаад.

Тэгээд энэ ажлаа одоо эрчимжүүлмээр байна. Энийг Их Хурал энэ манай Доржханд гишүүн онцгой анхаараад шаардлага тавиад энэ асуудлаа явуулах хэрэгтэй. Сая ярьсан бас тэр Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан сумын Баянхонгорын тэр 3 сум чинь салхины станц байгуулсан байхгүй юу. Тэгээд тэр нь чанар муутай, аккумулятор байхгүй. Тэгээд түүнийгээ шийдэх хэрэгтэй байгаа. Тэр уул нь бол технологи сайжраад тэр Амарбуяантын хийдийн цахилгаан станцыг ч гэсэн сэргээгдэх эрчим хүчээр барьж болох юм байна гээд тооцоо гарсан. Тэрийг сайжруул.

Дараа нь Пүрэвдорж гишүүн дуу дуулж өгөөрэй гарч. Энэ Ховдын эмч нар бас байна шүү.

Байдрагийн усан цахилгаан станцын асуудал байна. Тэгээд энэ асуудлуудыг нэмэр болгох хэрэгтэй.

Зочид танилцуулъя. Энэ чинь зөвхөн асуулт, хариултын цаг болж байгаа болохоор эрчим хүчний асуудлаар сонирхсон гишүүд л оролцож байгаа юм.

“Эрүүл Монгол хүн” үндэсний чуулганд оролцож байгаа Баянхонгор, Ховд аймгийн сумдын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, эмч нар Улсын Их Хурлын

үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүн ардынхаа эрүүл энхийн манаанд цуцалтгүй хөдөлмөрлөж, давшингүй ажиллаж, КОВИД-ыг даван туулж, ард иргэдийнхээ эрүүл энхийн төлөө хөдөлмөрлөн зүтгэж байгаа эмч нартаа сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нартаа энэ сумдаа ажиллаж, нутаг орныхоо ард иргэдийн эрүүл мэндийн төлөө хүчин зүтгэж байгаа та бүхэнд Улсын Их Хурлын нэрийн өмнөөс болон хувиасаа халуун баяр хүргэж мэндчилгээ дэвшүүлье.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энд хүрэлцэн ирсэн “Эрүүл Монгол Хүн” хөтөлбөрийн улсын арга хэмжээнд оролцож байгаа нийт Ховдынхоо эмч нарт, мөн түүнчлэн Баянхонгор аймгийн эмч нартаа бүгдэд нь эрүүл энх, сайн сайхныг хүсэж, хүн амынхаа эрүүл мэндийн төлөө зүтгэж байгаа зүтгэлд нь улам их сайн амжилттай байхын ерөөлийг дэвшүүлье.

Энд хамгийн гол ярьж байгаа зүйл бол эрчим хүчний асуудал байгаа. Тэгэхээр эрүүл байна гэдэг утаанаас салах ёстой, эрүүл орчинд амьдрах ёстой. Тийм учраас Монгол Улс энэ дэлхий энэ ураны нөөцөөрөө дэлхийн 2 хувийг эзэмшдэг. Тун удахгүй 5 хувь руу хүрнэ. Тэгэхээр энэ ураны ордуудаа ашиглаад, одоо байгаа ордууд байгаа Мардайн орд байна. Тэрийгээ Орост өгөх хэрэгтэй. Эмээлт Майнзаар дамжуулаад нэлээн ордууд байж байгаа түүнийгээ Хятадууд тэн дээрээ ороод явна биз. Улаанбадрахын орд байна. Энэ дээрээ “Арева” буюу францууд ороод ингээд явна. Тэгээд цаашаа Америк, Англи буюу энэ Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн байнгын 5 оронд ер нь энэ эрх ашгийг нь хангаад өгчих хэрэгтэй. Тэгж байж бид нар энэ цаашаа атомын цахилгаан станцыг ашиглах энэ юм руу явна.

Тэгэхээр атомын цахилгаан станц барина гэх дээр л тийм цөмийн хаягдлын тухай ярьдаг. Тийм юм байхгүй шүү дээ. Энэ 2 хөрш чинь өөрсдийнхөө нутаг дэвсгэр цөмийн хаягдал тээвэрлүүлчихсэн явж байдаг тийм юу байдаг юм. Энэ бол гадаадынхны Монголд энэ эрчим хүчний хараат бус байх тэр бодлогын эсрэг л явуулж байгаа бодлого гэж ойлгож болно.

Тэгэхээр 1 килограмм цэвэр уранаар гаргаж байгаа эрчим хүч 1 сая килограмм эрчим хүчний нүүрснээс гаргаж байгаа эрчим хүчтэй тэнцэж байгаа байхгүй юу даа. 1 килограмм 1 сая тонн нүүрстэй. Тэгэхлээр ийм сайхан боломжийг бид нар өөрсдөө энэ ордтой байж байж ашиглаж чадахгүй байгаа нь харамсалтай байгаад байгаа юм.

1 доллар зарцуулаад 3 долларын ашиг олох энэ төсөл дээр бид нар өнөөдрийг хүртэл орохгүй ингээд байгаад байна гэдэг бол буруу гэж үзэж байгаа юм.

Тийм учраас Арева” бол ингээд “Орано” болчихсон. Тийм учраас хамгийн баталгаатай нөөц бараг ашиглалтад одоо ороход бэлэн болчихсон. Улаанбадрахын ордыг ашиглалтад оруулаад тэрнийхээ бүтээгдэхүүн хуваах гэрээгээрээ бид нар ядаж л 300 мегаваттын атомын цахилгаан станцтай болох хэрэгтэй байхгүй юу. Тэр чинь нэг портер дээр л багтана. Ийм их хөгжчихсөн юм. Юун утаа ерөөсөө сураг байхгүй. Эндээс нэлээн холхон, Улаанбаатараас нэлээн холхон бариад л тэндээсээ эрчим хүчээр Улаанбаатарыг тэр чигээр нь хангаад энэ хорт утаан дотор амьдарч байгаа тэр Монголчуудаа бүгдийг нь аврах ийм боломж байж байгаа шүү дээ. Энэ дээр одоо Засгийн газар яаралтай ажиллах хэрэгтэй. Тэгээд энэ ялангуяа тэр.../минут дуусав./

Г.Занданишатар: Дараа нь тодруулна. Хэн хариулах вэ? Тэр атомын цахилгаан станц, цөмийн хог хаягдал гэж худлаа шуугиад тэгээд атомын цахилгаан станц бариулдаггүй. Тэр “Арева”-гаар бол цахилгаан станц бариулчих ёстой юм байгаа шүү дээ.

Чойжилсүрэн сайд хариулъя.

Б.Чойжилсүрэн: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Атомын цахилгаан станц бол Монгол Улсын хувьд шинэ сэдэв. Нэлээн нухацтай судлах ёстой. Би Эрчим хүчний судалгааны хүрээлэнг судлаад танилцуул гэсэн байгаа. Би өөрөө энэ талаар бол сайн мэдээлэлтэй биш шүү. Тэгэхээр атомын цахилгаан станц энэ Францын Ерөнхийлөгч Монгол Улсад айлчлах ийм урьдчилсан мэдээлэл бий. Энэ талаар бол Засгийн газар, бид нар энэ үед бол тодорхой хэмжээний мэдээллүүд ярих байх.

Гэхдээ одоо ямар нэгэн байдлаар үр дүн гараагүй юмыг олон нийтэд тэгнэ, ингэнэ гэж гаргаж задлах нь ёс зүйгүй асуудал болоод байна. Судлаад танд эргээж мэдэгдье.

Г.Занданишатар: Пүрэвдорж гишүүн 1 минут тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Яг 20 хэдэн жилийн өмнө “Арева” компани одоо шинээр бол “Орано” компани Казахстан руу орсон, Казахстан ураны номер 5 тоглогч болчихсон явж байна. Монгол яасан хоцорсон хэвээрээ юу ч байхгүй.

Тэгэхээр одоо энэ 11 сар дотроо багтаагаад энэ “Орано”-гийн хөрөнгө оруулалтын гэрээг яаралтай батлаад тэгээд тэр ордыг цаашаа ашиглах тэр ажлуудыг хийгээд тэрнийхээ бүтээгдэхүүн хуваах гэрээгээрээ бас тодорхой хэмжээгээр энэ цахилгаан станцыг барих тэр асуудлыг шийдээд

явах ёстой байхгүй юу даа. Энэ дээр бол манай Засгийн газар зориг гаргаж чадна л гэж би харж байгаа. Хэрвээ та нар чадахгүй бол дараагийн үед бид нар энд хийх талаар ажиллана л гэсэн ийм бодолтой байна.

Г.Занданишатар: Тэгэхдээ энэ зөв зөв атомын цахилгаан станц. Ер нь энэ шинэ хот байгуулна гээд байгаа. Тэнд нүүрсний нөөц цаад талын тэр Өвөрхангайн нүүрсний уурхайгаас өөр нүүрсний цахилгаан станц, дулааны цахилгаан станц барих боломж байгаа байхгүй. Тэр нүүрсний орд нь тэнд л байгаа. Тэр чинь бүүр цаашаа 300, 400-гаад километр. Тэр чинь юу билээ нөгөө, тэгэхээр атомын цахилгаан станцаараа тэр ёстой хэлдгээр тэр жижиг хот 1 контейнер хүрэхгүй жижиг нөөцөөр л хот гэрэлтэнэ шүү дээ тээ. Тийм боломж судалж байгаа гэж би ойлгосон шүү дээ. Шинэ хот байгуулалт дээр.

Одоо ингээд гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо асуулга тавьсан Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг үг хэлнэ.

Х.Ганхуяг: Өнөөдөр мэдээлэл хүргэсэн ажлын хэсэг болон Эрчим хүчний сайд Чойжилсүрэнд талархал илэрхийлье.

Өнөөдөр бас энэ асуулгыг тавьсан гол шалтгаан юу вэ гэхээр үндсэндээ ялт ч үгүй эрчим хүчний салбар манай хөгжлийн саад, bottle neck гэж бас ярьдаг. Бид нар уул нь экспорт хийх гэхээр боомт дээрээ очоод гацдаг байсан бол дараад нь замаас болж гацдаг байсан. Одоо ингээд цаашидын томоохон хэмжээний бүтээн байгуулалт хийх, томоохон хэмжээний үйлдвэрлэл хөгжүүлэх, нэмүү өртөг бий болгоё гэхэд энэ эрчим хүчний салбар өөрөө хангаж дийлэх шинээр боломж эд нар бүрдэхгүй байна гэж харж байгаа.

Тэр хамгийн эх оронч бүтээн байгуулалт ялт ч үгүй эрчим хүчний салбарын бүтээн байгуулалт байх болно гэж харж байгаа юм. Тэгээд энэ ялт ч үгүй сая Их Хурлын дарга ч гэсэн хэллээ. Миний энэ асуулган дээр ч гэсэн явж байгаа асуудал юу юм гэхээр 33 жилийн хугацаанд хувийн хэвшлийн ганцхан цахилгаан станцаас өөр шинэ цахилгаан станц баригдсангүй. Хувийн хэвшлийн тэр 5 мегаватт билүү, 8 мегаватт билүү, тэр “Энержи Ресурс”-ийн барьсан цахилгаан станцаас өөр нэг ч бүтээн байгуулалт, нэг ч цахилгаан станц баригдсангүй.

Тэгээд энд үндсэн хэрэглээнийхээ 20 хувийг бид нар импортлоод байж байдаг. Энэ утаа нь шийдэгддэггүй. Тэгээд хавар болохоор утаагаа мартдаг. Бүтээн байгуулалт болохоор цахилгаан нь байхгүй. Нэг иймэрхүү л нөхцөл байдалтай бид нар энэ 32 жилийг өнгөрөөлөө. Хангалттай мөнгө байсан л байна. Бид нар жил болгон зөвхөн тэр Оюу толгойтой холбоотойгоор 120 сая долларыг алдаж байна. Эрчим хүчний хэрэглээнийхээ 20 хувийг бид нар гаднаас импортолж байна. Сэргээгдэх эрчим хүчийг дэлхийд байхгүй үнэтэйгээр бид нар сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж байна.

Тэгэхээрээ цаашидаа бид нар Чойжилсүрэн сайдад хэлэхэд бид нар энэ алтернатив эрчим хүчний салбаруудаа бас хөгжүүлэх тэр хийгээс цахилгаанаа гаргах, саяын Пүрэвдорж гишүүний ярьж байгаа тэр уранаар уран баяжуулж тэр атомын цахилгаан станцын төслүүдийг бас судалж үзэх. Тэгэхгүй л бол бид нар яг ялт ч үгүй ингээд таазандаа тулчихлаа даа. Тэгээд бид нар 33 жил явж ирлээ. Яг л ингээд цахилгаан станцын төслүүд хөдлөх гээд л ирдэг 2, 3, нэг бол хэдэн малчин очоод зогсоочихдог. Нэг бол 2, 3 хэвлэлийн бага хурал хийгээд л зогсоочихдог. Энэ бол бид нар бодит энэ

түүхийн гэрч болоод л үлдэж байна. Энэ цаг хугацаа хайран, харамсалтай ийм цаг хугацаа бас бид нарын ард өнгөрлөө.

Цаашидаа энэ салбарынхаа бүтээн байгуулалт, салбарынхаа хөгжлийг арай бас өөрөөр харахгүй бол зөвхөн нүүрс гэж хараад бид нар цаг хугацаанаасаа маш их алдаж байна гэдгийг бас анхаарах хэрэгтэй болов уу гэж бодож байна. Би энэ ажлын хэсгийн бас гишүүдэд хэлж байгаа юм.

Баярлалаа. Өнөөдөр бас яг энэ асуулгад идэвхтэй оролцсон бүх гишүүдээ бас талархал илэрхийлье. Баярлалаа Их Хурлын даргаа.

Г.Занданшатар: Ганхуяг гишүүн Эдийн засгийн байнгын хороонд энэ асуудлаараа бас яаралтай авах арга хэмжээний талаар тогтоол санаачилж чиг үүрэг өгч болно. Эрчим хүчний асуудал бол ер нь бараг хөгжлийн хамгийн хязгаарлагч хүчин зүйл. Дэлхий нийтийн ч гэсэн ер нь хамгийн том сорилтуудын нэг эрчим хүчний асуудал болж байна шүү дээ.

Ингээд Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуягаас Эрчим хүчний сайд сайдад хандаж тавьсан асуулгаа хариуг чуулганы нэгдсэн хуралдаанаар сонслоо.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

16.02 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

